



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



**ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД
ХИЙСЭН БАРИМТЫН СУДАЛГАА**

**УЛААНБААТАР
2014 ОН**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД**НЭГ. ТАЙЛАНГ БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН***Цэрэнхүүгийн Дулмаа*

Статистикч-Эдийн засагч
 Эдийн засгийн ухааны магистр
 ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын шинжээч

Жалавын Бумнанжид

Хуульч, Төрийн удирдлагын менежер
 Хууль зүйн магистр
 ОХУ-ын аюулгүй байдлын академийн профессор
 Цагдаагийн хурандаа

Болзоогийн Даваахүү

Эдийн засагч-Статистикч
 Эдийн засгийн ухааны магистр
 ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын гэрээт ажилтан

Цэвэгмидийн Арвинбуудай

Хуульч, мөрдөн байцаагч
 Хууль зүйн магистр
 Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл судалгааны төвийн дарга,
 Цагдаагийн хурандаа

Дуламсүрэнгийн Цэвээндулам

Эрх зүйч, философич
 Философийн ухааны магистр
 Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл судалгааны төвийн
 статистик мэдээллийн сангийн эрхлэгч, Цагдаагийн дэд
 хурандаа

ХОЁР. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН*Сономцэрэнгийн Мэндсайхан*

ҮСХ-ны дарга

Баатарын Эрдэнэсүрэн

Үйлдвэрийн инженер-Эдийн засагч
 Эдийн засгийн ухааны доктор, профессор
 ҮСХ-ны дэд дарга

Дандарын Оюунчимэг

Эдийн засагч-Статистикч
 Эдийн засгийн ухааны доктор
 ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БҮТЭЦ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	5
1.1 Судалгааны зорилго, мэдээлэл цуглуулалт	5
1.2 Судалгааны бүтэц	6
1.3 Ойлголт, тодорхойлолт	7
БҮЛЭГ 2. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	9
2.1 Гэмт хэргийн гаралтанд нөлөөлөх хүчин зүйлүүд	9
2.2 Бүртгээгдсэн гэмт хэргийн чиг хандлага	10
БҮЛЭГ 3. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН ТАЛААР МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН СУДАЛГААНУУДЫН ҮР ДҮНГЭЭС	20
3.1 Судалгаануудын нийтлэг байдал	21
3.2 Гэмт хэргийн хохирогчийн дүр төрх	22
3.3 Мэдэх эрх	23
3.4 Аюулгүй байдлаа хангуулах эрх	23
3.5 Зөрчигдсэн эрхээ нөхөн сэргээлгэх, хохирлоо арилгуулах эрх	24
3.6 Нийгмийн халамж, дэмжлэг тусалцаа авах эрх	26
БҮЛЭГ 4. ХОХИРОГЧИЙН ДҮР ТӨРХӨД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, хууль сахиулах байгууллагаар	27
4.1 Гэмт хэргийн хохирогч гэж хэн бэ?	27
4.2 Бүртгээгдсэн гэмт хэргийн хохирогчийн дүр төрх	27
4.3 Гэр бүлийн хүчирхийлэл бол орчин цагийн боолчлол мөн	49
4.4 Бүртгээгдсэн гэмт хэргийн хохирогчийн дүр төрх, гэмт хэргийн төрлөөр....	52
4.5 Гэмт хэргийн хохирогчийн дүр төрх (ШЕЗ)	54
4.6 Гэмт хэргийн хохирогчийн дүр төрх (ШШГЕГ)	87
БҮЛЭГ 5. ХОХИРЛЫГ БАРАГДУУЛЖ БУЙ ХЭЛБЭР, ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, хууль сахиулах байгууллага бүрээр	98
5.1 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт (ЦЕГ)	98
5.2 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт (ШЕЗ)	105
5.3 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт (ШШГЕГ)	108
5.4 Хохирлын нөхөн төлүүлэлт (УПЕГ)	111
5.5 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт (АТГ)	113
5.6 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, хууль сахиулах байгууллагаар	114
БҮЛЭГ 6. ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЧАНАР, УЯЛДАА, ХОЛБОО хууль сахиулах байгууллага бүрээр	116
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	123

ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 40/34 дүгээр шийдвэрээр "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал" батлагдсан нь дэлхийн улс орнуудад өөр өөрсдийн онцлогт тохирсон хохирогч судлалын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн гол үндэслэл болсон байна.

Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдлээс баттай хамгаалагдсан байх явдал юм.

Гэмт хэрэг бол өөрөө нийгмийн амьдралын сөрөг үр дагавар бөгөөд улс орны эдийн засаг доройтож ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, үнэ, инфляци өсөхийн хирээр гэмт хэргийн гаралт ч бас нэмэгдэж байдаг зүй тогтолтой. Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг өсөхийн хирээр гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн тоо ч нэмэгдсээр байна.

Үндэсний статистикийн хороо статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2014 онд гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох, аргачлал арга зүйг олон улсын жишигт нийцрүүлэх, гэмт хэргийн статистикийн мэдээллийн хоёр дахь эх үүсвэр болсон хохирогчийн судалгааг зохион байгуулж явуулахаар төлөвлөөд ажиллаж байна.

Энэ удаа хохирогчийн судалгааны эхний шат болох хохирогчтой холбоотой мэдээлэлд үндэслэсэн баримтын судалгааг явуулж, тайланг Та бүхэнд толилуулж байна.

Энэхүү баримтын судалгаа нь Эрүүгийн гэмт хэргийн хохирогчийн талаарх албан ёсны мэдээлэлд үндэслэсэн анхны судалгаа юм. Уг судалгаанд олон улсын хүний эрхийн гэрээ конвенц, НҮБ-ын тунхаглал зарчмуудыг үндэс болгон Монгол Улсад хүний эрх, түүний дотроос гэмт хэргийн хохирогчийн эрх ямар хэмжээнд хамгаалагдаж байдаг, хохирогчийн эрхийн хамгаалалт хууль эрх зүйн онолын хэмжээнд ямар хэмжээнд байгаа, практик амьдрал дээр гэмт хэргийн улмаас хохирсон иргэний эрхийг төрийн зүгээс хэрхэн хамгаалдаг, гэмт хэргийн хохирогчийн ямар төрлийн хохирлыг нөхөн төлүүлж байгаа, гэмт хэргийн статистикийн мэдээллийн дотор хохирогчтой холбоотой мэдээлэл ямар хэмжээнд байдаг, хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн статистикийн мэдээлэл цуглуулалтад хэрхэн оролцдог гэх мэтчлэн олон асуудалд хариулт өгөхийг зорьсон болно.

Хохирогчийн эрхийн асуудал нь хүний эрхийн асуудал бөгөөд дэлхийн олон орнууд хүний эрх, түүний дотроос хохирогчийн эрхийн асуудлыг эртнээс судлан иргэдийнхээ эрхийг хамгаалж ирсэн түүхтэй. Монгол Улсад ч хохирогчийн эрхийг хамгаалах, хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр Хууль зүйн яам болон Төрийн бус байгууллагуудаас хийсэн хорь гаруй судалгаа байна. Гэвч эдгээр судалгаануудад хохирогчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлд илүү анхаарчээ. Иймээс хохирогчийн талаарх албан ёсны мэдээлэлд үндэслэн үнэлэлт дүгнэлт өгөх зайлшгүй хэрэгцээ шаардлага бидэнд тулгарсан юм.

Хохирогчийн талаарх мэдээлэлд үндэслэсэн баримтын судалгааг явуулахад хамтран ажилласан Монгол Улсын Хууль зүйн яам, Улсын Прокурорын ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон энэхүү судалгааны мэдээллийн үндэс суурийг бүрдүүлж, сэтгэл, зүтгэл гарган, гар нийлж ажилласан Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, технологийн төвийн хамт олонд гүн талархалаа илэрхийлье.

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БҮТЭЦ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Үндэсний статистикийн хороо Статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн судалгааг явуулахаар төлөвлөн ажиллаж байна. Судалгааны эхний шатанд улсын хэмжээнд байгаа хохирогчтой холбоотой тоо, мэдээлэл болон хохирогчийн талаар хийсэн судалгааны мэдээлэлд үндэслэн Монгол Улс дахь Эрүүгийн гэмт хэргийн хохирогчийн дүр төрх, ямар төрлийн гэмт хэргийн улмаас иргэн, байгууллагад ямар хэлбэрийн хохирол учирдаг, түүнийг хэрхэн барагдуулдаг, хохирогчийн эрхийн хамгаалалт Монгол Улсад ямар хэмжээнд байгаа, ямар төрлийн хохирлыг барагдуулж байгаа, Хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн чанар, уялдаа, холбоо, үзүүлэлтийн оновчтой байдал, хохирогчийн эрхийг хамгаалах талаар хийгдэж буй тусламж үйлчилгээний талаар судлахыг зорилго. НҮБ-ын Гэмт хэрэг мансууруулах бодистой тэмцэх газар болон Европын эдийн засгийн комиссоос гаргасан Хохирогчийн судалгааны гарын авлагад өгүүлсэнчлэн “Хохирогчийн судалгаа” нь зөвхөн гэмт хэргийн хохирогчийн талаар судлаад зогсдоггүй, гэмт хэргийн чиг хандлага, төрлийг олон талаас нь нарийвчлан судалгаараа бусад судалгаануудаас ялгарах онцлогтой. Маш их өргөн хүрээтэй мэдээллийг хамардаг учраас судалгааны зорилго тодорхой байх ёстой байдаг. Энэ л жишгийн дагуу баримтын судалгааныхаа зорилгыг дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд:

- *Гэмт хэргийн хохирогч гэж хэн бэ?*
- *Монгол Улсад Эрүүгийн гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдал ямар хэмжээнд байгаа вэ?*
- *Эрүүгийн гэмт хэргийн улмаас хохирч буй иргэн, байгууллагын дүр төрх, учирч буй хохирол*
- *Хууль сахиулах байгууллагуудын аль шатанд нөхөн төлүүлэлт ямар хэмжээнд явагддаг вэ?*
- *Хохирогчийн эрхийг хамгаалах тусламж дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа*
- *Гэмт хэргийн статистикийн мэдээллийн чанар, уялдаа холбоо*

Дэлхийн олон орнууд гэмт хэргийн чиг хандлага, төрөл, хохирогчийн эрхийн хамгаалалт, хохирогчийн дүр төрхийг тодорхойлох, хохирлын нөхөн төлүүлэлт, хохирогчид тусламж дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа болон хууль эрх зүйн орчинг сайжруулах, зорилгоор олон судалгааг явуулж иржээ. Харин Монгол Улсын хувьд гэмт хэргийн чиг хандлага, хохирогч судлалын талаарх анхны албан ёсны судалгаа нь энэхүү хохирогчийн талаарх мэдээлэлд үндэслэсэн баримтын судалгаа болж байна.

Баримтын судалгаагаар Цагдаагийн ерөнхий газар, Улсын Прокурорын ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2007-2013 оны хохирогчтой холбоотой тоо, мэдээллийг цуглуулж, боловсруулсан болно.

1.2 СУДАЛГААНЫ БҮТЭЦ

Баримтын судалгааны тайлан нь зургаан бүлэг, дүгнэлт, зөвлөмж, хавсралтаас бүрдэнэ.

Нэгдүгээр бүлэгт- Судалгааны зорилго, мэдээлэл цуглуулалт, бүтэц, ойлголт, тодорхойлолтыг тусгав.

Хоёрдугаар бүлэгт– Бүртгэгдсэн гэмт хэргийн чиг хандлага, нөлөөлөх хүчин зүйлүүдийг тусгав.

Гуравдугаар бүлэгт - Хууль зүй яам болон төрийн бус байгууллагуудын гэмт хэргийн хохирогчийн талаар хийсэн судалгаануудын үр дүнг харьцуулан судлав.

Дөрөвдүгээр бүлэгт- Гэмт хэргээс хохирсон хохирогчийн дүр төрхийг Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2007-2013 оны захиргааны болон албан ёсны мэдээлэлд үндэслэн судлав.

Тавдугаар бүлэгт- Гэмт хэргийн улмаас иргэн, байгууллагад учирсан хохирол, түүний нөхөн төлүүлэлт, хохирлын хэлбэр, хохирол үүссэн шалтгааныг Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Прокурорын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2007-2013 оны захиргааны болон албан ёсны мэдээлэлд үндэслэн тусгав.

Зургаадугаар бүлэгт- Гэмт хэргийн статистикийн мэдээллийн чанар, уялдаа холбоо өнөөгийн түвшинд ямар байгааг тодорхойлохыг зорив.

Судалгааны төгсгөлд дүгнэлт, бодлогын зөвлөмжийг тусгав. Мөн гэмт хэргийн хохирогчийн шинж байдал, түүнд учирсан хохирол, хохирлын нөхөн төлүүлэлтийн талаарх гол гол үзүүлэлтийг хэрэглэгчдэд зориулан бүс, аймаг, нийслэл, дүүргээр боловсруулж хавсаргав.

1.3 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Гэмт хэргийн статистикт холбогдох ойлголт, тодорхойлолтуудыг Монгол Улсын Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомж, Олон улсын гэрээ конвенц, эрхийн актууд, НҮБ-ын хохирогчийн талаарх тунхаглал, зарчим, НҮБСК болон НҮБ-ын Гэмт хэрэг мансууруулах бодистой тэмцэх газар, Европын Эдийн засгийн комиссоос гаргасан гэмт хэргийн статистикийн гарын авлага, зөвлөмж, ангилалаас авч ашигласан болно.

№	Ойлголт	Тодорхойлолт
1	Гэмт хэрэг	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг (<i>Монгол Улсын Эрүүгийн хууль</i>)
2	Хохирогч	“Хохирогч” гэж гэмт хэрэг, эрх мэдлээ хортойгоор ашигласан болон хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийн улмаас бие эрхтэн, оюун сэтгэхүйн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, сэтгэл санааны зовлон шаналалд автсан, эд материалын хохирол хүлээсэн, үндсэн эрх, эрх чөлөө нь ноцтой зөрчигдсэн хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүсийг(<i>НҮБ-ын тунхаглал</i>)
3	Хохирол	Эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бие мах бодийн гэмтэл учирсан болон сэтгэл санааны дарамтанд орсон, эд хөрөнгийн хохирол учирсан, эсхүл үндсэн эрх нь зөрчигдсэн зэргийг (<i>НҮБ-ын тунхаглал</i>)
4	Нөхөн төлбөр	Хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн хир хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль, боловсролын түвшинг аль болох өмнө нь байсан хэмжээнд нь сэргээн бүрдүүлэхийг (<i>НҮБ-ын тунхаглал</i>)
5	Хохирогчийн эрх зүйн байдал	Иргэн нь эрх, эрх чөлөөгөө зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй (<i>Монгол Улсын Үндсэн хууль</i>)
6	Хохирогчийн үүрэг	Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн дуудснаар ирэх, хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх, өөрт илэрхий болсон хэргийн талаарх мэдээ сэлт задруулахгүй байх, шүүх хуралдаан болон байцаан шийтгэх ажиллагааны журмыг сахих (<i>Монгол Улсын Эрүүгийн хууль</i>)
7	Иргэний нэхэмжлэгч	Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэх буюу сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч (<i>Монгол Улсын Эрүүгийн хууль</i>)
8	Хохирол арилгуулах эрх	Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, сэтгэл санааны үр дагавраа арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших хийгээд бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй. (<i>Монгол Улсын Эрүүгийн хууль</i>)

9 Хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл	Иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсний улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана. (Монгол Улсын Эрүүгийн хууль)
10 Хуулийн этгээдэд хохирлыг нөхөн төлөх	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах болон прокурор, шүүхийн байгууллагын хууль бус ажиллагааны улмаас хуулийн этгээдэд учирсан хохирлыг төр хариуцна. (Монгол Улсын Эрүүгийн хууль)
11 Хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэл гаргах	Хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай өргөдлийг иргэн өөрөө буюу түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл тухайн иргэний итгэмжлэгдсэн төлөөлөгч, түүнчлэн өмгөөлөгч гаргаж болно. (Монгол Улсын Эрүүгийн хууль)
13 Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт 91-107-р зүйл анги буюу хүнийг санаатай алах, эхн нь нярай хүүхдээ алах, санаа сэтгэл нь хүчтэй цочирдон давчдсан үед бусдыг санаатай алах, бусдыг болгоомжгүй алах, бусдыг амиа хорлоход хүргэх, бусдын бие махбодид хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл учруулах, тарчлаах зүйл ангиудыг хамааруулна. (Монгол Улсын Эрүүгийн хууль)
14 Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг	Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэгт хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс зөвхөн бусдын биед учруулсан хохирлыг санаатай буюу болгоомжгүй байдлаар хүнд, хүндэвтэр, хөнгөн хэлбэрээр учруулсан гэмтлийг (Монгол Улсын Эрүүгийн хууль)
15 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21-р бүлэг-Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайрах, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодис буюу хордуулах цацраг идэвхт тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх, уулгалан довтлох, зандалчлах, терроризм, аюулгүй ажиллагааны журам зөрчих, нийтийн эмх замбараагүй байдал буй болгох зүйл ангиудыг (Монгол Улсын Эрүүгийн хууль)
16 Өмчлөх эрхийн эсрэг	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх, залилан мэхэлж авах, завших, үрэгдүүлэх, бусдын эд хөрөнгөнд болгоомжгүйгээр хохирол учруулах, бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх, өмчлөгчийн эрхийг зөрчих зэрэг зүйл ангиудыг (Монгол Улсын Эрүүгийн хууль)
17 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих, зам тээврийн ослын үед үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, согтуурсан буюу мансуурсан хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах, жолоогоо бусдад шилжүүлэх, төмөр зам, усан болон агаарын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон техник ашиглалтын журам зөрчих, агаарын хөлөг авч зугтаах, Олон улсын нислэгийн журам зөрчих, тээврийн хэрэгсэл, зам харилцааны төхөөрөмжийг эвдэх, гэмтээх зэрэг зүйл ангиудыг (Монгол Улсын Эрүүгийн хууль)

БҮЛЭГ 2. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1 Гэмт хэргийн гаралтанд нөлөөлөх хүчин зүйлүүд

Гэмт хэргийн гаралт, түүний хандлага, бүтэц, тархалт, гэмт хэрэг үйлдэгчдийн байдалд нөлөөлдөг үндсэн 3 хүчин зүйл байдаг:

- Эдийн засгийн хүчин зүйл
- Нийгмийн орчин
- Гэр бүлийн хүчин зүйл

Эдийн засгийн хүчин зүйлд санхүүгийн нөөцийн хомс байдал, ядуурал, боловсрол олж авах болон ажил эрхлэх боломж муу байх, орон сууцны нөхцөл муу байх, байгууллагын хариуцлага зэрэг олон зүйлүүд багтаж байдаг.

Нийгмийн орчны хүчин зүйлд гэр бүлд үзүүлэх дэмжлэг бага байх, хүүхэд, хувь хүний төлөвшилд анхаарал бага тавих, иргэдийн чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх орчин, нөхцөл муу зэрэг олон зүйлүүд багтдаг.

Гэр бүлийн хүчин зүйлд дараах зүйлүүд ордог. Үүнд:

- Эцэг, эхийн үл нийцэх байдал, хоорондын зөрчил
- Эцэг эх гэмт хэрэг үйлдэх, хэрэгт холбогдох
- Бие биеэ үл хүндэтгэх, хариуцлага хүлээхгүй байх
- Хүүхэдтэй зүй бусаар харьцах, хүчирхийлэх, хайхрахгүй байх
- Гэр бүлийн хүчирхийлэл

ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТАНД НӨЛӨӨЛДӨГ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД




2.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн чиг хандлага (ЦЕГ)

Гэмт хэрэг бол өөрөө нийгмийн амьдралын сөрөг үр дагавар бөгөөд эдийн засаг доройтож ажилгүйдэл, ядуурал нэмэгдэхэд гэмт хэрэг ч бас нэмэгдэж байдаг. Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг өсөхийн хирээр хохирогчийн тоо ч нэмэгдсээр байна.

Улсын хэмжээнд 2013 онд 25.4 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2000 оныхоос 1899 хэрэг буюу 8.1 хувь, 2005 оныхоос 7951 хэрэг буюу 45.7 хувь, 2007 оныхоос 4094 хэрэг буюу 19.2 хувь, 2012 оныхоос 3273 хэрэг буюу 14.8 хувиар нэмэгдсэн байна. (Зураг 2.2.1).


Зураг 2.2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, 1990-2013 он



Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо нэмэгдэж байгаа нь нэг талаас хэрэг бүртгэл сайжрах, сэжигтэн холбогдогч нь тогтоогдоогүй байсан хэрэг илрэх гэх мэт эерэг тал байвч нөгөө талаас нийгмийн тогтворгүй байдал, амьжиргааны түвшний доройтол, ажилгүйдлээс шалтгаалж гэмт хэргийн гаралт нэмэгдсэнтэй холбоотой. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хамгийн бага гэмт хэрэг бүртгэгдсэн жил 1990 он, хамгийн олон хэрэг бүртгэгдсэн жил 2013 он байна.

Зураг 2.2.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, сүүлийн 20 жилд



Улсын хэмжээнд 2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 14.9 хувь нь Төвийн бүсэд, 11.5 хувь нь Хангайн бүсэд, 6.1 хувь нь Баруун бүсэд, 5.9 хувь нь Зүүн бүсэд бүртгэгдсэн бөгөөд нийт гэмт хэргийн 60.8 хувь нь нийслэлд, 38.4 хувь нь аймгуудад,

0.4 хувь нь төмөр замын цагдаагийн хэлтэст, 0.3 хувь нь иргэний агаарын тээврийн салбарт, 0.1 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

2013 оны байдлаар бүртгэгдсэн 10 хэрэг тутмын 6 нь нийслэлд, 4 нь аймаг, орон нутагт, 2 нь аймгийн төвд, 3 нь согтуугаар үйлдэгдсэн, 1 нь эмэгтэйчүүд оролцсон гэмт хэрэг байна.

Бүртгэгдсэн 10 хэрэг тутмын 4 нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 3 нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байна. Өмчлөх эрхийн эсрэг 10 хэрэг тутмын 7 нь бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэг, 5 нь хувийн өмчийг хулгайлах хэрэг байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 45.4 хувийг хүндэвтэр, 45.9 хувийг хөнгөн, 7.0 хувийг хүнд, 1.7 хувийг онц хүнд хэрэг эзэлж, 2012 оныхоос хөнгөн хэргийн эзлэх хувь 2.3 пунктээр нэмэгдэж, онц хүнд хэргийнх 0.5 пункт, хүнд хэргийнх 1.7 пункт, хүндэвтэр хэргийнх 0.1 пунктээр буурав. (Хүснэгт 2.2.1)


Хүснэгт 2.2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, ангиллаар, 2007-2013 он

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Бүртгэгдсэн гэмт хэрэг	21 268	20 704	20 373	19 825	19 197	22 089	25 362
Гэмт хэргийн ангиллаар							
Хөнгөн	7 881	7 854	7 857	8 151	7 977	9 637	11 648
Хүндэвтэр	9 786	10 165	10 006	9 219	8 889	10 041	11 514
Хүнд	3 158	2 352	2 126	2 014	1 823	1 914	1 766
Онц хүнд	443	333	384	441	508	497	434

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Гэмт хэргийн өсөлт, бууралтыг 2012-2013 оны сараар авч үзэхэд, 2012 оны 1,3, 4,8, 9,10, 12-р сар, 2013 оны 1,4, 5, 7, 10, 12 - р саруудад өссөн дүнтэй, бусад саруудад буурсан байна. Эндээс үзэхэд жил бүрийн 1, 4, 10, 12-р саруудад гэмт хэрэг тогтмол нэмэгддэг байна (Зураг 2.2.3).


Зураг 2.2.3 Гэмт хэргийн өсөлт, бууралт, өмнөх сартай харьцуулсан хувиар, 2012-2013 он



Гэмт хэргийн илрүүлэлт гэдэг нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргээс гэмт хэрэг үйлдсэн эзнийг нь тогтоож ял сонгосон хэргийн хувийн жингээр тооцогддог чанарын үзүүлэлт юм.

2013 оны байдлаар гэмт хэргийн илрүүлэлт Завхан аймагт хамгийн бага, Хөвсгөл аймагт хамгийн өндөр байна. Гэмт хэргийн илрүүлэлт улсын дунджаар 58.5 хувь, нийслэлд 56.5 хувь, аймгуудад 41.1-84.1 хувьтай байна.

Зураг 2.2.4 Гэмт хэргийн илрүүлэлт, хувиар, 2013 он



Гэмт хэргийн илрүүлэлт 2013 онд нийслэлд өмнөх оныхоос 2.2 пунктээр буурахад Баянгол, Хан-Уул, Багануур дүүргүүдэд гэмт хэргийн илрүүлэлт 2.2-3.6 пунктээр буурсан нь голлон нөлөөлжээ. Бусад дүүргүүдэд гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдсэн байна.

Зураг 2.2.5 Гэмт хэргийн илрүүлэлт, дүүргээр, хувиар, 2013 он




Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ТӨРЛӨӨР

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл 2013 онд нийт гэмт хэрэгт Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 43.8 хувь, Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 32.2 хувь, Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 8.5 хувь, Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7.5 хувь, бусад гэмт хэрэг 8.0 хувийг эзэлж байна.

Зураг 2.2.6 Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрөл, дүнд эзлэх хувиар, 2012-2013 он




Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2013 онд 8156 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1001 буюу 14.0 хувиар нэмэгджээ. Энэ төрлийн гэмт хэрэг 2010 он хүртэл тасралтгүй өсч байснаа 2011 онд буурч, сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 92.7 хувийг бусдын биед гэмтэл учруулах гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 1.2 пунктээр нэмэгджээ. Бусдыг санаатай болон болгоомжгүй алах гэмт хэргийн энэ төрлийн хэрэгт эзлэх хувь буурсан байна.

Зураг 2.2.7 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 2004-2013 он




Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 57.3 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд Дархан-Уул (303), Төв (253), Сэлэнгэ (255), Баян-Өлгий(224), Орхон (218), Өвөрхангай (208), аймагт энэ төрлийн гэмт хэргийн гаралт бусад аймгийнхаас их байна. Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 85.1 хувь байгаа нь 2012 оныхоос 10.5 пунктээр нэмэгджээ.

Хүснэгт 2.2.2 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 2004-2013 он

Хэргийн төрөл	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	4 526	4 512	5 280	5 843	6 524	6 808	6 813	6 462	7 155	8 156
Үүнээс:										
Хүнийг санаатай алах	335	310	311	300	213	223	230	262	231	204
Бусдыг болгоомжгүй алах	19	16	15	14	23	16	15	21	14	21
Бусдын биед гэмтэл учруулах	2 846	2 991	3 584	4 614	5 319	5 770	5 821	5 838	6 546	7 564
Бусдыг амиа хорлоход хүргэх	1 293	1 167	1 340	888	945	764	727	314	324	323
Амиа хорлосон хүн	-	-	-	-	-	-	119	51	46	48
Золгүй явдлаас нас барсан	-	-	-	-	-	-	608	263	278	275
Бусад	33	28	30	27	24	35	20	27	40	44
Дүнд харьцуулсан хувь										
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:										
Хүнийг санаатай алах	7.4	6.9	5.9	5.1	3.3	3.3	3.4	4.1	3.2	2.5
Бусдыг болгоомжгүй алах	0.4	0.4	0.3	0.2	0.4	0.2	0.2	0.3	0.2	0.3
Бусдын биед гэмтэл учруулах	62.9	66.3	67.9	79.0	81.5	84.8	85.4	90.3	91.5	92.7
Бусдыг амиа хорлоход хүргэх	28.6	25.9	25.4	15.2	14.5	11.2	10.7	4.9	4.5	3.9
Амиа хорлосон хүн	-	-	-	-	-	-	16.4	16.2	14.2	14.9
Золгүй явдлаас нас барсан	-	-	-	-	-	-	83.6	83.8	85.8	85.1
Бусад	0.7	0.6	0.6	0.5	0.4	0.5	0.3	0.4	0.6	0.6

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар


Зураг 2.2.8 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг ба бусдын биед гэмтэл учруулах гэмт хэргийн харьцаа, 2004-2013 он



Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 2013 онд 11118 бүртгэгдэж, өмнөх оныхоос 2095 хэрэг буюу 23.2 хувиар өсөхөд энэ төрлийн гэмт хэргийн 70.9 хувийг эзэлж буй хулгайн хэрэг 1618-аар, халаасны хулгайн хэрэг 177-оор, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж, авах хэрэг 133-аар өссөн нь голлон нөлөөлжээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнд ордог дийлэнх төрлийн гэмт хэрэг сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай хэдий ч авто тээврийн хэрэгсэл хулгайлах хэрэг 21.5 хувиар буурсан байна. (Хүснэгт 2.2.3)

Зураг 2.2.9 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 2004-2013 он




Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 64.6 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд Төв (402), Дорнод (387), Дархан-Уул (288), Орхон (262), Хэнтий (207), Сэлэнгэ (205) аймагт энэ төрлийн гэмт хэргийн гаралт бусад аймгийнхаас их байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 51.8 хувь байгаа нь өмнөх оныхоос 0.2 пунктээр өсчээ.

Хүснэгт 2.2.3 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 2004-2013 он

Хэргийн төрөл	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Бүгд	10 138	8 896	8 847	10 865	9 489	8 853	7 944	7 232	9 023	11 118
Үүнээс:										
Хулгай	7 861	6 683	6 657	7 927	6 609	6 376	5 777	5 276	6 266	7 884
Булаалт	328	327	418	703	354	167	143	137	179	227
Дээрэм	655	584	455	656	818	754	520	536	552	620
Залилан	697	678	669	816	866	801	764	688	1 098	1 231
Завших, үрэгдүүлэх	338	371	341	357	331	348	337	202	269	326

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Зураг 2.2.10 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг ба хулгайн хэргийн харьцаа, 2004-2013 он




Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг

Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2013 онд 1894 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 145 хэрэг буюу 8.3 хувиар нэмэгджээ. 2013 онд бүртгэгдсэн нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 40.1 хувь нь бүртгэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй, 31.0 хувь нь ял сонгосон хэрэг байгаа ба энэ төрлийн хэргийн илрүүлэлт 77.4 хувьтай байна. 2013 онд бүртгэгдсэн нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 1839 буюу 97.1 хувь нь танхайн хэрэг байна. Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн илрүүлэлт 2013 онд улсын хэмжээнд 77.7 хувь байгаа нь өмнөх оныхоос 12.0 пунктээр өссөн байна.


Зураг 2.2.11 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 2004-2013 он



Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Танхайн гэмт хэрэг 2013 онд 1839 бүртгэгдсэн ба 2012 оныхоос 152 хэрэг буюу 9.0 хувиар нэмэгдэхэд энэ төрлийн гэмт хэргийн тоо Говь-Алтай аймагт 14 хэрэг буюу 2.3 дахин, Дархан-Уул аймагт 21 хэрэг буюу 75.0 хувь, Төв аймагт 10 хэрэг буюу 45.5 хувь, Булган аймагт 7 хэрэг буюу 2 дахин, Өмнөговь аймагт 9 хэрэг буюу 81.8 хувь, Улаанбаатар хотод 203 буюу 16.3 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

Зураг 2.2.12 Танхайрах гэмт хэрэг, 1990-2013 он




Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам (ТХХАБАЖ)-ын эсрэг гэмт хэрэг 2013 онд 2148 болж, өмнөх оныхоос 149 хэрэг буюу 7.5

хувиар өссөн байна. Энэ төрлийн гэмт хэргийн 56.4 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 66.1 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн гэмт хэрэг (ТХХАБАЖЗ), 31.7 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэрэг эзэлж байна.


Зураг 2.2.13 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг, 2006-2013 он



Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар


ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн 56.4 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд Төв (148), Дорноговь (77), Дархан-Уул (55), Сэлэнгэ (63), Өмнөговь (61) аймагт энэ төрлийн гэмт хэргийн гаралт бусад аймгийнхаас их байна. ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 78.5 хувь байгаа нь өмнөх оныхоос 6.1 пунктээр өсчээ.

Зураг 2.2.14 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг, 2006-2013 он



ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН БАЙДАЛ, ХУГАЦАА, ГАРАГ, ГАЗАР

Зураг 2.2.15 Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал, 2006-2013 он




2013 онд бүртгэгдсэн хэргийн 6406 буюу 25.3 хувь нь согтуугаар, 2447 буюу 9.6 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн, 418 буюу 1.6 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн байна. Согтуугаар үйлдэгдсэн хэрэг 2013 онд өмнөх оныхоос 1343 буюу 26.5 хувиар, эмэгтэйчүүд оролцсон хэрэг 399 буюу 14.5 хувь, хүүхэд оролцсон хэрэг 47 буюу 4.4 хувь, бүлэглэн гүйцэтгэсэн хэрэг 20 буюу 0.8 хувиар нэмэгдсэн байна.

2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 75.7 хувь нь ажлын өдөр, 24.3 хувь нь амралтын өдөр үйлдэгджээ. Нийт гэмт хэргийн 16.0 хувь нь даваа гарагт үйлдэгдсэн бөгөөд үүний 61.5 хувь нь нийслэлд, 38.5 хувь нь аймгуудад байна. Ажлын өдөрт үйлдэгдсэн нийт хэргийн 21.2 хувь нь Даваа гарагт үйлдэгдсэн байна.

2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх нь 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн байгаа бөгөөд энэ дүр зураг нийслэл, аймагт ижил байна. Улсын хэмжээгээр бүртгэгдсэн гэмт хэргийн 17.9 хувь нь 06-14 цагт, 25.2 хувь нь 14-19 цагт, 17.9 хувь нь 19-22 цагт, 39.0 хувь нь 22-06 цагийн хооронд үйлдэгджээ.

Зураг 2.2.16 Бүртгэгдсэн гэмт хэрэг үйлдэгдсэн цагаар, 2013 он



2013 онд Улаанбаатар хотод бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 36.7 хувь нь шөнийн 22 цагаас өглөөний 06 цагийн хооронд, 25.4 хувь нь 14-19 цагийн хооронд, 19.6 хувь нь 06-14 цагийн хооронд, 18.3 хувь нь 19-22 цагийн хооронд үйлдэгдсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 28.2 хувь нь гэр, орон сууцанд, 21.1 хувь нь гудамж, талбайд үйлдэгджээ.

Зураг 2.2.17 Бүртгээгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, 2013 он



Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

БҮЛЭГ 3. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН ТАЛААР МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН СУДАЛГААНУУДЫН ДҮГНЭЛТЭЭС

Энэ удаагийн баримтын судалгаагаар Монгол Улсын Хууль зүйн яам болон Төрийн бус байгууллагуудаас явуулсан гэмт хэргийн хохирогчийн эрхийн хамгаалалт, эрх зүйн орчинг сайжруулах талаарх 20 гаруй судалгаануудын материалыг цуглуулж, өмнө судлагдаж ирсэн байдал, өнөөгийн мөрдөгдөж буй Монгол Улсын хууль тогтоомжуудад гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах тогтолцоо ямар хэмжээнд байгааг тодорхойлохыг зорьсон болно.

3.1 Судалгаануудын нийтлэг байдал.

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, Нээлттэй Нийгэм Форум хамтран гэмт хэргийн хохирогчийн нийтлэг дүр төрхийг тодорхойлох зорилгоор "Гэмт хэргийн хохирогч", "Гэмт хэргийн хохирогчийн эрхийн хамгаалалтын байдал" судалгаануудыг явуулсан байна. Эдгээр судалгаануудад гэмт хэргийн хохирогчийн эрхийн хамгаалалтын НҮБ-ын зарчмууд болон олон улсын жишгийг МУ-ын хууль тогтоомжтой харьцуулан шинжлэх, гэмт хэргийн хохирогчийн өнөөгийн дүр зураг, хохирогчийн эрхийн хамгаалалтын хэрэгцээ шаардлага, эрхийн хэрэгжилтийн талаарх хохирогчийн сэтгэл ханамж, хохирогчид үзүүлж байгаа тусламж үйлчилгээ, хохирогчид тулгарч буй бэрхшээл болон цаашид хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлох зорилго тавин ажиллажээ.

Мөн хохирогчийн сэтгэл ханамжийг харьцуулах үүднээс судалгаанд хамрагдсан хохирогчийг хуулийн байгууллагад хандаад байгаа, хуулийн байгууллагад хандаагүй, хэрэг шийдвэрлэгдсэн гэж 3 түвшинд авч үзэхийн зэрэгцээ олон улсын стандартын дагуу хохирогчийн хэрэгцээ шаардлагыг нэн түрүүнд илэрхийлэх эрхүүдийн хүрээнд Монгол улсын хууль тогтоомж болон түүний хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийхэд чиглэгджээ.

Гэмт хэргийн хохирогчийн эрхийн хамгаалалтын түвшинд Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын эрх зүйн баримт бичиг, гадаад улс орнуудын хууль тогтоомж, практик алхамууд болон виктимологийн шинжлэх ухааны бүтээлүүдийг хамруулсан онолын судалгаа, гэмт хэргийн хохирогч, хуулийн байгууллагын ажилтнуудыг хамруулсан тоон ба чанарын судалгааны үр дүн болон хавтаст хэргийн материалд хийсэн дүн шинжилгээ буюу эмпирик судалгааны үр дүнд дараах дүгнэлтэд хүрсэн байна. Үүнд:

Монгол Улсын хууль тогтоомжид гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдал нь олон улсын стандартад зарим талаар ойртож очсон боловч, ихэвчлэн тунхаглалын шинжтэй, хохирогчийн зарим эрхийг хэрэгжүүлэх механизм, зохион байгуулалт, эдийн засгийн баталгаа, бааз, суурь байхгүйн улмаас хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн хэвээр байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэх, нийгэмд дасан зохицох бодит хэрэгцээг үл хайхран олон жилийн турш "Гэмт хэрэгтэй тэмцэх" төрийн бодлогын хүрээнд хохирогчийг гэмт хэрэгтний гэм бурууг "нотлох баримт"-ын эх сурвалж гэж үзэж ирсэн байна.

Хохирогчийн байцаан шийтгэх ажиллагааны эрх нь иргэн хүний үндсэн эрхийн хувьд Үндсэн хуульд бүрэн тодорхой бэхжигдсэн боловч, бусад хууль тогтоомжид нарийвчлагдаж чадаагүй байна. Олон улсын эрх зүйн стандарт, үндсэн зарчмуудтай харьцуулан үзэхэд гэмт хэргийн хохирогч нь нийгмийн халамж тусламж авах, мэдээлэл авах эрх, хохирогчийн аюулгүй байдлаа хамгаалуулах эрх нь тодорхой тусгагдаагүйгээс гадна төрөөс нөхөн төлбөр авах, нөхөн олговор олгох асуудал олон улсын жишгээс хол хоцорчээ.

Хуульд хохирогчийн байцаан шийтгэх ажиллагааны эрхийг нилээд дэлгэрэнгүй хуульчилсан боловч, тэдгээрийн олонхийг өөрөө чөлөөтэй ашиглах боломж олгоогүй, эдгээр эрх нь мөн үүргийн шинж чанарыг давхар илэрхийлсэн байна. Тухайлбал: хохирогчийн нотлох, зөрчигдсэн эрхээ нөхөн сэргээлгэх эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд туслах шинжтэй үүрэг болон хувирсан нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох түүний эрхийн агуулга зөрчигдөхөд хүргэж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хохирогч нь байцаан шийтгэх ажиллагааны гурван статустай /иргэний нэхэмжлэгч, гэрч, хохирогч/ оролцож байгаа боловч, түүний эрх, үүрэг нь зөвхөн сэжигтний түвшинд л хуульчлагдсан нь хохирогч байцаан шийтгэх ажиллагааны бүх үе шатанд идэвхтэй оролцох, түүнийг түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох буюу дуусгах хүртэл мөрдөн шалгах ажиллагаанд нөлөөлөх боломжоор хязгаарлагдмал байдлаар илэрч байна.

Хохирогч гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, санаа сэтгэлээр хохирохын зэрэгцээ, төрийн албан тушаалтны хайрамжгүй байдал, хүнд суртал, гэмт хэрэгтэн, түүний хамсаатнаас айж эмээх, айлган сүрдүүлэлтэнд автах улмаар гэмт хэргийн талаар мэдүүлэг, мэдээлэл өгөхөөс татгалзсан, худал мэдүүлэг өгсөний төлөө гэмт хэрэгтэн болон хувирах давхар дарамтанд өртөх явдал байна.

Эрүүгийн хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын болон шүүн таслах шатанд оролцсон гэрч, хохирогч, бусад оролцогчийн аюулгүй байдлыг хамгаалах талаар нэгдсэн хууль тогтоомж байхгүй, эрх зүйн зохицуулалт, хамгаалалт дутагдсанаас хуулийн зарим байгууллагууд өөрсдийн үзэмж, дотоод журмаар шийдэж байна.

3.2 Гэмт хэргийн хохирогчийн дүр төрх

“Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн хамгаалалтын байдал” тоон болон чанарын судалгаа, Хавтаст хэргийн судалгааны үр дүнгээр өнөөдөр хохирогчийн өргөдөл гомдлыг түргэн шуурхай хүлээн авч, шийдвэрлэх, хохирогчийн бие махбод, эд хөрөнгө, сэтгэл санааны хор хохирлыг арилгах, аюулгүй байдлыг хангах улмаар хохирогчид нийгэм сэтгэл зүй, нийгмийн халамж, хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхийг хамгийн их хүсч байгааг онцолсон байна. Тухайлбал: Судалгаанд хамрагдсан хоёр хохирогч тутмын нэг нь хохирлоо барагдуулахыг, гурван хохирогч тутмын нэг нь өргөдөл гомдолд шуурхай хариу өгч, шийдвэрлэхийг санал болгосон байна. Гэтэл хохирогчийн өргөдөл гомдлыг удаах, өргөдөл гомдлын мөрөөр авсан арга хэмжээ нь тодорхойгүй, шийдвэрлэсэн талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй, өөрөөр хэлбэл хохирогчийн зүгээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх талаар хуулийн байгууллагуудаас ихээхэн хойрго хандаж байгаа явдал нь хуулийн байгууллагад хохирогчийн итгэх итгэлийг сулруулж, хуулийн байгууллагад хандаж асуудлаа шийдвэрлүүлэх итгэл үнэмшлийг бууруулж байна. Судалгаанд хамрагдсан хоёр хохирогч тутмын нэг нь хуулийн аль нэг байгууллагад хандсанаар асуудлаа шийдвэрлүүлэх итгэл найдвар байхгүй байна гэж үзсэнийг үндэс болгожээ.

Мөн хохирогч хуулийн байгууллагад сэтгэл дундуур байгаагийн шалтгааныг хохирогчийг залхаадаг, олон дахин явуулдаг, байнга дууддаг, хүлээлгэдэг, хүнд суртал гаргадаг, шат дамжлага ихтэй, соёлгүй харьцдагаас гадна хуулийн байгууллагын ажилтнууд шударга бус ханддаг, хохирогчийг хэргээ өөрөө нотлохыг шаарддаг, авилгал шан харамж хардаг, хохирогчийг буруутгаж харьцдаг, танил талаа харж асуудлыг шийдэж байгаатай холбон тайлбарласан байна. Нөгөө талаас хуулийн байгууллагын ажилтнуудад хэргийн ээдрээ төвөгтэй байдал, ажлын ачаалал зэрэг хүндрэл байгаа нь байцаан шийтгэх үйл ажиллагааг удаашруулахад нөлөөлж энэ нь хохирогчид таагүй сэтгэгдэл төрүүлж байна.

Дээр дурьдсанчлан хохирогчийн хамгийн их хүсэн хүлээж буй асуудлын нэг болох хохирол барагдуулалт ямар түвшинд байгааг хэд хэдэн эх үүсвэрээр судалж үзэхэд хохирогч нарын бараг тал хувь нь хохирол барагдуулаагүй гэж үзсэн бөгөөд үүний шалтгааныг хуулинд хохирол барагдуулах талаар тодорхой заалт байхгүй, хохирол барагдуулах тогтолцоо бүрэлдээгүй, хохирол барагдуулах талаар хуулийн байгууллагын ажилтнууд санаачлагагүй ханддаг, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч төлбөрийн чадваргүй, сэтгэл санааны хохирлыг үнэлж чадахгүй байгаа зэрэгтэй холбон авч үзсэн байна.

Хуулийн байгууллагын ажилтнуудын 65 хувь нь одоогийн хууль тогтоомжийн хүрээнд хохирогчийн эрх ашгийг хангаж ажиллах боломжгүй байна гэж үзэхдээ хохирол барагдуулах тогтолцоо бүрдээгүй, хохирогчийн эрхийг хамгаалсан хуулийн заалт байдаг ч хэрэгждэггүй, хуульд хохирогчийн эрхийг хамгаалах хангалттай заалт зохицуулалт хомс, хохирогчийн аюулгүй байдлыг хангаж чаддаггүй, хуульчдын хохирогчдод хандах хандлага төлөвшөөгүй, үл тоомсорлодог, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээний талаар хуульд ямар нэгэн заалт байхгүй, хуульчид хуулийн заалтыг нэг мөр ойлгодоггүй явдал нь нөлөөлж байна хэмээн үзсэн байна.

Өнөөдөр манай улсад хохирогчийн эрхийн хамгаалалтыг хангаж ажиллах, хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх асуудал хууль тогтоомжуудад өнөөг хүртэл хангалттай түвшинд тусгалаа олоогүй байгаа нь баримтад хийсэн дүн шинжилгээгээр ажиглагдсан.

Тоон болон чанарын судалгаагаар хохирогчид үзүүлэх нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгааллын талаарх тусламж үйлчилгээ үзүүлж буй байгууллага ганц нэг төрийн бус байгууллагыг эс тооцвол бараг байхгүй байна хэмээн онцолсон байна.

Явагдсан судалгаануудын дүгнэлтээс үзэхэд хохирогчийн эрх нь гэмт этгээдийн эрхээс доогуур түвшинд хуульчлагдсан, хуульчлагдсан хуулийн зарим заалт нь тодорхой бусаас хууль хангалттай хэрэгжихгүй, мөн хуулийг хэрэглэж байгаа хуульчдын ёс суртахуун, үзэл хандлага нь хохирогчдод хуулийн байгууллагад итгэх итгэлийг сулруулж хохирогчийг хохирсон дээр нь улам хохироход хүргэж байгаа дүр төрх харагдаж байгааг тэмдэглэсэн байна.

3.3 Мэдэх эрх (Мэдээлэл авах, мэдээллээр хангагдах эрх)

НҮБ-ын Үндсэн зарчмуудад "Хохирогч түүний эрхийг, нэн ялангуяа хохирлоо барагдуулах эрхийг тайлбарлахын зэрэгцээ байцаан шийтгэх ажиллагаанд түүний гүйцэтгэх үүрэг болон хянан шийдвэрлэх ажиллагааны цар хүрээ, хугацаа, явц ба шийдвэрийн талаарх мэдээллээр хангаж, тайлбарлах"-ын чухлыг зөвлөснийг онцолсон байна. Үүнд:

- Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар хохирогч, түүний төлөөлөгчид байцаан шийтгэх ажиллагааг явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас зөвхөн тэдний үндсэн болон байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой эрх, үүргийн тухай мэдээллийг тайлбарлан өгөх үүрэгтэй, хохирогч эдгээр эрхээ хэрэгжүүлэх боломжийг шаардах эрхтэйг тэмдэглэсэн байна.
- Тоон болон чанарын судалгаанд хамрагдсан гурван хохирогч тутмын нэг нь хуулийн байгууллагын ажилтнуудын зүгээс эрхийг нь огт тайлбарлаж өгдөггүй гэсэн бол бусад нь уншиж өгдөг, хохирогчоор өөрөөр нь уншуулдаг тул тэр болгон эрхийнхээ талаар хангалттай ойлголт, мэдээлэл авч чаддаггүй гэж хариулсан байна. Судалгаагаар эрх бүхий албан тушаалтнаас хохирогчид эрх үүргийг нь тайлбарлаж өгөх үүргээ биелүүлэхгүй, биелүүлсэн ч нэр төдий байгаа нь харагдаж байна гэж үзсэн байна.

3.4 Аюулгүй байдлаа хангуулах эрх

НҮБ-ын үндсэн зарчмуудад хохирогчид учруулсан чирэгдлийг багасгах шаардлагатай үед нууцлалыг хангах, дарамтлагч ба өс хонзон хайгчдаас хохирогч, түүний гэр бүлийн гишүүд болон холбогдох гэрч нарыг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах арга хэмжээг авахыг зөвлөснийг дурьдаад, Манай улсад хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар "Цагдаагийн байгууллагын тухай" хуулийн хүрээнд "..Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх..", Гүйцэтгэх ажлын хуульд "..Иргэний аюулгүй байдлыг

хангах.” зарчмыг тунхагласан төдий, мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд “Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчоос гаргасан гомдол хүсэлтийг шийдвэрлэх”¹ хүрээнд хохирогчийн зүгээс өөрийн болон өөрт хамаатай бусдын аюулгүй байдлыг хамгаалуулах талаар хүсэлт гаргах ганцхан “эрх”-ээр хязгаарлагдаж байгааг эс тооцвол гэрч, хохирогч болон тэдгээрийг хамгаалах механизмын талаар ямар ч заалт үгүй байна.

Эрүүгийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаа улам нарийн төвөгтэй болж байгаа өнөө үед гэрч, хохирогч нарын аюулгүй байдлыг хамгаалах хууль, тогтоомж үгүйлэгдэж, түүнийг хэрэгжүүлэх нэгдсэн хөтөлбөр, төсөл дутагдаж байгааг дурьдсан байна.

Тоон болон чанарын судалгаанд Хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар:

- Аюул заналхийлэлд өртөж байсан гэж хариулсан 10 хохирогч тутмын 9 нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар хуулийн байгууллагуудаас ямар нэгэн арга хэмжээ авч байгаагүй.
- Хохирогч нарын дөнгөж 13 хувь нь хуулийн байгууллагаас арга хэмжээ авч байсан гэж үзэхдээ хавтаст хэрэгт нэр хаягийг нууцалсан төдийгөөр л аюулгүй байдлыг нь хамгаалах арга хэмжээ хязгаарлагдаж байгааг нотолсон.
- Хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар хуульчдаас өөрсдөөс нь тандахад 56.6 хувь нь ямар нэгэн арга хэмжээ авч байгаагүй гэж үзэхдээ хуульд ямар нэгэн заалт байхгүй (23.5%) эсвэл ямар нэгэн арга хэмжээ авч байгаагүй (33.1%)-г дурьдсан байна. Үүнээс үзэхэд хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний талаар тодорхой заалт үгүй, ямар ч хамгаалалтгүй байна гэж хэлж болохоор байна.

Ялангуяа хүнд, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн хохирогч, гэрчийн асуудалд төрөөс онцгой анхаарч үзэх шаардлагатай байгааг тэмдэглэсэн байна.

3.5 Зөрчигдсэн эрхээ нөхөн сэргээлгэх, хохирлоо арилгуулах эрх

НҮБ-ын үндсэн зарчмуудад гэмт этгээд буюу түүний өмнөөс хариуцлага хүлээх гуравдагч тал нь хохирогч, түүний гэр бүл буюу түүгээр тэжээлгэж буй хүмүүсийн хохирлыг шударгаар арилгах ёстой.

Хэрвээ гэмт этгээдээс буюу бусад эх үүсвэрээс хохирлыг арилгах боломжгүй тохиолдолд төрөөс наад зах нь

а/ Хүнд төрлийн гэмт хэргийн улмаас бие махбодын хүнд гэмтэл авсан, бие буюу сэтгэцийн эрүүл мэнд нь алдагдсан

б/ Дээрх төрлийн хохирлоос шалтгаалан сэтгэцийн өвчтэй буюу тахир дутуу болсон эсвэл нас барсан хохирогчийн гэр бүл, түүний дотор тэжээгчээ алдсан хүмүүст нөхөн олговор олговол зохино гэж зөвлөсөн байна.

Монголд төр засгаас учирсан зарим төрлийн хохирлыг, Тухайлбал, улс төрийн хэлмэгдүүлэлтийн хохирогчдын хохирлыг нөхөн төлж байгаа боловч, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын төлөө нөхөн төлбөр, олговор олгох эрх зүйн зохицуулалт практик үйл ажиллагаа гадаадын хөгжингүй улс орнуудаас ихээхэн хоцорч байгааг онцолсон байна.

Мөн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгуулах талаарх заалт холбогдох хуулинд хангалттай мэт боловч эдгээр нь зөвхөн тунхаглалын шинжтэй төдийгүй хэрэгжих механизм нь тодорхой бус

байна. Ялангуяа сэтгэл санааны хохирлыг барагдуулах асуудал хуулинд маш бүрхэг байгаагаас гадна хохирлыг үнэлэх үнэлгээний арга зүй ч алга байна. Тухайлбал: ЭБШ хуульд иргэний нэхэмжлэл гаргах эрх зүйн үндсийг гагцхүү гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээсэн этгээдэд гаргуулах эрхийг олгосон нь эдийн бус хохирлыг барагдуулах асуудлыг бүрхэгдүүлснийг тэмдэглэсэн байна.

Манай улсын хувьд ийнхүү хохирлыг арилгах, гэмт хэргийн улмаас учирсан хохирогчийг нийгэм, сэтгэл зүй, бие махбодын хувьд хамгаалах асуудал хамгийн ихээр тулгамдсан хэвээр байгаа боловч, түүнийг шийдвэрлэх явдал дэлхийн хөгжилтэй улсуудаас хоцорсон хэвээр байна. Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, хохирлыг арилгах асуудлыг “нийтийн” болон “иргэний” эрх зүйн аль салбараар нь зохицуулахыг цаашид гүнзгийрүүлэн нарийн судлах шаардлагатайг дурьдсан байна.

Тоон болон чанарын судалгаагаар хохирогчийн хохирлыг арилгах асуудал ямар түвшинд байгааг тандахад:

Хохирогч нарын бараг тал хувь (47%) нь хохирол барагдуулаагүй гэж үзсэн бөгөөд ялангуяа хэрэг нь шийдвэрлэгдээгүй удсан хохирогч нарын хувьд ингэж үзсэн нь харьцангуй их байна.

Хохирол барагдахгүй байгаагийн гол шалтгааныг хуулинд хохирол барагдуулах талаар тодорхой заалт байхгүй гэж 6.5 хувь, хохирол барагдуулах тогтолцоо бүрэлдээгүй гэж 11.9 хувь, хохирол барагдуулах талаар хуулийн байгууллагын ажилтнууд санаачлагагүй ханддаг гэж 23.8 хувь, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч төлбөрийн чадваргүйгээс болдог гэж 23.2 хувь нь хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг үнэлж чадахгүй байгаа гэж 13 хувь, одоогоор шалгаж байгаа гэж 17.3 хувь нь үзсэн байна.

Хохирогчид учирсан хохирлуудаас сэтгэл санаа, нэр төр алдар хүндээрээ хохирох явдал хамгийн хүнд бөгөөд шийдвэрлэх боломжгүй байдаг хэмээн хуулийн байгууллагын ажилтнуудын 63.3 хувь нь үзсэн зэргийг үндэс болгосон байна.

Судалгааны дүнд тулгуурлан хохирогчийн хохирлыг хуулийн байгууллагын ажилтнууд барагдуулах тал дээр санаачлагагүй ханддаг, гэмт этгээд төлбөрийн чадваргүй, сэтгэл санааны болон зарим төрлийн хохирлыг үнэлж чадахгүй байгааг нь хуулинд заасан хохирол барагдуулах эрх ерөнхийдөө зөрчигдөхөд хүргэж байгааг тэмдэглэжээ.

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад, гэмт хэргийн хохирогчийн нөхөн төлбөрийг хангах салбарын хамгийн боловсронгуй хууль тогтоомж нь ихэвчлэн нэхэмжлэгчдийн хангалттай өргөн хүрээ (*хохирогч, төрөл төрөгсөд, тэжээн тэтгүүлэгчид, гадаадад хохирсон жуулчин, иргэд гэх зэрэг*), нөхөн төлбөрийн хөтөлбөрийг хэрэглэх хязгаарлагдмал үндэслэлүүд (*бие хүний эсрэг хүч хэрэглэсэн гэмт хэрэг, мөн зарим эд хөрөнгийн гэмт хэргийн нөхөн төлбөрийг олгох*) ба санхүүгийн хатуу тогтоосон тодорхой эх үүсвэрүүдийг (*төрийн төсөв, гэмт хэрэгтнүүдээс хураан авсан эд зүйл, тэднээс хуримтлуулсан торгууль, хураамж, шимтгэл, даатгал, гэх зэрэг*) авч үзсэн байдгийг тэмдэглэжээ.

3.6 Нийгмийн халамж, дэмжлэг түслалцаа авах эрх

НҮБ-ын үндсэн зарчмуудад хохирогчид шаардлагатай материаллаг, эмнэлгийн, сэтгэл зүйн ба нийгмийн халамжийн тусламжийг төрийн, сайн дурын, оршин суугаа газрын буюу орон нутгийн эх үүсвэрүүдээс авах ёстой ба хууль сахиулах байгууллагууд болон эрүүл мэнд, нийгмийн салбарын ажилтнуудад тусгай сургалт явуулахын

зэрэгцээ, хохирогчид зохих тусламж үйлчилгээг шуурхай үзүүлэх талаар удирдамж, зааварчилгаа гаргаж мөрдүүлэх арга хэмжээ авахыг зөвлөсөн байна.

Мөн тусламж үзүүлэхдээ авсан гэмтэл буюу өөр учир шалтгааны улмаас тусгай үйлчилгээ шаардах эмзэг бүлгийн хохирогчид илүү анхаарал тавьж шуурхай үйлчлэхийг зориуд анхааруулан зөвлөснийг тэмдэглэсэн байна.

Манай оронд хохирогчийн нийгмийн халамж, эд хөрөнгийн, эмнэлэгийн, сэтгэл зүйн болон холбогдох мэдээллээр хангах зэрэг тусламж үйлчилгээ үзүүлэх талаар хангалтгүй, энэ талаар хууль тогтоомжид гэмт хэргээс хохирсон этгээдүүд нь зөвхөн эрх зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх, төлөөлүүлэх эрхээр хязгаарлагдаж байгааг онцолжээ.

Манай орны хувьд хохирогчдод наад захын тусламж үйлчилгээг зөвхөн хөтөлбөрийн хүрээнд төрийн бус байгууллагуудаас үзүүлж байна. Үүнд:

Хүчирхийллийн эсрэг үдэсний төв (ХЭҮТ) болон төрийн бус байгууллагууд ихэвчлэн эмзэг бүлгийн хохирогчдод чиглэсэн эмнэлгийн тусламж, нийгмийн халамж, сэтгэл зүйн болон хууль эрх зүйн холбогдох мэдээллээр хангах зэрэг үйлчилгээг үзүүлж байна. Харин бусад хохирогчдод чиглэсэн үйлчилгээ үгүйлэгдсэн хэвээр байгааг тэмдэглэжээ. Эдгээр үйлчилгээг үзүүлэх эрх бүхий хуулийн байгууллагууд болон эрүүл мэнд, нийгмийн салбарын ажилтнуудын хамтын ажиллагаа, ажил үүргийн уялдаа холбоо сул байна гэж үзсэн байна.

Хавтаст хэргийн судалгаагаар Цагдаагийн байгууллагаас хохирогчдод үзүүлж буй тусламж үйлчилгээний талаар судлахад 48.4 хувь нь энэ арга хэмжээний талаар хавтаст хэргүүдэд ямар нэгэн мэдээлэл тэмдэглэгдээгүй, 29.4 хувь нь эмнэлэгийн туслалцаа үзүүлсэн, 21.3 хувь нь эрхээ хамгаалах талаар зөвөлгөө өгсөн, 0.9 хувь нь аюулгүй байдлыг нь хангаж хамгаалалтанд авсаныг дурьджээ.

Судалгаанаас үзэхэд хохирогчдод үзүүлэх тусламж үйлчилгээний талаар холбогдох байгууллагууд ямар нэгэн ойлголт мэдээлэлгүй, энэ талаар баримталж ажиллах журам, заавар байхгүй байна. Хэрэв хохирогчид энэрэнгүй хандаж туслалцаа үзүүлэх тухай олон улсын жишигийн дагуу тодорхой журам байвал холбогдох албан тушаалтнууд хэрэгжүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлснийг тэмдэглээд дээрх чиглэл тус бүрээр тодорхой зөвлөмж өгчээ.

Хууль зүйн яам болон төрийн бус байгууллагуудаас явуулсан өмнөх судалгаануудад ихэвчлэн хохирогчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр судалж байсан бол энэ удаагийн баримтын судалгаагаар хохирогчтой холбоотой тоо мэдээлэлд үндэслэн гэмт хэргийн хохирогчийн шинж байдал, гэмт хэргийн улмаас ямар төрлийн хохирол учирч, түүнийг хэрхэн барагдуулж байгаа талаар судлах болно.

БҮЛЭГ 4. ХОХИРОГЧИЙН ДҮР ТӨРХӨД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, хууль сахиулах байгууллагуудаар

4.1 ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ГЭЖ ХЭН БЭ ?

Олон улсын Хүний эрхийн гэрээ, конвенц болон НҮБ-ын тунхаглал, зарчмууд нь хохирогчийн эрхийн хоёр үндсэн асуудлыг дэвшүүлэн тавьсан. Үүнд:

1. Аливаа хохирогчтой хүнлэг ёсоор эрх, эрх чөлөөг нь хүндэтгэн харьцах бөгөөд төрөөс хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдал, бие махбодын болон оюун санааны сайн сайхан, хувийн амьдралын халдашгүй байдлыг баталгаажуулах бүхий л зохистой арга хэмжээг авах үүрэгтэй. Үүний тулд хохирогчийн зөрчигдсэн эрхээ сэргээлгэх ажиллагааны явцад түүнийг дахин хохироохгүй байх баталгааг бүрдүүлэх үүднээс тусгай хөнгөлөлт, туслалцаа, дэмжлэг үзүүлэх явдлыг хууль тогтоомждоо тусгах явдал юм гэжээ.

2. Олон улсын гэрээ, конвенц, НҮБ-ын тунхаглал зарчмуудаар баталгаажсан хоёр дахь гол асуудал бол хохирлоо нөхөн төлүүлэх эрх юм.

1989 оны НҮБ-ын “Хохирогч ба түүнийг хамгаалах тухай” конвенц болон олон улсын хүний эрхийн талаарх үндсэн зарчмуудад **“ХОХИРОГЧ”** гэж гэмт хэрэг, эрх мэдлээ хортойгоор ашигласан болон хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийн улмаас бие эрхтэн, оюун сэтгэхүйн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, сэтгэл санааны зовлон шаналалд автсан, эд материалын хохирол хүлээсэн, үндсэн эрх, эрх чөлөө нь ноцтой зөрчигдсэн хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ” гэж тодорхойлсон бол *Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд “Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ” гэж тодорхойлжээ.*


НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас 1985 онд “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал” батлагдсан нь дэлхийн улс орнуудад виктимологийн шинжлэх ухаан хөгжих эрх зүйн гол үндэслэл болсон байна.

4.2 Эрүүгийн гэмт хэргийн хохирогчийн дүр төрх (Цагдаагийн Хэрэг бүртгэл, Мөрдөн байцаалтын шатанд)

Энэ бүлэгт Эрүүгийн гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн шинж байдал, түүний хохирлыг хэрхэн барагдуулж байгаа, хохирогчийн эрхийн хамгаалалт Монгол Улсад ямар хэмжээнд байгааг баримтын судалгаагаар цуглуулсан мэдээллийн хүрээнд тодорхойлохыг зорилоо.

Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдлээс баттай хамгаалагдсан байх явдал юм. Нэг ч хүн хохирохгүй байх нөхцлийг бүрдүүлсэн улс орны туршлага хаа ч байхгүй бөгөөд байх ч боломжгүй. Гэхдээ л иргэдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг тасралтгүй үр ашигтай явуулах, нэгэнт хохирсон тохиолдолд түүний хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх эрх зүйн тогтолцоо, үйл ажиллагааны зохистой нөхцлийг цогцоор нь бүрдүүлэх явдал нь аль ч улс орны хувьд нэн чухал байдаг байна.

Зураг 4.2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба хохирогч иргэд, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 7 жилийн дунджаар жил тутам 21260 гэмт хэрэг Цагдаад бүртгэгдэж 20573 хүн Эрүүгийн гэмт хэргийн хохирогч болжээ. Хохирогчдын 7196 буюу 35.0 хувь нь эмэгтэйчүүд, 1174 буюу 5.7 хувь нь хүүхдүүд байна (Хүснэгт 4.2.1)

Гэмт хэргийн улмаас 2013 онд 25015 иргэн хохирсон нь 2012 оныхоос 3721 хүн буюу 17.5 хувиар нэмэгдэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо ч 3273 буюу 14.8 хувиар, 2012 онд 2011 оныхоос хохирогч иргэдийн тоо 6423 буюу 34.5 хувь нэмэгдэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 6165 буюу 32.1 хувиар өссөн байна. Эндээс харахад гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо, гэмт хэргийн тоотой шууд хамааралтайгаар өссөөр байгаа байдал ажиглагдаж байна (Зураг 4.2.1).

Хүснэгт 4.2.1 Хохирогчийн дүр төрх, 2007-2013 он


Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	Хохирогч иргэдийн тоо			Хохирогч байгууллагын тоо			Учирсан хохирол тэрбум.төг			Нөхөн төлүүлэлт тэрбум.төг	10000 хүнд ноогдох хохирогчийн тоо	
	Нийт	Эмэгтэй	18 хүртэлх насны хүүхэд	Нийт	Төрийн	Хувийн	Нийт	Төрийн	Хувийн			
2007 он	21 268	19 931	6 115	1 151	975	456	446	29.5	10.9	15.8	4.0	76
2008 он	20 704	20 256	6 175	1 080	1 044	490	396	54.8	10.9	22.7	7.0	76
2009 он	20 373	19 545	6 312	1 045	824	468	307	49.2	13.6	25.8	18.0	72
2010 он	19 825	19 381	7 097	1 066	358	234	74	33.4	8.8	24.4	14.3	70
2011 он	19 197	18 592	6 856	1 178	184	128	42	35.9	10.0	25.4	18.5	66
2012 он	22 089	21 294	7 977	1 270	167	88	55	53.3	9.6	42.8	25.1	74
2013 он	25 362	25 015	9 838	1 426	157	99	48	159.0	79.0	72.9	111.3	85

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2012 оны байдлаар Монгол Улсын 10000 хүн тутмаас 74 нь гэмт хэргийн хохирогч болсон бол 2013 онд 85 болж, 11 хүн буюу 12.9 хувиар нэмэгдсэн байна. Харин 2012 онд 10000 хүн тутмын 28 нь эмэгтэй хохирогч, 4 нь 18 хүртэлх насны хохирогч хүүхэд байсан бол 2013 онд 10000 хүний 34 нь эмэгтэй хохирогч, 5 нь 18 хүртэлх насны хохирогч хүүхэд болж, 10000 хүнд ноогдох эмэгтэй хохирогчийн тоо 6-аар, 18 хүртэлх насны хүүхдийн тоо 1-ээр нэмэгдсэн байна.


2013 онд гэмт хэргийн улмаас хохирсон 10 хүн тутмын 5 нь 18-34 насны залуучууд, 6 нь эрэгтэйчүүд, 3 нь ажилгүй иргэн байгаа нь өмнөх оны түвшингээс буураагүй байна.

Зураг 4.2.2 Хохирогч иргэд, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Зураг 4.2.3 Хохирогч иргэд, хүйсээр, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хүснэгт 4.2.2 Хохирогч иргэд, эмэгтэйчүүд, хүүхэд, дүнд эзлэх хувь, 2007-2013 он


Онууд	Хохирогч иргэдийн тоо			Өсөлт, бууралт			Дүнд эзлэх хувь		
	Нийт	Эмэгтэй	Хүүхэд	Нийт	Эмэгтэй	Хүүхэд	Нийт	Эмэгтэй	Хүүхэд
2007	19 931	6 115	1 151	-	-	-	100.0	30.7	5.8
2008	20 256	6 175	1 080	↑	↑	↓	100.0	30.5	5.3
2009	19 545	6 312	1 045	↓	↑	↓	100.0	32.3	5.3
2010	19 381	7 097	1 066	↓	↑	↑	100.0	36.6	5.5
2011	18 592	6 856	1 178	↓	↓	↑	100.0	36.9	6.3
2012	21 294	7 977	1 270	↑	↑	↑	100.0	37.5	6.0
2013	25 015	9 838	1 426	↑	↑	↑	100.0	39.3	5.7
Жилийн дундаж	20573	7196	1174	-	-	-	100.0	34.8	5.7

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 7 жилд хохирсон нийт иргэдийн 51.6-60.6 хувь нь Улаанбаатарт, 6.0-8.6 хувь нь Зүүн бүсэд, 15.3-18.3 хувь нь Төвийн бүсэд, 11.3-13.1 хувь нь Хангайн бүсэд, 5.9-8.4 хувь нь Баруун бүсэд байна. 2013 оны эцсийн байдлаар нийт хохирогчдын 60.6 хувь нь Улаанбаатар хотод, 15.3 хувь нь Төвийн бүсэд, 12.2 хувь нь Хангайн бүсэд, 6.0 хувь нь Зүүн бүсэд, 5.9 хувь нь Баруун бүсэд байна.

2013 онд Төв, Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудаас хамгийн олон иргэн хохирсон бол Говь-Алтай, Говьсүмбэрт хамгийн цөөн иргэн хохирсон байна. 2013 онд Улаанбаатар хотын хэмжээнд 15029 иргэн хохирсны 14393 буюу 95.8 хувь нь төвийн 6 дүүрэгт гарсан байна. Дүүргүүдээс Баянзүрх дүүрэгт хамгийн олон 3630 иргэн хохирсон нь 2013 онд улсын хэмжээнд хохирсон иргэдийн 14.5 хувийг эзэлж байна. Баян зүрх дүүргийн нийт хохирсон иргэдийн 1047 буюу 28.8 хувь нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хохирогч, 1755 буюу 48.3 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, 418 буюу 11.5 нь Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч байна.


Зураг 4.2.4 Хохирогч иргэд, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч агентлаг Цагдаагийн Ерөнхий газар

2013 оны байдлаар хохирогч иргэдийн 49.5 хувь нь 18-34 насны залуучууд байна. Нийт хохирогчдод 18-24 насны залуусын эзлэх хувь 2013 онд 17.7 хувь болж, өмнөх оныхоос 1.8 пункт, 18 хүртэлх насны хүүхдийнх 6.0 хувь болж 0.3 пункт, 40-44 насныхан 10.2 хувь болж 0.2 пункт, 45-49 насныхан 8.5 хувь болж 0.3 пунктээр нэмэгдэж, харин бусад насны хохирогч иргэдийн эзлэх хувь буурчээ. 2013 онд нийт хохирогч иргэдийн 31.8 хувийг ажилгүй иргэд эзэлж байгаа нь 2012 оныхоос 622 хохирогч буюу 2.7 пунктээр буурчээ. Хохирогчдын 365 буюу 1.5 хувь нь өөрийн буруугаас, 371 буюу 1.5 хувь нь архидан согтуурсны улмаас хохирсон байна.

Зураг 4.2.5 Хохирогч иргэд, насны бүлэг, дүнд эзлэх хувиар, 2012-2013 он




Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Зураг 4.2.6 Хохирогч иргэд, нийгмийн байдлаар, 2012-2013 он



Эх үүсвэр: Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Зураг 4.2.7 Хохирогч иргэд, эмэгтэй, хүүхэд, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 7 жилийн байдлаар гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн дүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь тасралтгүй өссөөр ирсэн байна. 2007-2009 онд Монгол Улсын 10000 хүн тутмаас 23 эмэгтэй гэмт хэргийн хохирч байсан бол 2010 онд 3-аар нэмэгдэж 26 болж, харин 2011 онд буураад, сүүлийн 2 жил дахин нэмэгдсээр байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2013 онд 25015 байгаагийн 1426 буюу 6.0 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 9838 буюу 39.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

Нийт хохирогч иргэдийн дүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2008 онд 2007 оныхоос 0.2 пунктээр буурсан бол 2013 онд 2008 оныхоос 8.8 пункт, 2009 оныхоос 7.0 пункт, 2010 оныхоос 2.7 пункт, 2011 оныхоос 2.4 пункт, 2012 оныхоос 1.8 пунктээр тус тус нэмэгджээ.

Хүүхдийг хохироох явдал, тэдний эрх ашгийг ноцтой зөрчих явдал манай оронд хэвшмэл байдлаар байсаар байна.

Хүснэгт 4.2.3 Хохирсон хүүхэд, 2007-2013 он

	Нийт хүн амын тоо	Үүнээс:		Хохирогч иргэд	Хохирогч эмэгтэй	Хохирогч хүүхэд	10000 хүүхэд тумаас хохирч буй хүүхдийн тоо
		Эмэгтэй	18 хүртэлх насны хүүхэд				
2007 он	2 620 446	1 343 197	935 070	19 931	6 115	1 151	12
2008 он	2 665 955	1 364 650	923 637	20 256	6 175	1 080	12
2009 он	2 716 275	1 388 135	913 980	19 545	6 312	1 045	11
2010 он	2 760 968	1 418 887	909 879	19 381	7 097	1 066	12
2011 он	2 811 666	1 446 943	902 253	18 592	6 856	1 178	13
2012 он	2 867 744	1 474 291	925 007	21 294	7 977	1 270	14
2013 он	2 930 277	1 504 434	949 046	25 015	9 838	1 426	15

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2007-2010 онд Монгол Улсын 18 хүртэлх насны 10000 хүүхэд тутмын 11-12 нь хохирогчоор бүртгүүлсэн бол 2011 оноос нэмэгдсээр 2013 онд Монгол Улсын 10000 хүүхэд тутмаас 15 хүүхэд хохирогчоор Цагдаагийн байгууллагад эдийн засаг, эд материалын хохирлоо барагдуулахаар бүртгүүлжээ. 2013 оны байдлаар хохирогч хүүхдийн 13.0 хувь нь 7 хүртэлх насны, 27.7 хувь нь 8-13 насны, 59.3 хувь нь 14-17 насны хүүхэд байна.

Хүснэгт 4.2.4 Хохирсон хүүхэд, гэмт хэргийн төрлөөр, 2007-2013 он

д/д	Гэмт хэргийн зүйл анги	Хохирогч хүүхэд						
		2007	2008	2009	2010	2011	2012	2013
1	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	1	-	-	-	-	-
2	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	290	363	350	343	375	391	398
3	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	-	2	1	-	1	2	6
4	Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	202	158	170	184	202	196	202
5	Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	2	3	1	2	5	11	5
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	330	246	204	187	210	269	373
7	Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	1	1	-	4	-	-	7
8	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	86	75	75	95	125	115	102
9	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	41	67	85	67	50	41	85
10	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	-	-	-	1	-	-	1
11	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	195	162	158	181	208	244	246
12	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	1
13	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	3	1	1	2	2	-	-
14	Албан тушаалын гэмт хэрэг	-	1	-	-	-	-	-
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	1	-
Улсын дүн		1 151	1 080	1 045	1 066	1 178	1 270	1 426

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар


Сүүлийн 7 жилд дунджаар жил тутам Эрүүгийн гэмт хэргийн улмаас 1170 орчим хүүхэд хохирсон байна (Хүснэгт 4.2.4).

Гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл хохирогч хүүхдүүдийн зонхилох хэсэг нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, Өмчлөх эрхийн эсрэг, Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг, Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг, Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирчээ.

2013 онд нийт хохирсон хүүхдүүдийн 27.9 хувь нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, 26.2 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг, 17.2 хувь нь ТХХАБАЖ-ын эсрэг, 14.2 хувь нь Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг, 7.2 хувь нь Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон байна. 2013 онд хохирсон хүүхдийн тоо 156 буюу

12.3 хувиар өсөхөд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо өмнөх оныхоос 6.1 пункт, Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо 2.2 пунктээр өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 4.2.8 Хохирогч хүүхэд, гэмт хэргийн төрөл, дүнд эзлэх хувиар, 2012-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хүснэгт 4.2.5 Хохирогч иргэд, боловсролын түвшин, гэмт хэргийн төрлөөр, 2013 он

Эрүүгийн хуулийн бүлгээр	Хохирогч иргэн-бүгд	Боловсролын түвшин						
		Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	-	-	-	-	-	-	1
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	8 285	290	593	1 618	3 492	6	332	1 954
Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	52	6	1	3	11	-	3	28
Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	408	43	94	106	115	-	4	46
Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	126	4	8	23	72	-	4	15
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	11 012	231	679	1 623	3 842	4	487	4 146
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	95	8	1	1	8	-	5	72
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1 927	57	100	350	925	-	63	432
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	273	29	65	56	70	-	15	38
Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	262	3	3	6	21	-	18	211
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	2 293	127	192	389	990	3	90	502
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	203	7		7	63	-	4	122
Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	59	4	2	5	13	-	1	34
Албан тушаалын гэмт хэрэг	10	1			2	-	-	7
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	9		3	2	4	-	-	-
Улсын дүн	25 015	810	1 741	4 189	9 628	13	1 026	7 608

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хохирогч иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 2013 онд нийт хохирогч иргэдийн 38.5 хувийг бүрэн дунд боловсролтой, 30.4 хувийг дээд боловсролтой, 16.7 хувийг суурь боловсролтой, 7.0 хувийг бага боловсролтой, 4.1 хувийг тусгай мэргэжлийн дунд, 3.2 хувийг боловсролгүй, 0.1 хувийг техникийн болон мэргэжлийн боловсролтой иргэд эзэлж байна.

Бүрэн дунд боловсролтой хохирогч иргэний нийт хохирогч иргэдийн дунд эзлэх хувь 2013 онд өмнөх оныхоос 1.1 пункт, 2011 оныхоос 6.7 пункт, 2010 оныхоос 7.1 пунктээр тус тус буурсан байна.

Дээд боловсролтой хохирогч иргэдийн тоо 2013 онд өмнөх оныхоос 24.3 хувь, 2010 оныхоос 55.3 хувиар нэмэгдсэн байна.

Хохирогч иргэдийн 11012 буюу 44.0 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг, 8285 буюу 33.1 хувь нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, 2293 буюу 9.2 ТХХАБАЖ-ын эсрэг, 1927 буюу 7.7 хувь нь Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч байна (Хүснэгт 4.2.5).

Хүснэгт 4.2.6 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2007-2013 он

Он	Хохирогч иргэд	Учирсан хохирол сая .төг	1 хохирогчид ноогдох хохирол сая.төг	Нөхөн төлүүлэлт сая.төг	1 хохирогчид ноогдох нөхөн төлүүлэлт сая.төг
2007 он	19 931	29 265.3	1.5	4 065.3	0.2
2008 он	20 256	54 802.3	2.7	6 974.7	0.3
2009 он	19 545	49 186.1	2.5	17 965.0	0.9
2010 он	19 381	33 383.1	1.7	14 346.8	0.7
2011 он	18 592	35 904.3	1.9	18 490.5	1.0
2012 он	21 294	53 263.2	2.5	25 135.6	1.2
2013 он	25 015	159 024.2	6.4	111 266.6	4.4

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Гэмт хэргийн улмаас 2013 онд 1 хохирогчид ноогдох хохирол 6.4 сая төг байгаа нь 2007 оныхоос 4.3 дахин, 2008 оныхоос 2.4 дахин, 2009 оныхоос 2.6 дахин, 2010 оныхоос 3.8 дахин, 2011 оныхоос 3.4 дахин, 2012 оныхоос 2.6 дахин нэмэгдсэн байна (Хүснэгт 4.2.6).

Харин 2012 онд нийт учирсан хохирлын 47.2 хувийг нөхөн төлүүлсэн бол 2013 онд нийт учирсан хохирлын 70 хувийг нөхөн төлүүлсэн байна. Энэ нь 2009 оныхоос 33.4 пункт, 2010 оныхоос 27.2 пункт, 2011 оныхоос 18.5 пункт, 2012 оныхоос 22.9 пунктээр өссөн хэдий ч бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, түүний хор хохиролтой харьцуулахад хангалттай үр дүн биш юм.


Сүүлийн жилүүдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлт нэмэгдэж байгаа ч энэ нь зөвхөн мөнгөөр илэрхийлж болох эд материал, эдийн засгийн хохирол юм. Эдийн засаг эд материалын хохирлоос гадна эрүүл мэнд, сэтгэл санаа, нэр төрийн асар их хохирлыг тогтоох, нөхөн төлүүлэх механизм манай оронд үгүйлэгдэж байна.

2013 онд 1 хохирогчид ноогдох хохирол 6.4 сая төгрөг байсан бол 1 хохирогчид ноогдох нөхөн төлүүлэлт 4.4 сая төгрөг байна.

Монгол Улсад эрх нь хамгийн их зөрчигдөж байгаа хүмүүс бол гэмт хэргийн улмаас хохирогчид байдаг байна. Энд зөвхөн Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт яригдаж байгаа бөгөөд Цагдаад бүртгүүлээгүй гэмт хэргийн хохирогчид ч байсаар л байдаг нь нууц биш юм.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Эрх чөлөөтэй монгол хүн” тавдугаар бүлэгт гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах, хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, гэрч, хохирогчийн талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах, гэрч, хохирогчдыг мэдээллээр хангах, хариуцлагатай байх талаар тусгасан. Энэ ажлын хүрээнд “ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” хууль батлагдсан нь сайшаалтай боловч хуулийг хэрэгжүүлэх орчин нөхцөл, хөрөнгө санхүүгийн асуудал шийдэгдэхгүй удаашралтай байна.

Зураг.4.2.9 Учирсан хохирол, гэмт хэргийн ангиллаар, 2012-2013 он




Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

НАС БАРСАН ИРГЭД

Эрүүгийн гэмт хэргийн улмаас сүүлийн 7 жилд нийт 8469 хүн амь насаа алдсаны 1990 буюу 23.5 хувь нь эмэгтэйчүүд, 665 буюу 7.9 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Жил тутам дунджаар 1210 хүн нас барсны 284 нь эмэгтэй, 95 нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. 2007-2008 онд жил тутам 1500-1600 иргэн гэмт хэргийн улмаас нас барж байсан бол сүүлийн жилүүдэд 900 орчим болж буурчээ.

Гэмт хэргийн улмаас 2013 онд 25015 хүн хохирсны 949 хүн буюу 3.8 хувь нь нас барсан, 9797 буюу 39.2 хувь нь гэмтсэн иргэд байна. Нас барсан иргэдийн тоо өмнөх оныхоос 48 буюу 5.3 хувиар нэмэгдэхэд Архангай, Төв, Дундговь, Говьсүмбэр, Булган аймгуудад өмнөх оныхоос өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 4.2.10 Нас барсан иргэд, сүүлийн 7 жилд



Хүснэгт 4.2.7 Нас барсан иргэд, гэмт хэргийн төрлөөр, 2007-2013 он

д/д	Гэмт хэргийн зүйл анги	Нас барсан иргэн													
		2007		2008		2009		2010		2011		2012		2013	
		Нийт	Эм	Нийт	Эм	Нийт	Эм	Нийт	Эм	Нийт	Эм	Нийт	Эм	Нийт	Эм
1	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	2	-	-	-	-	-	-	-	-	-
2	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1 210	246	1 170	213	985	265	814	203	507	123	472	115	461	108
3	Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	1	1	2	2	2	1	4	3	2	2	2	2	4	4
4	Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	18	3	34	6	20	1	16	3	15	2	33	1	36	6
5	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг			2	1	10		5	3	5	2	6		8	2
6	Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	-	-	11	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	23	3	16	4	20	1	26	6	29	4	18	2	14	2
8	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	1	-	-	-	1	-	2	2
9	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	344	65	313	73	317	68	325	114	363	100	369	111	424	115
10	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	-	1	-	1	-	-	-	1	-	-	-	-	-
11	Албан тушаалын гэмт хэрэг	-	-	2	1	1	1	-	-	-	-	-	-	-	-
Улсын дүн		1 597	318	1 551	300	1 358	337	1 191	332	922	233	901	231	949	239

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 7 жилд нас барсан хүмүүсийн 5619 буюу 66.3 хувь нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, 2455 буюу 29.0 хувь нь Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алджээ.

Сүүлийн 7 жилд нас барсан иргэдийн 1988 буюу 23.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Эмэгтэйчүүдийн 1273 буюу 64.0 хувь нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, 646 буюу 32.5 хувь нь Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь нас алджээ.

Хүснэгт 4.2.8 Нас барсан иргэд, бүс, аймаг, нийслэлээр, 2007-2013 он

Аймаг, нийслэл	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2007-2013
БҮГД	1597	1551	1358	1191	922	901	949	8469
Баруун бүс	122	99	115	53	68	32	55	544
Баян-Өлгий	13	10	12	15	13	6	9	78
Говь-Алтай	13	15	8	9	15	6	9	75
Завхан	28	12	29	5	10	10	16	110
Увс	32	32	36	6	5	3	5	119
Ховд	36	30	30	18	25	7	16	162
Хангайн бүс	314	229	154	170	138	170	159	1334
Архангай	60	69	28	25	31	23	30	266
Баянхонгор	26	18	17	17	19	28	21	146
Булган	25	21	19	32	9	14	26	146
Орхон	44	30	17	18	23	26	11	169
Өвөрхангай	38	36	36	23	30	43	40	246
Хөвсгөл	121	55	37	55	26	36	31	361
Төвийн бүс	272	259	232	198	226	235	288	1710
Говьсүмбэр	10	12	19	5	8	4	18	76
Дархан-Уул	19	31	17	38	31	28	19	183
Дорноговь	36	17	13	21	16	31	29	163
Дундговь	10	12	6	5	19	4	15	71
Өмнөговь	60	41	25	44	29	29	30	258
Сэлэнгэ	57	45	41	41	51	47	48	330
Төв	80	101	111	44	72	92	129	629
Зүүн бүс	141	117	68	79	57	78	79	619
Дорнод	30	39	35	25	20	25	29	203
Сүхбаатар	34	23	12	13	7	15	17	121
Хэнтий	77	55	21	41	30	38	33	295
Улаанбаатар	724	835	783	665	427	386	366	4186
Бусад*	24	12	6	26	6	0	2	76

Тайлбар: *Төмөр замын цагдаагийн хэлтэс, Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэст бүртгэгдсэн болон Монгол Улсын иргэдийн хилийн чанадад үйлдсэн хэргийг хамруулав.

Сүүлийн 7 жилд нас барсан иргэдийн 4262 буюу 50.3 хувь Улаанбаатар хот, 1710 буюу 20.2 хувь нь Төвийн бүс, 1334 буюу 15.8 хувь нь Хангайн бүс, 619 буюу 7.3 хувь нь Зүүн бүс, 544 буюу 6.4 хувь нь Баруун бүсийнх байна.

Сүүлийн 7 жилийн дунджаар Улаанбаатар хотод нас баралт хамгийн их байгаа хэдий ч 2010 оноос эрс буурч, 2013 онд 368 болсон байна.


Хүснэгт 4.2.9 Нас барсан иргэд, насны бүлгээр, 2010-2013 он

д/д	Насны бүлэг	Нас барсан хүн				Дүнд эзлэх хувь			
		2010	2011	2012	2013	2010	2011	2012	2013
1	7 хүртэлх	48	43	42	41	4.0	4.7	4.7	4.3
2	8-13	25	15	12	10	2.1	1.6	1.3	1.1
3	14-17	13	19	26	23	1.1	2.1	2.9	2.4
4	18-24	126	114	120	88	10.6	12.4	13.3	9.3
5	25-29	121	87	93	110	10.2	9.4	10.3	11.6
6	30-34	173	116	116	122	14.5	12.6	12.9	12.9
7	35-39	161	119	109	128	13.5	12.9	12.1	13.5
8	40-44	151	123	95	93	12.7	13.3	10.5	9.8
9	45-49	155	103	103	117	13.0	11.2	11.4	12.3
10	50-54	100	90	89	90	8.4	9.8	9.9	9.5
11	55-59	41	45	38	45	3.4	4.9	4.2	4.7
12	60-64	29	19	26	38	2.4	2.1	2.9	4.0
13	65-69	14	16	14	19	1.2	1.7	1.6	2.0
14	70 ба түүнээс дээш	34	13	18	25	2.9	1.4	2.0	2.6
Улсын дүн		1 191	922	901	949	100.0	100.0	100.0	100.0

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Жил тутам нас барсан нийт иргэдийн 70 гаруй хувийг 18-44 насныхан эзэлдэг ба 18-24 насныхан гэмт хэргийн улмаас хамгийн их нас баржээ.

Зураг 4.2.11 Нас барсан, гэмтсэн иргэд, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Гэмт хэргийн улмаас 2013 онд нас барсан хүний 44.7 хувь нь ТХХАБАЖ-ын эсрэг, 16.9 хувь нь хүнийг санаатай алах, 26.7 хувь нь бусдыг амиа хорлоход хүргэх, 1.9 хувь нь бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийн улмаас нас баржээ.

Гэмт хэргийн улмаас 74 хүүхэд нас барж, 721 хүүхэд гэмтсэн байна. Нас барсан хүүхдүүдийн 36 буюу 48.6 нь авто ослын улмаас амь насаа алдсан байна. Эндээс үзэхэд замын хөдөлгөөний аюулгүй байдал, жолооны сургалтын чанарыг сайжруулах, хөдөлгөөнд оролцогч жолооч нарын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх ажил зайлшгүй шаардлагатай байна. Гэмт хэргийн улмаас нас барсан хүний 91.3 хувь нь 24 цагийн дотор, 7.7 хувь нь 30 хоногийн дотор, 1.1 хувь нь 30-аас дээш хоногт эмнэлэгийн тусламж авсан байна. Харин эмчилгээний зардлаа нөхөн төлүүлэх, нийгмийн хамгааллын байгууллагад хандсан талаар ямар ч мэдээлэл Цагдаагийн байгууллагад одоогоор алга байна.

Зураг 4.2.12 Нас барсан иргэд, гэмт хэргийн төрлөөр, 2011-2013 он




Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Нас барсан иргэдийг байршлаар авч үзвэл 2013 оны байдлаар 38.8 хувь нь Улаанбаатар хотын, 30.3 хувь нь Төвийн бүсийн, 16.8 хувь нь Хангайн бүсийн, 8.3 хувь нь Зүүн бүсийн, 5.8 хувь нь Баруун бүсийнх байна.

2012 онд нас барсан нийт иргэдийн 472 буюу 52.4 хувийг Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 369 буюу 41.0 хувийг ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан иргэд эзэлж байсан бол 2013 онд Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 461 болж 11 буюу 2.3 хувиар буурч, харин ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан иргэд 55 буюу 15.0 хувиар нэмэгдсэн байна. Иймд ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийг бууруулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.


Зураг 4.2.13 Нас барсан иргэд, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2007-2013 он



2013 оны байдлаар нийт хохирогч иргэдийн 31.8 хувь нь ажилгүй, 8.7 хувь нь оюутан, сурагчид, 8.3 хувь нь төрийн албан хаагчид байна.

2010–2013 оны байдлаар Монгол Улсын нийт ажилгүй иргэдийн 6.6-8.4 хувь нь гэмт хэргийн хохирогчоор Цагдаагийн байгууллагад бүртгүүлсэн байна.

Зураг 4.2.14 Гэмт хэргийн гаралт болон хохирогч ихтэй аймгууд, 2013 он




Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Нийт хохирогч иргэдийн дүнд гэмт халдлагад өртсөн гадаад орны иргэдийн эзлэх хувь 2010 онд 0.7 хувь, 2011 онд 0.6 хувь, 2012 онд 0.6 хувь, 2013 онд 0.5 хувь байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон гадаад иргэдийн тоо 2013 оны эцэст 126 болж, өмнөх оныхоос 5-аар өсөхөд Хятад, ОХУ, АНУ-ын гэмт халдлагад өртсөн иргэдийн тоо буурсан хэдий ч БНСУ-ын иргэдийн тоо өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 4.2.15 Гэмт халдлагад өртсөн гадаад орны иргэд, 2010-2013 он




Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч Агентлаг Цагдаагийн ерөнхий газар

ГЭМТСЭН ИРГЭД

Эрүүгийн гэмт хэргийн улмаас сүүлийн 7 жилд нийт 59267 иргэн гэмтсэний 20154 буюу 34.1 хувь нь эмэгтэйчүүд, 4603 буюу 7.8 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Жил тутам дунджаар 8467 хүн гэмтсэний 2879 нь эмэгтэй, 658 нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна.

Зураг 4.2.16 Гэмтсэн иргэд, сүүлийн 7 жилд



Сүүлийн 7 жилд гэмтсэн хүмүүсийн 36225 буюу 61.1 хувь нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, 7144 буюу 12.1 хувь нь Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 9702 буюу 16.4 хувь нь Нийгмийн аюулгүй байдлын эсрэг, 2690 буюу 4.5 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас гэмтэж бэртсэн байна.

Гэмтсэн хүний тоо 2013 онд өмнөх оныхоос өсөхөд Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 917 буюу 17.1 хувь, ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг 204 буюу 18.9 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 4.2.10 Гэмтсэн иргэд, гэмт хэргийн төрлөөр, 2007-2013 он

д/д	Гэмт хэргийн зүйл анги	Гэмтсэн хүний тоо													
		2007		2008		2009		2010		2011		2012		2013	
		Нийт	Эм	Нийт	Эм	Нийт	Эм	Нийт	Эм	Нийт	Эм	Нийт	Эм	Нийт	Эм
1	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4	3	2	1	5	-	-	-	-	-	-	-	-	-
2	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	4 437	1 415	5 182	1 786	5 479	1 854	4 600	1 704	4 868	1 860	5 371	2 010	6 288	2 412
3	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	-	-	3	3	6	6	1	1	1	1	1	-	-	-
4	Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	202	188	233	198	192	169	154	146	150	142	121	115	112	108
5	Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	36	4	45	9	35	7	31	7	46	12	58	8	81	11
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	374	86	919	143	365	102	233	61	265	76	258	66	276	90
7	Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	1	-	2	2	1	-	3	2	2	-	-	-	-	-
8	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1 497	233	1 496	222	1 284	159	1 242	186	1 416	225	1 302	219	1 465	259
9	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	190	103	236	144	243	135	238	156	195	129	177	128	220	140
10	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	1	-	2	-	1	1	1	-	-	-	1	-	2	1
11	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	945	372	892	307	920	315	933	387	1 094	445	1 078	488	1 282	552
12	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	46	4	60	3	40	3	42	2	55	1	57	3	64	9
13	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	6	-	10	3	6	2	2	1	4	3	5	3	1	1
14	Албан тушаалын гэмт хэрэг	7	-	2	1	7	-	-	-	-	-	-	-	-	-
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	13	-	12	-	9	-	6	-	4	-	7	1	6	-
	Улсын дүн	7 759	2 408	9 096	2 822	8 593	2 753	7 486	2 653	8 100	2 894	8 436	3 041	9 797	3 583

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Жил тутам гэмтсэн нийт иргэдийн 76 орчим хувь нь 18-44 насныхан байгаа ба 18-24 насныхан гэмт хэргийн улмаас хамгийн их гэмтэл авчээ (Хүснэгт 4.2.11).

2013 оны байдлаар нийт гэмтсэн иргэдийн 19.8 хувийг 18-24 насныхан, 19.1 хувийг 25-29 насныхан, 16.0 хувийг 30-34 насныхан эзэлж байгаа нь өмнөх оныхоос 25-29 насныхан 0.6 пункт, 30-34 насныхан 1.0 пункт, 35-39 насныхан 0.9 пунктээр нэмэгдэж, харин 18-24 насныхан 2.7 пунктээр буурсан байна.


2013 онд гэмт хэргийн улмаас 7 хүртэлх насны 114 хүүхэд гэмтэж бэртсэн нь 2007 оныхоос 2 дахин их, өмнөх оныхоос 34.1 хувиар өссөн байна. Иймд бага насны хүүхдийг харж хамгаалах, ялангуяа зам тээврийн ослоос сэргийлэх ажлыг идэвхжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 4.2.11 Гэмтсэн иргэд, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2010-2013 он

д/д	Насны бүлэг	ГЭМТСЭН ХҮНИЙ ТОО				ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ			
		2010	2011	2012	2013	2010	2011	2012	2013
1	7 хүртэлх	69	86	85	114	0.9	1.1	1.0	1.2
2	8-13	141	194	188	182	1.9	2.4	2.2	1.9
3	14-17	358	421	435	425	4.8	5.2	5.2	4.3
4	18-24	1 611	1 945	1 902	1 937	21.5	24.0	22.5	19.8
5	25-29	1 327	1 478	1 558	1 875	17.7	18.2	18.5	19.1
6	30-34	1 126	1 073	1 269	1 565	15.0	13.2	15.0	16.0
7	35-39	878	979	981	1 228	11.7	12.1	11.6	12.5
8	40-44	723	697	747	830	9.7	8.6	8.9	8.5
9	45-49	530	532	534	657	7.1	6.6	6.3	6.7
10	50-54	333	317	380	498	4.4	3.9	4.5	5.1
11	55-59	177	170	180	227	2.4	2.1	2.1	2.3
12	60-64	93	92	74	106	1.2	1.1	0.9	1.1
13	65-69	43	56	40	70	0.6	0.7	0.5	0.7
14	70 ба түүнээс дээш	77	60	63	83	1.0	0.7	0.7	0.8
15	Улсын дүн	7486	8100	8436	9797	100.0	100.0	100.0	100.0

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Зураг 4.2.17 Гэмтсэн иргэд, гэмтлийн зэргээр, дүнд эзлэх хувиар, 2012-2013 он




■ хөнгөн ■ хүндэвтэр ■ хүнд

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2013 оны байдлаар гэмтсэн хүмүүсийн 77.3 хувь нь хөнгөн, 14.8 хувь нь хүндэвтэр, 7.9 хувь нь хүнд хэлбэрээр гэмтжээ. Гэмтсэн иргэдийн тоо 2012 оныхоос 16.1 хувиар өсөхөд хүнд гэмт хэрэг 0.5 пунктээр өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 4.2.18 Гэмтсэн иргэд, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2007-2013 он


Баримтын судалгаа | 2014



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Гэмтсэн иргэдийг дүнд эзлэх хувь, байршлаар нь авч үзвэл сүүлийн 7 жилийн байдлаар гэмтсэн нийт иргэдийн 49.4-60.6 хувь нь Улаанбаатарт, 15.9-20.7 хувь нь Төвийн бүсэд, 11.3-13.3 хувь нь Хангайн бүсэд, 5.0-9.2 хувь нь Зүүн бүсэд, 5.4-8.3 хувь нь Баруун бүсийнх байна.

Зураг 4.2.19 Хамгийн олон иргэд гэмтсэн аймгууд, 2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2013 онд гэмтсэн иргэдийн тоо 1361 буюу 16.1 хувиар өсөхөд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Орхон аймагт гэмтсэн иргэд их байгаа нь голлон нөлөөлжээ.


2013 онд улсын хэмжээгээр гэмтсэн 9797 иргэдийн 5801 буюу 59.2 хувь нь Улаанбаатар хотын иргэд байна. Улаанбаатар хотын дүүргүүдээс Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүргийн иргэд хамгийн их гэмтсэн байна.

Хүснэгт 4.2.12 Гэмтсэн иргэд, нийслэл, дүүргээр, 2007-2013 он

	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Улсын дүн	7 759	9096	8593	7486	8100	8436	9797
Нийслэл	3 801	5 061	4 724	4 175	4 858	5 032	5 801
Баянгол	605	726	827	786	1 092	1 040	1 186
Баянзүрх	903	956	660	616	590	1 017	1 220
Сүхбаатар	512	1152	727	466	775	685	682
Сонгинохайрхан	691	925	991	736	816	803	1 004
Хан-Уул	350	393	469	495	537	507	626
Чингэлтэй	399	568	691	726	718	617	707
Багануур	155	169	190	153	152	186	176
Багахангай	9	2	16	197	-	1	5
Налайх	177	170	153	-	178	176	195

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Зураг 4.2.20 Гэмтсэн иргэд, гэмт хэргийн төрлөөр, 2011-2013 он




Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2013 оны байдлаар Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн иргэдийн тоо өмнөх оныхоос 45 буюу 3.7 хувь, ТХХАБЖ-ын эсрэг гэмт хэргийнх 15 буюу 2.5 хувиар өссөн байна. (Зураг 4.2.20)

Нийт гэмтсэн иргэдийн 629 буюу 6.4 хувь нь 2013 онд эмнэлэгийн тусламж үйлчилгээнд хамрагджээ.

Зураг 4.2.21 Гэмтсэн иргэд, гэмтлийн зэрэг, дүнд эзлэх хувиар, 2007-2013 он



Хүснэгт 4.2.13 Гэмтсэн иргэд, сонгосон гэмт хэргийн төрлөөр, гэмтлийн зэргээр, 2013 он

Эрүүгийн хуулийн зүйл ангиар	Бүгд	Гэмтлийн зэрэг			
		Эмэгтэй	Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд
Улсын дүн	9797	3583	7574	1446	777
Үүнээс:					
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (91-107)	6288	2412	5446	504	338
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (215-225)	1282	552	300	643	339
Дүнд эзлэх хувиар					
Улсын дүн	100.0	36.6	77.3	14.8	7.9
Үүнээс:					
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (91-107)	100.0	38.4	86.6	8.0	5.4
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (215-225)	100.0	43.1	23.4	50.2	26.4

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Гэмт хэргийн чиг хандлагаас харахад сүүлийн жилүүдэд гэмтсэн иргэдийн дийлэнх нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон ТХХАБЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон байна.


Гэмтлийн зэргээр нь авч үзвэл Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн иргэдийн 86.6 хувь нь хөнгөн, 8.0 хувь нь хүндэвтэр, 5.4 хувь нь хүнд гэмтэл авсан бол ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн иргэдийн 23.4 хувь нь хөнгөн, 50.2 хувь нь хүндэвтэр, 26.4 хувь нь хүнд гэмтэл авчээ.

4.3 “ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БОЛ ОРЧИН ЦАГИЙН БООЛЧЛОЛ”

Гэр бүлийн хүчирхийллийг орчин цагийн боолчлол хэмээн олон улсад үздэг байна. “Боолчлол” гэдэг ойлголт зөвхөн нийгмийн түвшинд яригдахаа больж, гэр бүлийн хүрээлэлд буй болжээ. Монгол айл өрхийн хүрээнд эрхийн дарангуйлал, мөнгө санхүүгийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл байсаар байгааг Монгол Улсын ерөнхийлөгч “Хүчирхийллийн эсрэг нэгдэцгээ” уулзалтанд хэлсэн үгэндээ нэгэнтээ дурьджээ.

2013 оны эцсийн байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас 418 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 116 буюу 21.7 хувиар буурсан хэдий ч 2014 оны эхний хагас жилд 353 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеийнхээс 194 хэрэг буюу 2.2 дахин нэмэгдсэн байна. Энэ нь нэг талаас иргэдийн Цагдаагийн байгууллагад бүртгүүлэх явдал сайжирсан байх талтай боловч нөгөөтэйгүүр гэр бүлийн хүчирхийлэл нийгэмд газар авч, өсч байгаагийн илэрхийлэл юм.


Зураг 4.3.1 Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэд, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч 2013 онд Увс, Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Хэнтий аймагт хамгийн олон байна. Нийт гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэдийн дийлэнх нь Улаанбаатар хотод байна.

Зураг 4.3.2 Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэд, дүүргээр, 2009-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хүснэгт 4.3.1 Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэд, хамаарлаар, 2010-2013 он

д/д	Хохирогч	Гэр бүлийн хүчирхийлэлд автсан нийт хүн				Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хохирогч			
		2010	2011	2012	2013	2010	2011	2012	2013
1	Эхнэр	173	243	260	205	161	234	252	204
2	Нөхөр	44	32	18	19	39	29	18	19
3	Хамтран амьдрагч эмэгтэй	19	32	63	37	18	29	61	34
4	Эмээ	-	-	-	1	-	-	-	1
5	Төрсөн эх	4	3	5	5	2	2	5	5
6	Хадам эх	3	3	7	5	3	3	7	5
7	Төрсөн эгч	1	2	5	4	1	1	5	4
8	Төрсөн эмэгтэй дүү	-	8	9	3	-	8	9	2
9	Төрсөн хүүхэд	12	17	7	9	7	9	5	5
10	Үрчилж авсан хүүхэд	1	-	-	-	-	-	-	-
11	Дагавар хүүхэд	15	18	17	7	6	4	2	1
	Улсын дүн	272	358	391	295	237	319	364	280

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2013 оны эцсийн байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон иргэдийн 64.5 хувийг эхнэр нь, 12.5 хувийг хамтран амьдрагч нь, 6.4 хувийг нөхөр нь, 3.1 хувийг төрсөн хүүхэд нь, 2.4 хувийг дагавар хүүхэд нь эзэлж байна.

Хохирогчдын 63.9 хувь нь 1 жил хүртэл, 14.7 хувь нь 1-3 жилийн туршид хүчирхийлэлд автсан байна. Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэдийн 63.0 хувь нь жилд 1-2 удаа, 2.2 хувь нь байнга хүчирхийлэлд автагддаг байна. Энэ нь зөвхөн Цагдаагийн байгууллагад хандсан гэр бүлийн хүчирхийллийн тоо бөгөөд үүний цаана Цагдаад бүртгэгдээгүй, бүртгүүлэх боломжгүй алслагдмал бүс нутагт амьдарч байгаа, эсвэл биеэ хамгаалж, эрхээ хамгаалах чадваргүй бага насны хүүхэд, охид эмэгтэйчүүд байсаар байгаа нь ойлгомжтой.

Хүснэгт 4.3.2 Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэдийн хамаарал, дүнд эзлэх хувиар, 2012-2013 он

Хамаарал	нэгж	2012 он	2013 он	Өөрчлөлт	
				пункт	↑ ↓
Эхнэр	хувь	66.5	69.5	3.0	↑
Нөхөр	хувь	4.6	6.4	1.8	↑
Хамтран амьдрагч эмэгтэй	хувь	16.1	12.5	-3.6	↓
Төрсөн эх	хувь	1.3	1.7	0.4	↑
Хадам эх	хувь	1.8	1.7	-0.1	↓
Төрсөн эгч	хувь	1.3	1.4	0.1	↑
Төрсөн эмэгтэй дүү	хувь	2.3	1.0	-1.3	↓
Төрсөн хүүхэд	хувь	1.8	3.1	1.3	↑
Дагавар хүүхэд	хувь	4.3	2.4	-1.9	↓
Эмээ	хувь	-	0.3	0.3	↑
Дүн	хувь	100.0	100.0	-	-

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Монгол Улсын ерөнхийлөгч цааш хэлсэн үгэндээ “Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж үздэг болно, хүчирхийлэгч гэм зэмгүй явдаг байсан цаг өнгөрсөн. Энэ 2013 он бол хүчирхийлэгчдийн хувьд сүүлчийн он байх болно. Гэр бүлдээ хүчирхийлэл, зовлон учруулдаг хүн бүхэн хуулийн хариуцлага хүлээх болно” гэжээ.


Монгол Улс 2005 онд батлагдсан “Гэр бүлийн хүчирхийллийн тухай” хууль болон гэр бүлийн хүчирхийллийн тухай олон хөтөлбөр бодлогыг хэрэгжүүлсэн, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа зүйл ч олон байна. Ярьж төлөвлөсөн зүйл олон боловч дорвитой хийгдсэн өөрчлөлт хийгдэхгүй байгаагаас олон иргэд хохирсоор л байна.

Гадаадын олон орны Засгийн газрын төсөвт хохирогчдын хохирлыг барагдуулах, хохирлыг нөхөн сэргээх, хохирогч иргэдийг байршуулах орон байрны зардал ч туссан байдаг байна. Хууль сахиулах байгууллагуудын хувьд ч гэмт этгээдийг хөдөлмөрлүүлэх хэлбэрээр хохирогчийн хохирсон хохирлыг нөхөн төлүүлэх, эрүүл мэндийн зардлыг гаргуулах, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах гэх мэт хэлбэрээр нөхөн төлбөрүүд хийгддэг жишээ байна.

2007-2013 онд гэр бүлийн хүчирхийлэлд жилд дунджаар 278 хүн автжээ. Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэдийн 81.1-86.1 хувь нь бие махбодын, 24.0-33.3 хувь нь сэтгэл санааны, 2.8-11.4 хувь нь бэлгийн хүчирхийлэлд автсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2013 онд 319 хүн хохирсон нь 2012 оныхоос 114 хүн буюу 26.3 хувиар буурчээ (Зураг 4.3.1).

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэр бүл салах, түүнээс улбаалан хүүхэд өнчрөх, хараа хяналтгүй хүүхдийн тоо олшрох зэрэг нийгэмд олон сөрөг үр дагавар бий болсоор байдаг.

Зураг 4.3.3 Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэд, хүчирхийллийн хэлбэрээр, 2008-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Дээрх графикаас харахад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн дийлэнх нь бие махбодын хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэлд өртдөг байна.

4.4 ХОХИРСОН БАЙГУУЛЛАГА

Хүснэгт 4.4.1 Хохирсон байгууллага, гэмт хэргийн төрлөөр, 2012-2013 он


Эрүүгийн хуулийн зүйл анги	Гэмт хэргийн зүйл анги	2012 он				2013 он			
		Хохирогч байгууллага-бүгд	Байгууллагын төрөл			Хохирогч байгууллага-бүгд	Байгууллагын төрөл		
			Төрийн	Төрийн бус	Хувийн		Төрийн	Төрийн бус	Хувийн
145-155	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	94	24	23	47	73	22	9	42
156-176	Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	30	30	-	-	51	49	-	2
177-191	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	2	1	-	1
192-201	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	1	-	-	-	-	-	-
202-214	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	22	21	-	1	15	15	-	-
215-225	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	8	3	-	5	6	3	-	3
230-244	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	7	5	-	2	3	3	-	-
245-262	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2	2	-	-	6	5	1	-
263-273	Албан тушаалын гэмт хэрэг	2	1	1	-	1	1	-	-
274-296	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1	1	-	-	-	-	-	-
Бүгд		167	88	24	55	157	99	10	48

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2012-2013 оны байдлаар улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирол хүлээж буй байгууллагын 87.5-88.5 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг, Аж ахуйн эсрэг, Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн улмаас хохирчээ (Хүснэгт 4.4.1).

Монгол Улсын хэмжээнд 2013 онд 157 байгууллага хохирсон нь өмнөх оныхоос 10 байгууллага буюу 6 хувиар буурчээ. Нийт хохирогч байгууллагын тоо өмнөх оныхоос буурсан хэдий ч Улаанбаатар хот болон Дорноговь аймагт тус бүр 48 байгууллага хохирч, өмнөх оныхоос Дорноговь аймагт 2 дахин, Улаанбаатар хотод 16.2 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 4.4.1 Хохирсон байгууллага, гэмт хэргийн төрөл, дүнд эзлэх хувиар, 2012-2013 он




Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Дорноговь аймгийн 48 байгууллагад 712.1 сая төгрөгийн хохирол учирсан бол нийслэлийн 48 байгууллагад 529.1 сая төгрөгийн хохирол учирсан байна. Энэ нь 2013 онд байгууллагад учирсан нийт хохирлын 25.0 хувийг эзэлж байна.

Дорноговь аймгийн байгууллагад учирсан хохирлын зонхилох хэсгийг хууль бусаар хил нэвтрүүлэх, татвараас зайлсхийх хэргүүд эзэлдэг ба энэ нь тус аймгийн хувьд хил гаалийн асуудлаас болж байгууллагууд олноор хохирдогтой холбоотой. Харин Улаанбаатар хотын Багануур дүүрэгт ихэвчлэн уурхайд хулгайн хэргүүд, Сонгинохайрхан дүүрэгт татвараас зайлсхийх хэргийн улмаас хохирох явдал нийтлэг

тохиолддог байна. Байгууллагын хэлбэрээр нь авч үзвэл төрийн байгууллага зонхилж байгаа ба өмчийн хэлбэрийн хувьд төрийн өмчийн аж ахуйн нэгж голчлон хохирогч байгууллагаар бүртгүүлдэг байна.

Зураг 4.4.2 Хохирогч байгууллага, төрлөөр, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2008 онд хохирогч байгууллагын тоо 2007 оныхоос 7.0 хувиар өсөж, харин сүүлийн жилүүдэд буурсаар байна.

Гэмт хэрэг өөрөө нийгмийн сөрөг үр дагавар гэдгийг манай хүмүүс сайн мэддэг хэдий ч өнөөдрийн байдлаар Цагдаагийн ерөнхий газрын албан ёсны ба захиргааны мэдээллийн эх үүсвэрээс гэмт хэрэгтэн болон хохирогчийн сарын орлого, амьжиргаа, ажил эрхлэлтийн байдлын талаар анализ, дүн шинжилгээ хийхүйц мэдээлэл дутагдалтай байсаар байна.

Хохирогчдын хэдэн хувь нь ажилгүй, хэд нь ядуу, хэдэн нь өмгөөлөгч авдаг, хэд нь хамгаалах байраар үйлчлүүлдэг, хэд нь сэтгэл зүйчид очдог, хэд нь нийгмийн хамгаалалд хамрагддаг гэх мэтчилэн нийгмийн олон нарийн асуудлын талаар мэдээлэл хомсдолтой байна. Бусад нийгмийн салбарууд болон хууль сахиулах байгууллагуудын мэдээлэлтэй уялдаа холбоо бага байгаа нь анализ, дүн шинжилгээ хийхэд хүндрэл бэрхшээл учруулж байна.

4.5 ХОХИРОГЧИЙН ДҮР ТӨРХ, ГЭМТ ХЭРГИЙН ТӨРЛӨӨР


Энэ бүлэгт Эрүүгийн гэмт хэргийн улмаас хохирч буй иргэдийн дүр төрхийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн холбогдох бүлгүүдээр тодорхойлохыг зорилго.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилго нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтөний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино. Монгол Улсын Эрүүгийн хууль энэ зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд хүн, төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тогтооно. Одоогийн мөрдөгдөж буй Монгол Улсын Эрүүгийн хууль нь 16 бүлэг, 236 зүйлтэй.

Хүснэгт 4.5.1 Хохирогч иргэд, гэмт хэргийн төрлөөр, 2007-2013 он

д/д	Гэмт хэргийн зүйл анги	Хохирогч иргэн						
		2007	2008	2009	2010	2011	2012	2013
	Улсын дүн	19 931	20 256	19 545	19 381	18 592	21 294	25 015
1	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	18	11	12	2	1	4	1
2	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	5 930	6 599	6 948	6 828	6 500	7 167	8 285
3	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	27	24	27	38	23	36	52
4	Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	382	411	378	395	413	383	408
5	Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	57	90	62	62	70	116	126
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	9 723	9 495	8 490	7 928	7 070	8 838	11 012
7	Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	14	41	31	51	31	67	95
8	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1 843	1 703	1 520	1 766	1 904	1 753	1 927
9	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	198	251	277	300	234	216	273
10	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	23	56	58	102	159	284	262
11	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1 446	1 326	1 480	1 690	1 950	2 122	2 293
12	Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	3	-	-	-
13	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	123	157	173	154	163	234	203
14	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	42	50	50	42	57	52	59
15	Албан тушаалын гэмт хэрэг	37	27	25	11	12	8	10
16	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	68	15	14	9	5	14	9
Дүнд харьцуулсан хувь								
	Улсын дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
1	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0.1	0.1	0.1	-	-	-	-
2	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	29.8	32.6	35.5	35.2	35.0	33.7	33.1
3	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	0.1	0.1	0.1	0.2	0.1	0.2	0.2
4	Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	1.9	2.0	1.9	2.0	2.2	1.8	1.6
5	Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	0.3	0.5	0.3	0.3	-	0.6	0.5
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	48.8	46.9	43.4	40.9	38.0	41.5	44.0
7	Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	0.1	0.2	0.2	0.3	0.2	0.3	0.4
8	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	9.2	8.4	7.8	9.1	10.3	8.2	7.7
9	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1.0	1.2	1.4	1.6	1.3	1.0	1.1
10	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	0.1	0.3	0.3	0.5	0.9	1.3	1.1
11	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	7.3	6.5	7.6	8.7	10.5	10.0	9.2
12	Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-
13	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	0.6	0.8	0.9	0.8	0.9	1.1	0.8
14	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	0.2	0.2	0.3	0.2	0.3	0.2	0.2
15	Албан тушаалын гэмт хэрэг	0.2	0.1	0.1	0.1	0.1	-	0.1
16	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	0.3	0.1	0.1	0.1	-	0.1	-

Зураг 4.5.1 Хохирогч иргэд, гэмт хэргийн төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2007-2013 он




Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хохирогч иргэдийн дийлэнх нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хохирогчид байна (Хүснэгт 4.5.1).

2007-2013 онуудад гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 93.4-95.1 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг, Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг, Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирчээ. Өөрөөр хэлбэл жил тутмын хохирсон иргэдийн 93.4-95.1 хувь нь дээрх 4 зүйл ангийн гэмт хэргийн улмаас хохирсон байна (Зураг 4.5.1).

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 19 дүгээр бүлгийн “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” буюу 145-155 дугаар зүйлд заасан гэмт хэргийн үлмаас хохирсон иргэн, учирсан хохирол, нөхөн төлүүлэлтийн талаар

Зураг 4.5.2 “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, сүүлийн 7 жилд



Сүүлийн 7 жилийн байдлаар Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2011 онд хамгийн бага бүртгэгдсэн бол 2013 онд 11118 болж, 2012 оныхоос 2095 хэрэг буюу 23.2 хувиар өсөхөд энэ төрлийн гэмт хэргийн 70.9 хувийг эзэлж буй хулгайн хэрэг 1618-аар, халаасны хулгайн хэрэг 177-оор, бусдын хөрөнгийг залилан мэхэлж авах хэрэг 133-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдхүүнд ордог ихэнх хэргүүд сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай хэдий ч авто тээврийн хэрэгсэл хулгайлах хэрэг 21.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 4.5.2 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, насны бүлэг, хүйсээр, 2007-2013 он

Он	Хохирогч иргэн	Үүнээс: Эмэгтэй	Насны бүлгээр													
			7 хүртэлх	8-13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70 ба түүнээс
2007 он	9 764	3 038	0	56	274	991	1 712	1 450	1362	1 253	983	670	347	267	199	200
2008 он	9 495	2 806	1	51	194	986	2 003	1 382	1331	1 071	930	654	338	228	177	149
2009 он	8 490	2 781	2	29	173	840	1 435	1 343	1261	1 014	929	624	362	214	139	125
2010 он	7 928	3 099	2	27	158	909	1 090	1 205	1196	1 025	832	630	343	202	136	173
2011 он	7 070	2 747	1	63	146	885	1 032	1 046	1039	834	744	527	334	185	122	112
2012 он	8 838	3 508	6	69	194	1 197	1 359	1 337	1275	1 027	900	628	343	223	135	145
2013 он	11 012	4 645	1	124	248	1 399	1 735	1 740	1530	1 235	1 068	807	489	265	180	191


Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агаар Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 7 жилийн байдлаар Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас жилд дунджаар 8942 иргэн хохирчээ.

2013 онд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас 11012 иргэнд 72.8 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирсон иргэдийн 44.0 хувь, учирсан хохирлын 45.8 хувийг эзэлж байна. Харин учирсан хохирлын 31.9 тэрбум төг буюу 43.8 хувийг нөхөн төлүүлжээ.

Хохирсон иргэдийн 4645 буюу 42.2 хувь нь эмэгтэйчүүд, 373 буюу 3.4 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Энэ бүлгийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 80 орчим хувь нь 18-49 насныхан байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо өмнөх оныхоос 2174 буюу 25.0 хувиар өссөн байна.

Зураг 4.5.3 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс хамгийн олон иргэд хохирсон аймгууд, 2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Улсын хэмжээнд 2013 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас 11012 иргэн хохирсны 4.9 хувь нь Баруун бүсийнх, 12.3 хувь нь Хангайн бүсийнх, 12.8 хувь нь Төвийн бүсийнх, 6.6 хувь нь Зүүн бүсийнх, 62.8 хувь нь Улаанбаатар хотын иргэд байна.


2013 онд энэ бүлгийн гэмт хэргийн улмаас Улаанбаатар хотын 6918 иргэн хохирсоны 5238 буюу 75.8 хувь нь Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол, Сүхбаатар дүүргийн иргэд байна. Баянзүрх дүүрэгт 1755 иргэн хохирсон нь нийслэлийн дүүргүүдээс хамгийн олон иргэн хохирсон дүүрэг байна.

Энэ бүлгийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 20.8 хувь нь Төв, Дорнод, Дархан-Уул, Хөвсгөл, Орхон, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгуудынх, 62.8 хувь нь Улаанбаатар хотын иргэд байна.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд учирсан хохирлын 61.4 тэрбум төг буюу 84.4 хувь нь Улаанбаатар хотын иргэд, байгууллагад учирсан хохирол байна. Дүүргүүдээс Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уулд хамгийн их хохирол учирсан ба Баянзүрх дүүрэг учирсан хохирлын 34.5 хувь, Сүхбаатар дүүрэг 18.1 хувь, Хан-Уул дүүрэг 95.3 хувийг тус тус нөхөн төлүүлсэн байна.

Аймгуудаас энэ онд хамгийн их хохирол учирсан аймаг нь Төв, Өмнөговь, Булган, Дорнод, Хэнтий аймгууд байна. Төв аймаг учирсан хохирлын 66.6 хувь, Хэнтий аймаг 58.6 хувь, Дорнод аймаг 38.2 хувь, Өмнөговь аймаг 34.9 хувийг нөхөн төлүүлжээ.

Зураг 4.5.4 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, насны бүлэг, 2012-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хүснэгт 4.5.3 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, нийгмийн байдлаар, 2010-2013 он

Он	Нийгмийн байдал											
	Төрийн албан хаагч	Үүнээс: Цагдаа	Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	Төрийн бус байгууллагын ажилтан	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Малчин	Оюутан	Сурагч	Сургууль завсардсан	Тэнэмэл	Хоригдол	Ажилгүй
2010 он	619	26	1063	221	1257	1967	296	163	1	0	5	2336
2011 он	431	19	919	181	1150	1946	244	150	1	1	2	2045
2012 он	684	21	1404	343	2146	1550	348	194	1	1	10	2157
2013 он	819	37	1633	458	3121	1610	526	267	2	1	10	2565

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2010-2013 оны байдлаар Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 23.0-29.0 хувийг ажилгүй иргэд эзэлж байна.

2013 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн дүнд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь өмнөх оныхоос 4.0 пунктээр нэмэгджээ.

Зураг 4.5.5 Нийт хохирогч иргэд ба сонгосон зүйл ангийн хохирогч иргэд, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2007-2013 оны байдлаар нийт бүртгэгдсэн гэмт хэргийн дүнд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 37.7-51.1 хувь байхад нийт хохирогч иргэдийн дүнд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн эзлэх хувь мөн л 38.0-48.8 хувийг эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хувьд бусад гэмт хэргийн зүйл

ангитай харьцуулахад нас барсан, гэмтсэн хохирол бага эдийн засаг, хөрөнгө мөнгөний хохирол илүү учирдаг онцлогтой.

Зураг 4.5.6 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, сүүлийн 7 жилд




Хүснэгт 4.5.4 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс хохирсон байгууллага, төрлөөр, 2007-2013 он

Он	Хохирогч байгууллага	Байгууллагын төрөл			Дүнд эзлэх хувь			
		Төрийн	Төрийн бус	Хувийн	Хохирогч байгууллага	Төрийн	Төрийн бус	Хувийн
2007 он	800	338	60	402	100.0	42.3	7.5	50.3
2008 он	715	228	143	344	100.0	31.9	20.0	48.1
2009 он	451	161	43	247	100.0	35.7	9.5	54.8
2010 он	196	86	45	65	100.0	43.9	23.0	33.2
2011 он	87	40	13	34	100.0	46.0	14.9	39.1
2012 он	94	24	23	47	100.0	25.5	24.5	50.0
2013 он	73	22	9	42	100.0	30.1	12.3	57.5
Дүн	2416	899	336	1181	100.0	37.2	13.9	48.9

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Зураг 4.5.7 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс хохирсон байгууллага, төрлөөр, 2007-2013 он




Хүснэгт 4.5.5 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2010-2013 он

Он	Учирсан хохирол сая.төг								Нөхөн төлүүлсэн хохирол сая.төг	Үүнээс:	
	Нийт	Гэмт хэргийн ангилал				Өмчийн хэлбэр				Хэрэг бүртгэлийн шатанд	Мөрдөн байцаалтын шатанд
		Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд	Онц хүнд	Төрийн	Орон нутгийн	Хувийн өмчид			
2010 он	20135.9	1933.2	9624.7	4890.7	3687.3	974.2	40.9	19113.7	8,041.0	1033.5	7007.5
2011 он	20258.6	2028.1	8929.0	2613.9	6687.6	1224.1	145.6	18888.9	9036.4	1000.9	8035.5
2012 он	28848.0	3330.4	11263.5	4715.7	9538.4	872.0	197.3	27778.7	12980.2	1638.0	11342.2
2013 он	72778.5	4411.5	15242.3	28696	24429	9226.3	4407.5	59144.7	31896.3	2288.5	29607.8


Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Зураг 4.5.8 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс учирсан хохирол, гэмт хэргийн ангиллаар, 2010-2013 он



Сүүлийн 4 жилд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 4.4 тэрбум төг буюу 8.2 хувийг хөнгөн, 15.2 тэрбум төг буюу 31.7 хувийг хүндэвтэр, 28.7 тэрбум төг буюу 28.8 хувийг хүнд, 24.4 тэрбум төг 31.2 хувь нь онц хүнд гэмт хэргийн улмаас учирсан хохирол байна.

Зураг 4.5.9 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс учирсан хохирлын нөхөн төлүүлэлт, тэрбум. төг, 2010-2013 он



Хүснэгт 4.5.6 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2012-2013 он

Зүйланги	2012 он			2013 он		
	Хохирогч иргэн	Учирсан хохирол сая төг	Нөхөн төлүүлэлт. сая. төг	Хохирогч иргэн	Учирсан хохирол сая төг	Нөхөн төлүүлэлт. сая. төг
145-155	8838	28848.0	12980.2	11012	72778.5	31896.3
145	6179	12246.5	6116.4	7899	13258.3	5403.2
Үүнээс	145.1	1996	1737.9	769.0	2549.4	1043.6
	145.2	4050	7171.5	2819.1	9364.1	3418.7
	145.3	96	599.32	487.7	27	545.8
	145.4	37	2737.8	2040.7	29	798.9
	145.4	37	2737.8	2040.7	29	798.9
Үүнээс	Хувийн өмч	4043	7695.7	3649.5	5810	8629.0
	Үүнээс: Халаасны хулгай	241	160.1	59.3	411	260.5
	Малын	1369	3248.7	1952.2	1514	3996.2
	Авто тээврийн хэрэгсэл	175	537.7	225.8	141	326.53
146	179	214.6	121.6	219	185.2	109.3
147	553	483.9	221.2	609	435.3	223.0
148	1073	12133.2	4456.1	1191	30082.3	17875.8
150	222	2577.3	1373.0	257	11270.4	1592.2
152	168	325.6	216.2	172	383.4	265.2

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас 2013 онд 11012 иргэнд 72.8 тэрбум төгрөгийн хохирол учирч Цагдаагийн байгууллагын шатанд 31.9 тэрбум буюу 43.8 хувийг нь нөхөн төлүүлжээ. Энэ нь өмнөх оныхоос 1.2 пунктээр буурч, харин хохирсон иргэний тоо, учирсан хохирлын хэмжээ өмнөх оныхоос нэмэгдсэн байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол нэмэгдэхэд Бусдын эд хөрөнгийг хулгайлах, Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах зэрэг хэргийн хохирол өссөн нь голлон нөлөөлжээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15 дугаар бүлгийн “Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг” буюу 91-107 дугаар зүйлд заасан гэмт хэргүүдийн улмаас хохирсон иргэн, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт

Сүүлийн 7 жилийн байдлаар хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас жилд дунджаар 6894 иргэн хохирчээ (Хүснэгт 4.5.7).

2013 онд хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас 8285 иргэнд 3.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирсон иргэдийн 33.1 хувь, учирсан хохирлын 2.5 хувийг эзэлж байна. Харин учирсан хохирлын 3.3 тэрбум төгрөг буюу 84.2 хувийг нөхөн төлүүлжээ.

Хүснэгт 4.5.7 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, насны бүлэг, хүйсээр, 2007-2013 он


Он	Хохирсон иргэн	Үүнээс: Эмэгтэй	Насны бүлгээр													
			7 хүртэлх	8-13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70 ба түүнээс
2007 он	5930	1 746	37	33	220	943	1 276	905	825	616	488	275	129	78	47	58
2008 он	6599	2 081	79	61	223	1 215	1 315	999	895	726	506	267	143	77	35	58
2009 он	6948	2 298	68	47	235	1 291	1 364	1 076	920	701	569	323	167	68	59	60
2010 он	6828	2 390	48	57	238	1 316	1 233	1 069	894	721	575	338	146	81	38	74
2011 он	6500	2 424	38	69	268	1 412	1 183	993	832	606	485	322	141	78	42	31
2012 он	7167	2 664	30	66	295	1 456	1 374	1 128	958	658	546	369	157	58	31	41
2013 он	8285	3 209	47	61	290	1 513	1 641	1 449	1 116	785	587	445	173	82	41	55

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хохирсон иргэдийн 3209 буюу 38.7 хувь нь эмэгтэйчүүд, 398 буюу 4.8 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Энэ бүлгийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 86 орчим хувь нь 18-49 насныхан байна. Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо өмнөх оныхоос 1118-аар буюу 15.6 хувиар өссөн байна.

Хохирогчийн тоо өсөхөд бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийн хохирогч өмнөх оныхоос 10 буюу 83.3 хувиар, Бусдын бие махбодид гэмтэл учруулах хэргийн хохирогч 17 буюу 13.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 4.5.10 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс хамгийн олон иргэд хохирсон аймгууд, 2013 он




Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Улсын хэмжээнд 2013 онд Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас 8285 иргэн хохирсны 8.0 хувь нь Баруун бүсийнх, 12.9 хувь нь Хангайн бүсийнх, 17.0 хувь нь Төвийн бүсийнх, 5.4 хувь нь Зүүн бүсийнх, 56.2 хувь нь Улаанбаатар хотын иргэд байна.

2013 онд энэ бүлгийн гэмт хэргийн улмаас Улаанбаатар хотод 4657 иргэн хохирсны 3940 буюу 84.6 хувь нь Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэгт байна. Баянзүрх дүүрэгт 1047 иргэн хохирсон нь бусад дүүргүүдээс хамгийн олон байна.

Энэ бүлгийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 23.4 хувь нь Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Баян-Өлгий, Өвөрхангай, Орхон, Дорнод, Дорноговь аймгуудынх, 56.3 хувь нь Улаанбаатар хотын иргэд байна (Зураг 4.5.10).

Зураг 4.5.11 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, насны бүлгээр, 2012-2013 он




Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд учирсан хохирлын 2.2 тэрбум төгрөг буюу 56.5 хувь нь Улаанбаатар хотод үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас үүссэн хохирол байна.

2013 онд Төв, Өвөрхангай, Орхон, Архангай, Хөвсгөл аймгуудад энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ бусад аймгуудынхаас их байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт Төв аймагт 94.5 хувь, Өвөрхангай аймагт 90.4 хувь, Орхон аймагт 80.5 хувь, Архангай аймагт 80.8 хувь, Хөвсгөл аймагт 83.3 хувьтай байна.

Зураг 4.5.12 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, 2007-2013 он



Хүснэгт 4.5.8 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, 2010-2013 он

Он	Хохирсон иргэн	Нийгмийн байдал										
		Төрийн албан хаагч	Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	Төрийн бус байгууллагын ажилтан	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Малчин	Оюутан	Сурагч	Сургууль завсардсан	Тэнэмэл	Хоригдол	Ажилгүй
2010 он	6 828	351	638	125	589	1 173	381	264	3	25	15	3 264
2011 он	6 500	306	660	115	648	1 196	312	245	5	17	7	2 989
2012 он	7 167	407	903	192	1 110	720	362	259	3	21	24	3 166
2013 он	8 285	518	1 047	283	1 618	719	410	277	2	20	29	3 362

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2010-2013 оны байдлаар хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 40.6-47.8 хувийг ажилгүй иргэд эзэлж байна.

2013 онд хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн дүнд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь өмнөх оныхоос 4.0 пункт, төрийн албан хаагчдынх 0.6 пункт, төрийн бус байгууллагын ажилтан 0.7 пунктээр өссөн байна.


Хүснэгт 4.5.9 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, боловсролын түвшингээр, 2010-2013 он

Он	Хохирсон иргэн	Боловсролын түвшин						
		Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
2010 он	6 828	337	609	799	3534	42	264	1243
2011 он	6 500	170	501	987	3310	21	240	1271
2012 он	7 167	202	543	1385	3196	4	306	1531
2013 он	8 285	290	593	1618	3492	6	332	1954

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 13532 буюу 47.0 хувь нь бүрэн дунд боловсролтой, 5999 буюу 20.8 хувь нь дээд боловсролтой, 4789 буюу 16.6 хувь нь суурь боловсролтой иргэд байна.

Зураг 4.5.13 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, сүүлийн 7 жилд



Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2013 онд 8156 болж, 2012 оныхоос 1001 хэрэг буюу 14.0 хувиар өсөхөд энэ төрлийн гэмт хэргийн 92.6 хувийг эзэлж буй бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 1018-аар өссөн нь голлон нөлөөлөв.

Хүснэгт 4.5.10 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2010-2013 он


Он	Бүгд	Учирсан хохирол. сая төг							Нөхөн төлүүлсэн хохирол сая төг	Үүнээс:	
		Гэмт хэргийн ангилал				Өмчийн хэлбэр				Хэрэг бүртгэлтийн шатанд	Мөрдөн байцаалтын шатанд
		Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд	Онц хүнд	Төрийн	Орон нутгийн	Хувийн			
2010 он	949.6	468.8	228.0	120.9	131.8	0.0	0.0	949.6	710.6	394.3	316.2
2011 он	1,588.7	868.0	273.8	174.4	272.5	0.6	0.4	1,587.7	1,277.7	700.5	577.2
2012 он	2,521.1	1,410.9	559.1	262.0	289.1	3.2	1.0	2,516.9	2,023.6	1,226.5	797.1
2013 он	3,916.4	2,215.1	886.5	432.0	382.8	10.1	2.2	3,904.2	3,299.6	1,998.7	1,300.9

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас сүүлийн 4 жилд 9.0 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь 2010-2013 онд гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 3.2 хувийг эзэлж байна. Нийт учирсан хохирлын 7.3 тэрбум төгрөг буюу 81.1 хувийг нөхөн төлүүлжээ. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас сүүлийн 7 жилд 5627 иргэн амь насаа алдаж, 36235 иргэн гэмтжээ.

2013 онд нийт учирсан хохирлын 3.9 тэрбум төгрөг буюу 2.4 хувь нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол байгаа бөгөөд 3.3 тэрбум төгрөг буюу 84.6 хувийг нь нөхөн төлүүлжээ.

Зураг 4.5.14 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс учирсан хохирол, гэмт хэргийн ангиллаар, 2010-2013 он



Сүүлийн 4 жилд Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 5.0 тэрбум төг буюу 55.3 хувийг хөнгөн, 1.9 тэрбум төг буюу 21.7 хувийг хүндэвтэр, 0.9 тэрбум төг буюу 11.0 хувийг хүнд, 1.1 тэрбум төгрөг 12.0 хувь нь онц хүнд гэмт хэргийн улмаас учирсан хохирол байна.


Хүснэгт 4.5.11 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2012-2013 он

Зүйл хэсэг	2012 он			2013 он			
	Хохирогч иргэн	Учирсан хохирол сая төг	Нөхөн төлүүлэлт сая төг	Хохирогч иргэн	Учирсан хохирол сая төг	Нөхөн төлүүлэлт сая төг	
91-107	7 167	2 521.1	2 023.6	8 285	3 916.4	3 299.6	
Үүнээс	91	233	293.3	196.8	208	315.7	
	94	12	35.0	34.5	22	3.0	
	95	284	77.6	61.4	292	70.1	
	96-100	6 607	2 092.5	1 723.8	7 728	2 871.5	
	Үүнээс	96	354	256.8	201.3	352	306.9
		97	15	12.9	12.3	32	31.7
		98	474	280.1	204.5	546	315.7
		99	5 734	1 539.3	1 303.4	6 764	2 189.2
		100	30	3.4	2.4	34	28.0
	106	22	22.2	6.7	27	34.3	
Бусад	9	0.6	0.5	8	6.0	5.0	

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас 2013 онд 8285 иргэнд 3.9 тэрбум төгрөгийн хохирол учирсны 3.3 тэрбум төгрөг буюу 84.6 хувийг нь нөхөн төлүүлжээ. Энэ нь өмнөх оныхоос 1.3 сая төг буюу 63.1хувиар нэмэгдсэн байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол нэмэгдэхэд Хүнийг санаатай алах, Бусдын бие махбодид гэмтэл учруулах, Бусдыг амиа хорлоход хүргэх (91, 95, 96-100 дугаар зүйл анги) хэргийн улмаас учирсан хохирол өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 4.5.15 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс учирсан хохирлын нөхөн төлүүлэлт, тэрбум төг, 2010-2013 он



Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21 дүгээр бүлгийн “Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” буюу 177-191 дүгээр зүйлд заасан гэмт хэргүүдийн улмаас хохирсон иргэн, учирсан хохирол, нөхөн төлүүлэлтийн талаар

Зураг 4.5.16 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, 2007-2013 он



Хүснэгт 4.5.12 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, насны бүлгээр, 2007-2013 он

Он	Хохирсон иргэн	Үүнээс: Эмэгтэй	Насны бүлгээр													
			7 хүртэлх	8-13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70 ба түүнээс
2007 он	1 843	286	2	4	80	450	457	299	213	131	94	61	26	9	12	5
2008 он	1 703	261	4	8	63	393	387	279	232	139	89	56	27	12	6	8
2009 он	1 520	197	0	3	72	404	353	230	179	114	80	49	15	7	7	7
2010 он	1 766	271	2	10	83	487	382	258	183	154	95	57	26	13	5	11
2011 он	1 904	316	4	9	112	597	375	258	212	134	100	52	25	13	6	7
2012 он	1 753	304	6	11	98	537	358	253	178	135	82	52	22	10	5	6
2013 он	1 927	344	4	8	90	541	429	287	214	144	105	50	27	14	8	6


Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 7 жилийн байдлаар нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас жилд дунджаар 1774 иргэн хохирчээ.

2013 онд нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 1927 иргэнд 1.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь нийт хохирсон иргэдийн 7.7 хувь, учирсан хохирлын 0.8 хувийг эзэлж байна. Нийт учирсан хохирлын 1.0 тэрбум төгрөг буюу 76.9 хувийг нөхөн төлүүлжээ.

Хохирсон иргэдийн 344 буюу 17.9 хувь нь эмэгтэйчүүд, 102 буюу 5.3 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Энэ бүлгийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 89.3 орчим хувь нь 18-49 насныхан байна. Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо өмнөх оныхоос 174-өөр буюу 9.9 хувиар өссөн байна.

Зураг 4.5.17 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс хамгийн олон иргэд хохирсон аймгууд, 2013 он




Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Улсын хэмжээнд 2013 онд Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 1927 иргэн хохирсны 2.3 хувь нь Баруун бүсийнх, 4.2 хувь нь Хангайн бүсийнх, 10.3 хувь нь Төвийн бүсийнх, 5.8 хувь нь Зүүн бүсийнх, 77.2 хувь нь Улаанбаатар хотын иргэд байна.

2013 онд энэ бүлгийн гэмт хэргийн улмаас Улаанбаатар хотод 1487 иргэн хохирсны 1444 буюу 97.1 хувь нь Баянзүрх, Сонгино хайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул дүүрэгт байна. Баянзүрх дүүрэгт 418 иргэн хохирсон нь бусад дүүргээс олон байна. Энэ бүлгийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 18.5 хувь нь дээрх аймгуудынх, 77.2 хувь нь Улаанбаатар хотын иргэд байна (Зураг 4.5.17).

Зураг 4.5.18 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, насны бүлгээр, 2012-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд учирсан хохирлын 0.7 тэрбум төгрөг буюу 53.8 хувь нь Улаанбаатар хотод үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас үүссэн хохирол байна.

Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт бусад дүүргээс их хохирол учирсан ба Баянзүрх дүүрэгт үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 72.2 хувь, Сонгинохайрхан дүүрэгт учирсан хохирлын 85.3 хувь, Баянгол дүүрэгт учирсан хохирлын 57.7 хувийг тус тус нөхөн төлүүлсэн байна. 2013 онд Ховд, Төв, Дархан-Уул, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон аймгуудад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ бусад аймгуудаас их байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт Ховд аймагт 99.7 хувь, Төв аймагт 92.6 хувь, Дархан-Уул аймагт 100.0 хувь, Өвөрхангай аймагт 97.6 хувь, Хөвсгөл аймагт 100.0 хувь, Орхон аймагт 86.2 хувьтай байна.

Хүснэгт 4.5.13 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, 2010-2013 он

Он	Хохирсон иргэн	Нийгмийн байдал										
		Төрийн албан хаагч	Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	Төрийн бус байгууллагын ажилтан	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Малчин	Оюутан	Сурагч	Сургууль завсардсан	Тэнэмэл	Хоригдол	Ажилгүй
2010 он	1 766	113	187	21	165	284	154	80	4	3	4	751
2011 он	1 904	80	178	12	192	301	149	63	0	1	7	921
2012 он	1 753	75	262	39	312	87	135	66		2	11	764
2013 он	1 927	101	270	68	452	84	156	69	1	3	15	708

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агетлаг Цагдаагийн ерөнхий газар

2010-2013 оны байдлаар нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 36.7-48.4 хувийг ажилгүй иргэд эзэлж байна.

2013 онд нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн дүнд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь өмнөх оныхоос 5.7 пункт, төрийн бус байгууллагын ажилтных 1.3 пункт, төрийн албан хаагчийнх 1.0 пунктээр нэмэгдсэн боловч ажилгүй иргэдийнх 6.8 пунктээр буурсан байна.


Хүснэгт 4.5.14 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, боловсролын түвшингээр, 2010-2013 он

Он	Хохирсон иргэн	Боловсрол							
		Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд	
2010 он	1 766	71	138	230	967	8	55	297	
2011 он	1 904	36	104	355	1019	7	45	338	
2012 он	1 753	44	83	358	861	3	70	334	
2013 он	1 927	57	100	350	925		63	432	

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агетлаг Цагдаагийн ерөнхий газар

Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл сүүлийн 4 жилд 3772 иргэн буюу 51.3 хувь нь бүрэн дунд боловсролтой, 1401 иргэн буюу 19.1 хувь нь дээд боловсролтой, 1293 иргэн буюу 17.6 хувь нь суурь боловсролтой иргэд байна.


Зураг 4.5.19 Нийт хохирогч иргэд ба сонгосон гэмт хэргийн төрлийн хохирогч иргэд, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2007-2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийн дүнд нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7.2-9.8 хувь, харин нийт хохирогч иргэдэд энэ бүлгийн гэмт хэргийн хохирогчийн эзлэх хувь 7.7-10.2 байна. Үүнээс нас барсан хүн 1.0-3.1, гэмтсэн хүн 15.0-19.3, учирсан хохирол 0.4-19.1 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 4.5.20 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, сүүлийн 7 жилд



Сүүлийн 7 жилийн байдлаар улсын хэмжээнд бүртгэгдсэн нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2009 онд бусад оноос бага байна. 2013 онд 1894 болж, 2012 оныхоос 145 хэрэг буюу 8.3 хувиар өссөн байх ба энэ төрлийн гэмт хэргийн 97.1 хувийг эзэлж буй танхайрах хэрэг 152 хэргээр өссөн нь дээрхи өсөлтөнд голлох дүнг эзэлж байна.

Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хамаарах гэмт хэргүүд сүүлийн жилүүдэд өссөн байх ба харин галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлэх хэрэг 75.0 хувиар буурсан байна.


Хүснэгт 4.5.15 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс хохирсон байгууллага, төрлөөр, 2007-2013 он

Он	Хохирогч байгууллага	Байгууллагын төрөл			Дүнд эзлэх хувь			
		Төрийн	Төрийн бус	Хувийн	Хохирогч байгууллага	Төрийн	Төрийн бус	Хувийн
2007 он	16	6	-	10	100.0	37.5	-	62.5
2008 он	22	10	5	7	100.0	45.5	22.7	31.8
2009 он	3	2	0	1	100.0	66.7	0.0	33.3
2010 он	11	9	1	1	100.0	81.8	9.1	9.1
2013 он	2	1	-	1	100.0	50.0	-	50.0

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 2007-2013 онд 54 байгууллага хохирсны 51.9 хувь нь төрийн, 37.0 хувь нь хувийн, 11.1 хувь нь төрийн бус байгууллага байна.

Зураг 4.5.21 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, насны бүлгээр, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хүснэгт 4.5.16 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2010-2013 он


Он	Бүгд	Учирсан хохирол сая.төг							Нөхөн төлүүлсэн хохирол сая.төг	Үүнээс:	
		Гэмт хэргийн ангилал				Өмчийн хэлбэр				Хэрэг бүртгэлтийн шатанд	Мөрдөн байцаалтын шатанд
		Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд	Онц хүнд	Төрийн	Орон нутгийн	Хувийн өмчид			
2010 он	639.1	1.5	331.7	305.8	-	372.2	0.0	266.9	401.4	3.2	398.1
2011 он	538.1	0.6	379.5	157.9	-	-	1.5	525.2	376.4	0.6	375.7
2012 он	727.2	-	498.7	228.5	-	2.3	1.9	723.0	469.4	-	469.4
2013 он	1,256.7	0.9	946.3	308.8	0.8	15.4	-	1,241.4	1,035.0	-	1,035.0

Эх үүсвэр: Засгийн Газрын Тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 4 жилийн байдлаар нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 3.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь нийт хохирлын 1.1 хувийг эзэлж байна. Учирсан хохирлын 2.3 тэрбум төгрөг буюу 71.9 хувь нь нөхөн төлүүлжээ. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас сүүлийн 7 жилд 150 иргэн амь насаа алдаж, 9702 иргэн гэмтжээ.

2013 онд нийт учирсан хохирлын 1.3 тэрбум төг буюу 0.8 хувь нь нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол байгаа бөгөөд 1.0 тэрбум төг буюу 76.9 хувийг нь нөхөн төлүүлжээ.

Зураг 4.5.22 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс учирсан хохирол, гэмт хэргийн ангиллаар, 2010-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 4 жилд Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 3.1 сая төгрөг буюу 0.1 хувийг хөнгөн, 2.2 тэрбум төгрөг буюу 68.2 хувийг хүндэвтэр, 1.0 тэрбум төгрөг буюу 31.6 хувийг хүнд, 8.0 мянган төгрөг 0.1 хувь нь онц хүнд гэмт хэргийн улмаас учирсан хохирол байна.

Зураг 4.5.23 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс учирсан хохирлын нөхөн төлүүлэлт, тэрбум төг, 2007-2013 он



Хүснэгт 4.5.17 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, Эрүүгийн хуулийн төрлөөр, 2013 он

Зүйл хэсэг	2012 он			2013 он		
	Хохирогч иргэн	Учирсан хохирол сая төг	Нөхөн төлүүлэлт сая төг	Хохирогч иргэн	Учирсан хохирол сая төг	Нөхөн төлүүлэлт сая төг
177-191	1 753	727.2	469.4	1 927	1 256.7	1035.0
181	1 713	574.3	379.7	1 896	979.3	771.3
182	3	0.3	0.3	6	11.8	3.5
185	4	0.5	-	5	0.7	0.7
186	1	2.1	-	-	-	-
187	1	8.0	-	-	-	-
Бусад	31	142.0	89.5	20	265.0	259.5

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 2013 онд 1927 иргэнд 1.3 тэрбум төгрөгийн хохирол учирч, Цагдаагийн байгууллагын шатанд 1.0 тэрбум төгрөг буюу 76.9 хувийг нь нөхөн төлүүлжээ. Энэ нь өмнөх оныхоос 12.4 пунктээр нэмэгдсэн байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол нэмэгдэхэд танхайрах хэргийн хохирол нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хотын дүүргүүдээс Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт танхайрах гэмт хэрэг илүү бүртгэгдсэн байна. Энэ нь орон нутгаас нийслэлд шилжин ирэгсдийн дийлэнх нь тус 2 дүүрэгт ирж суурьшдаг төдийгүй бусад дүүргүүдээс олон хүн амтай дүүргүүд тул бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас хохирогчид их байж болох талтай.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлгийн “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын (ТХХАБАЖ) эсрэг гэмт хэрэг” буюу 215-225 дугаар зүйлд заасан гэмт хэргүүдийн улмаас хохирсон иргэн, учирсан хохирол, нөхөн төлүүлэлтийн талаар

Зураг 4.5.24 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, 2007-2013 он



Хүснэгт 4.5.18 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргээс хохирогч иргэд, насны бүлгээр, хүйсээр, 2007-2013 он

Он	Хохирсон иргэн	Эмэгтэй	Насны бүлгээр													
			7 хүртэлх	8--13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70 ба түүнээс
2007 он	1446	483	49	83	63	214	238	149	157	142	132	88	51	30	24	26
2008 он	1326	410	39	58	65	203	236	183	152	118	87	80	36	24	27	18
2009 он	1480	443	45	71	42	214	246	183	177	141	136	95	62	29	20	19
2010 он	1690	644	52	77	52	288	214	214	185	179	150	122	63	41	21	32
2011 он	1950	685	66	81	61	354	294	218	218	197	158	131	64	35	32	41
2012 он	2122	776	91	83	70	373	287	302	248	192	158	123	81	49	29	36
2013 он	2293	821	82	91	73	305	352	302	287	204	190	154	91	67	42	53


Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 7 жилийн байдлаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас жилд дунджаар 1758 иргэн хохирчээ.

2013 онд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 2293 иргэнд 8.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирсон иргэдийн 9.2 хувь, учирсан хохирлын 5.6 хувийг эзэлж байна. Харин учирсан хохирлын 7.1 тэрбум төгрөг буюу 79.8 хувийг нөхөн төлүүлжээ.

Хохирсон иргэдийн 821 буюу 35.8 хувь нь эмэгтэйчүүд, 246 буюу 10.7 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Энэ бүлгийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 71.5 хувь нь 18-49 насныхан байна. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо өмнөх оныхоос 171-ээр буюу 8.1 хувиар өссөн байна.

Зураг 4.5.25 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас хамгийн олон иргэд хохирсон аймгууд, 2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар


2013 онд улсын хэмжээгээр Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 2293 иргэн хохирсоны 5.7 хувь нь баруун бүсийнх, 12.5 хувь нь хангайн бүсийнх, 21.5 хувь нь төвийн бүсийнх, 5.6 хувь нь зүүн бүсийнх, 54.4 хувь нь Улаанбаатар хотын иргэд байна.

2013 онд энэ бүлгийн гэмт хэргийн улмаас Улаанбаатар хотод 1248 иргэн хохирсны 924 буюу 74.0 хувь нь Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэгт байна. Баянзүрх дүүрэгт 268 иргэн хохирсон нь бусад дүүргүүдээс олон байна. Энэ бүлгийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 30.2 хувь нь дээрх аймгуудад, 54.4 хувь нь Улаанбаатар хотын иргэд байна.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд учирсан хохирлын 3.3 тэрбум төг буюу 37.1 хувь нь Улаанбаатар хотод үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас үүссэн байна. Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт бусад дүүргээс их хохирол учирсан ба Сүхбаатар дүүрэгт үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 90.8 хувь, Баянзүрх дүүрэгт учирсан хохирлын 87.8 хувь, Сонгинохайрхан дүүрэгт 83.2 хувь, Баянгол дүүрэгт 86.4 хувийг нөхөн төлүүлсэн байна.

2013 онд Төв, Говь-Алтай, Өмнөговь, Дархан-Уул, Хэнтий, Орхон аймгуудад учирсан хохирлын хэмжээ бусад аймгуудаас их байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт Өмнөговь аймагт 99.8 хувь, Говь-Алтай аймагт 95.5 хувь, Дархан-Уул аймагт 92.7 хувь, Орхон аймагт 89.2 хувь, Төв аймагт 87.1 хувь, Хэнтий аймагт 77.6 хувьтай байна.

Зураг 4.5.26 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, насны бүлгээр, 2012-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хүснэгт 4.5.19 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, нийгмийн байдлаар, 2010-2013 он

Он	Нийгмийн байдал										
	Төрийн албан хаагч	Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	Төрийн бус байгууллагын ажилтан	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Малчин	Оюутан	Сурагч	Сургууль завсардсан	Тэнэмэл	Хоригдол	Ажилгүй
2010 он	102	199	30	177	173	86	145		2	1	775
2011 он	105	228	26	170	301	78	151		1	1	889
2012 он	130	316	42	299	169	86	155	5	2	1	917
2013 он	155	286	64	387	179	69	140	2	1	2	1008

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

2010-2013 оны байдлаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 43.2-45.9 хувийг ажилгүй иргэд эзэлж байна.

2013 онд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн дунд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь өмнөх оныхоос 2.8 пункт, төрийн бус байгууллагын ажилтаных 0.8 пункт, төрийн албан хаагчдынх 0.6 пункт, ажилгүй иргэдийнх 0.7 пунктээр нэмэгджээ.


Хүснэгт 4.5.20 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, боловсролын түвшингээр, 2010-2013 он

Он	Хохирсон иргэн	Боловсролын түвшин						
		Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
2010 он	1 690	100	161	155	869	29	34	342
2011 он	1 950	95	206	241	926	29	59	394
2012 он	2 122	124	210	332	880	10	78	488
2013 он	2 293	127	192	389	990	3	90	502

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 4 жилд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 3665 иргэн буюу 45.5 хувь нь бүрэн дунд боловсролтой, 1726 иргэн буюу 21.4 хувь нь дээд боловсролтой, 1117 иргэн буюу 13.9 хувь нь суурь боловсролтой байна.

Зураг 4.5.27 Нийт хохирсон иргэд ба зарим төрлийн гэмт хэргийн хохирогч иргэд, 2007-2013 он



2007-2013 оны байдлаар нийт бүртгэгдсэн гэмт хэргийн дүнд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 5.8-9.7 байхад нийт хохирогч иргэдийн дунд хохирсон иргэдийн эзлэх хувь мөн л 7.3-10.5 хувийг эзэлж байна.

Зураг 4.5.28 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг, сүүлийн 7 жилд



Сүүлийн 7 жилийн байдлаар ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг 2008 онд хамгийн бага бүртгэгдсэн бол 2013 онд 2148 болж, 2012 оныхоос 149 хэрэг буюу 7.5 хувиар өсөхөд энэ төрлийн гэмт хэргийн 66.1 хувийг эзэлж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих хэрэг 181-ээр өссөн нь голлон нөлөөлжээ.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт хамаарах гэмт хэргүүд сүүлийн жилүүдэд өссөн хэдий ч зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах хэрэг 4.5 хувиар буурсан байна.


Хүснэгт 4.5.21 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргээс хохирсон байгууллага, төрлөөр, 2007-2013 он

Он	Хохирогч байгууллага	Байгууллагын төрөл			Дүнд эзлэх хувь			
		Төрийн	Төрийн бус	Хувийн	Хохирогч байгууллага	Төрийн	Төрийн бус	Хувийн
2007 он	15	5	2	8	100.0	33.3	13.3	53.3
2008 он	5	0	1	4	100.0	0.0	20.0	80.0
2009 он	9	1	0	8	100.0	11.1	0.0	88.9
2010 он	4	0	1	3	100.0	0.0	25.0	75.0
2011 он	8	3	0	5	100.0	37.5	0	62.5
2012 он	8	3		5	100.0	37.5	0	62.5
2013 он	6	3		3	100.0	50.0	0.0	50.0

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас 2007-2013 онд 55 байгууллага хохирсоны 27.3 хувь нь хувийн, 7.2 хувь нь төрийн, 65.5 хувь нь төрийн бус байгууллага байна.

Зураг 4.5.29 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргээс хохирсон байгууллага, төрлөөр, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хүснэгт 4.5.22 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргээс учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2010-2013 он

Он	Бүгд	Учирсан хохирол. сая төг							Нөхөн төлүүлсэн хохирол сая.төг	Үүнээс	
		Гэмт хэргийн ангилал				Өмчийн хэлбэр				Хэрэг бүртгэлтийн шатанд	Мөрдөн байцаалтын шатанд
		Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд	Онц хүнд	Төрийн	Орон нутгийн	Хувийн өмчид			
2010 он	1 529.3	512.3	917.0	100.0	-	54.6	0.1	1 474.7	882.0	375.6	506.3
2011 он	2 902.3	895.7	1,922.3	84.3	-	10.8	11.2	2 880.2	2 011.2	660.1	1 351.1
2012 он	5 208.7	1 338.7	3 586.0	284.0	-	42.4	94.7	5 071.6	3 947.2	1 081.8	2 865.3
2013 он	8 887.9	2 026.6	6 745.9	115.4	-	2 913.5	22.9	5 951.4	7 092.7	1 790.3	5 302.4


Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 4 жилийн байдлаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 18.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь нийт хохирлын 6.6 хувийг эзэлж байна.

Сүүлийн 4 жилд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан 18.5 тэрбум төгрөгийн хохирлын 13.9 тэрбум төгрөг буюу 75.1 хувь нь нөхөн төлөгджээ. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас сүүлийн 7 жилд 2455 иргэн амь насаа алдаж, 7130 иргэн гэмтжээ.

2013 онд учирсан нийт хохирлын 8.9 тэрбум төгрөг буюу 5.6 хувь нь Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол байгаа бөгөөд 7.1 тэрбум төгрөг буюу 79.8 хувийг нь нөхөн төлүүлжээ.


Зураг 4.5.30 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргээс учирсан хохирол, гэмт хэргийн ангиллаар, 2010-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 4 жилд ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 4.8 тэрбум төгрөг буюу 25.8 хувийг хөнгөн, 13.2 тэрбум төгрөг буюу 71.1 хувийг хүндэвтэр, 0.6 тэрбум төгрөг буюу 3.1 хувийг хүнд гэмт хэрэг байна (Зураг 4.5.30).

Зураг 4.5.31 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргээс учирсан хохирлын нөхөн төлүүлэлт, тэрбум төг, 2010-2013 он



Хүснэгт 4.5.23 ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргээс хохирсон иргэд, 2012-2013 он

Зүйл хэсэг	2012 он			2013 он		
	Хохирогч иргэн	Учирсан хохирол сая төг	Нөхөн төлүүлэлт сая төг	Хохирогч иргэн	Учирсан хохирол сая төг	Нөхөн төлүүлэлт сая төг
215-225	2122	5 208.7	3 947.2	2 293	8 887.9	7 092.7
Үүнээс	215	1369	4 426.8	1 586	7 985.8	6 303.2
	216	706	668.7	664	788.2	696.9
	221	1	2.1			
	222	5	4.4	4.4	2	5.0
Бусад	41	106.7	92.4	41	108.9	87.7

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас 2013 онд 2293 иргэнд 8.9 тэрбум төгрөгийн хохирол учирч, Цагдаагийн байгууллагын шатанд 7.1 тэрбум төгрөг буюу 79.8 хувийг нь нөхөн төлүүлжээ. Энэ нь өмнөх оныхоос 4.8 пунктээр өсч, хохирсон иргэний тоо, учирсан хохирлын хэмжээ өмнөх оныхоос нэмэгдсэн байна.

4.6 ХОХИРОГЧИЙН ДҮР ТӨРХ (Шүүхийн шатанд)

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн хохирогчийн төлөв байдал, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, хохирогчид ямар зүйл ангийн гэмт хэргийн улмаас хохирдог, тэдний эрхийг хэрхэн хамгаалдаг талаар судлахыг зорилоо.


Хүснэгт 4.6.1 Хохирогч иргэд ба учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2007-2013 он

	Нийт хүн амын тоо	Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг	Ял шийтгүүлсэн	Хохирогч иргэд	Учирсан хохирол сая.төг	Нөхөн төлүүлэлт сая.төг	10 000 хүн тутмаас хохирсон хүний тоо	1 хохирогчид ноогдох хохирлын хэмжээ сая.төг	1 хохирогчид ноогдох нөхөн төлүүлэлт мян.төг
2007 он	2 620 446	5 831	8 463	2 612	67 035.3	1 154.7	10	25.7	442.1
2008 он	2 665 955	5 812	8 494	3 098	14 927.6	9 671.9	12	4.8	3 122.0
2009 он	2 716 275	5 407	7 513	2 944	19 440.5	1 184.0	11	6.6	402.2
2010 он	2 760 968	5 460	7 292	2 829	26 312.8	1 955.4	10	9.3	691.2
2011 он	2 811 666	5 877	8 210	3 156	13 854.6	1 707.6	11	4.4	541.1
2012 он	2 867 744	6 161	8 324	3 617	21 981.9	2 065.0	13	6.1	570.9
2013 он	2 930 277	6 169	8 065	3 248	95 896.2	90 822.9	11	29.5	27 962.7

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн хохирсон иргэдийн тоо 2013 онд 3248 болж, өмнөх оныхоос 369 хэрэг буюу 10.2 хувиар буурахад ял шийтгүүлсэн хүний тоо 259 буюу 3.1 хувиар буурсан нь голлон нөлөөлөө.

Зураг 4.6.1 Хохирогч иргэд, 2007-2013 он



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2013 оны байдлаар шүүхээр 6169 хэрэг шийдвэрлэгдэж, 3248 хохирогчид холбогдох 95.9 тэр бум төгрөгийн хохирлын 90.8 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлжээ (Хүснэгт 4.6.1)


Хүснэгт 4.6.2 Хохирогч иргэд, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, хууль сахиулах байгууллага бүрээр, 2007-2013 он

Он	Хохирогч иргэн			Учирсан хохирол.тэрбум төг			Нөхөн төлүүлэлт.тэрбум төг			
	ЦЕГ	ШЕЗ	ШШГЕГ	ЦЕГ	ШЕЗ	ШШГЕГ	ЦЕГ	ШЕЗ	УПЕГ	ШШГЕГ
2007 он	19 931	2 612	2 381	29.5	67.0	2.0	4.00	1.1	3.1	1.7
2008 он	20 256	3 098	2 369	54.8	14.9	3.4	7.0	9.7	5.3	3.9
2009 он	19 545	2 944	2 643	49.2	19.4	2.5	18.0	1.2	6.1	1.9
2010 он	19 381	2 829	2 620	33.4	26.3	6.2	14.3	2.0	9.9	3.0
2011 он	18 592	3 156	2 217	35.9	13.9	1.2	18.5	1.7	87.0	3.0
2012 он	21 294	3 617	2 486	53.3	21.9	15.5	25.1	2.1	43.9	5.3
2013 он	25 015	3 248	2 912	159.0	95.9	29.9	111.3	90.8	18.7	4.9
Нийт дүн	144014	21504	17628	415.1	259.3	60.7	198.2	108.6	174.0	23.7
Дундаж	20573	3072	2518	59.3	37.0	8.7	28.3	15.5	24.9	3.4

Эх үүсвэр: ЦЕГ, ШЕЗ, ШШГЕГ, УПЕГ

Хууль эрх зүйн байгууллага бүрээр гэмт хэргийн улмаас хохирсон иргэд, учирсан хохирол, нөхөн төлүүлэлтийг харьцуулах боломжгүй бөгөөд одоогоор байгууллага бүрийн хохирогчийн талаарх мэдээлэл ч хангалттай биш байна.

Зураг 4.6.2 Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг ба хохирогч иргэд, 2007-2013 он




Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Сүүлийн 7 жилийн дунджаар жил тутам 5817 гэмт хэрэг Шүүхээр шийдвэрлэгдэж, 3072 иргэн хохирч, 37.0 тэрбум төгрөгийн хохирол учирч, 15.5 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Энэ хугацаанд Шүүхийн шатанд 21504 хохирогчийн хохирол тогтоогдсоны 10653 буюу 49.5 хувь нь Улаанбаатар хотын хохирогчид байна (Зураг 4.6.2).

Зураг 4.6.3 Хохирогч иргэд, бүс, нийслэлээр, 2007-2013 он



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл


Зураг 4.6.4 Хохирогч иргэд ба нас барсан, гэмтсэн иргэд, 2007-2013 он



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Жил тутам Шүүхийн шатанд хохирсон иргэдийн 20 орчим хувь нь нас барж, 80 гаруй хувь нь гэмтдэг байна (Зураг 4.6.4).


Зураг 4.6.5 Хохирогчид учирсан гэмтэл, хэлбэрээр, 2011-2013 он



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2013 онд гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 2693 буюу 82.9 хувь нь гэмтэл авсны 643 буюу 23.9 хувь нь хүнд, 653 буюу 24.2 хувь нь хүндэвтэр, 1397 буюу 51.8 хувь нь хөнгөн гэмтэл байна. 2013 онд шүүхээр шийдвэрлүүлсэн хэргээс гэр бүлийн хүчирхийлэлд автагдаж гэмтсэн эмэгтэйчүүдийн 5 нь хүнд, 11 нь хүндэвтэр, 19 нь хөнгөн гэмтэл авсан байна. 2013 онд шүүхээр шийдвэрлэгдсэн хэргээс хүнд хэлбэрийн гэмтэл авсан хүний тоо 2011 оныхоос 134 буюу 20.8 хувиар, 2012 оныхоос 19 буюу 3.0 хувиар нэмэгдсэн байна (Зураг 4.6.5).

Зураг 4.6.6 Учирсан хохирол, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2007-2013 он



Зураг 4.6.3 Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн хохирогч, бүс, аймаг, нийслэлээр, 2013 он

Аймаг, нийслэл	Шүүхээр шийдвэрлэсэн -бүгд					Гэмт хэргийн улмаас хохирсон иргэн	
	Хэрэг	Холбогдогч	Хохирогч	Учирсан хохирол /сая.төг/	Нөхөн төлүүлэлт /сая.төг/	Нас барсан	Гэмтсэн
Улсын дүн	6 169	8 065	3 248	95 896.2	90 822.9	555	2 693
Баруун бүс	428	610	184	746.8	40.5	36	148
Баян-Өлгий	76	126	29	151.7	-	3	26
Говь-Алтай	75	105	42	190.5	-	10	32
Завхан	82	103	36	175.6	-	7	29
Увс	88	125	50	79.1	-	10	40
Ховд	107	151	27	150.0	40.5	6	21
Хангайн бүс	969	1255	471	2374.1	150.2	90	381
Архангай	159	224	90	503.1	148.2	17	73
Баянхонгор	146	195	76	209.0	-	9	67
Булган	113	137	42	83.2	-	11	31
Орхон	167	228	63	670.9	-	14	49
Өвөрхангай	167	261	80	61.3	-	24	56
Хөвсгөл	217	210	120	846.6	2.0	15	105
Төвийн бүс	1270	1690	782	2928.9	26.6	160	622
Говьсүмбэр	53	62	51	104.9	0.4	6	45
Дархан-Уул	190	299	106	224.7	-	11	95
Дорноговь	239	317	129	276.9	-	30	99
Дундговь	89	114	39	144.0	21.7	9	30
Өмнөговь	137	168	87	1,650.5	-	21	66
Сэлэнгэ	292	387	193	527.3	1.3	43	150
Төв	270	343	177	0.6	3.2	40	137
Зүүн бүс	517	668	251	496.7782	7,696.6	49	202
Дорнод	220	293	121	104.2	7,696.0	24	97
Сүхбаатар	128	143	48	10.2	-	10	38
Хэнтий	169	232	82	382.3	0.6	15	67
Нийслэл	2 985	3 842	1 560	89349.63	82909.0	220	1 340

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2013 оны байдлаар 4223 холбогдогчтой, 3248 хохирогчтой 3184 хэрэг Шүүхээр шийдвэрлэгдсэн ба 95.9 тэрбум төгрөгийн хохирол учирчээ. Учирсан хохирлын 90.8 тэрбум төг буюу 94.7 хувийг нөхөн төлүүлжээ. 2013 онд гэмт хэргийн улмаас шүүхийн шатанд 555 хүн нас барж, 1353 хүн гэмтсэн байна.

Шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн хохирогч иргэдийг нас, хүйс, боловсрол, сарын орлого, ажил эрхлэлт г.м уялдаа холбоо хамаарлыг харуулах олон үзүүлэлтүүд дутагдалтайн улмаас дүгнэлт, анализ хийх боломж хязгаарлагдмал байлаа. Цаашид хохирсон иргэд, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, хохирогчийн эрхийг хамгаалах талаар хийж буй үйл ажиллагааны талаар цогц мэдээлэлтэй болох зайлшгүй хэрэгцээ байна.

НАС БАРСАН ИРГЭД

Сүүлийн 7 жилд Шүүхээр хэрэг шийдвэрлэх шатанд гэмт хэргийн улмаас 3889 иргэн нас барсны 310 буюу 7.9 хувь нь Баруун бүсэд, 721 буюу 18.5 хувь нь Хангайн бүсэд, 916 буюу 23.6 хувь нь Төвийн бүсэд, 292 буюу 7.5 хувь нь Зүүн бүсэд, 1650 буюу 42.4 хувь нь Улаанбаатар хотынх байна. Шүүхээр хэрэг шийдвэрлэх шатанд 7 жилийн дунджаар жил тутам 556 иргэн амь насаа алддаг байна.

2013 онд Шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн 555 иргэн нас барсан нь өмнөх оныхоос 99 буюу 15.1 хувиар буурсан байна. Нас баралт буурахад 2013 онд Баруун буюу Хангайн бүсэд нас баралт буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 4.6.4 Нас барсан иргэд, бүс, аймаг, нийслэлээр, 2007-2013 он

Аймаг, нийслэл	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2007-2013	7 жилийн дундаж
Улсын дүн	539	534	483	535	589	654	555	3889	556
Баруун бүс	46	39	49	49	36	55	36	310	44
Баян-Өлгий	7	6	16	8	10	17	3	67	10
Говь-Алтай	4	2	4	3	3	16	10	42	6
Завхан	10	9	7	9	3	12	7	57	8
Увс	13	14	14	18	10	4	10	83	12
Ховд	12	8	8	11	10	6	6	61	9
Хангайн бүс	120	99	82	74	115	141	90	721	103
Архангай	16	14	9	12	27	20	17	115	16
Баянхонгор	11	18	14	14	14	17	9	97	14
Булган	15	21	12	7	21	21	11	108	15
Орхон	24	22	23	13	22	21	14	139	20
Өвөрхангай	33	13	16	18	18	30	24	152	22
Хөвсгөл	21	11	8	10	13	32	15	110	16
Төвийн бүс	121	107	106	119	149	154	160	916	131
Говьсүмбэр	4	3	2	2	5	2	6	24	3
Дархан-Уул	18	15	19	17	28	22	11	130	19
Дорноговь	16	14	9	11	14	17	30	111	16
Дундговь	3	1	7	2	10	4	9	36	5
Өмнөговь	9	11	5	12	22	22	21	102	15
Сэлэнгэ	35	30	26	36	23	42	43	235	34
Төв	36	33	38	39	47	45	40	278	40
Зүүн бүс	25	46	22	62	45	43	49	292	42
Дорнод	11	17	6	15	16	15	24	104	15
Сүхбаатар	4	12	4	10	8	8	10	56	8
Хэнтий	10	17	12	37	21	20	15	132	19
Улаанбаатар	227	243	224	231	244	261	220	1650	236

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Нас баралтыг бүс нутгийн байршлаар авч үзвэл Хангайн бүс, Төвийн бүс, Улаанбаатар хотод нас баралт хамгийн өндөр байна.


ГЭМТСЭН ИРГЭД

Сүүлийн 7 жилд Шүүхээр хэрэг шийдвэрлэх шатанд гэмт хэргийн улмаас 17617 иргэн гэмтсэний 1253 буюу 7.1 хувь нь Баруун бүсэд, 2385 буюу 13.6 хувь нь Хангайн бүсэд, 3829 буюу 21.7 хувь нь Төвийн бүсэд, 1147 буюу 6.5 хувь нь Зүүн бүсэд, 9003 буюу 51.1 хувь нь Улаанбаатар хотод байна.

Шүүхээр хэрэг шийдвэрлэх шатанд сүүлийн 7 жилийн дунджаар жил тутам 2517 иргэн гэмтэж бэртсэн байна.

2013 онд Шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн улмаас 2693 иргэн гэмтсэн нь өмнөх оныхоос 270 буюу 9.1 хувиар буурсан байна. Гэмтсэн иргэдийн тоо буурахад Улаанбаатар хотын гэмтсэн иргэдийн тоо 359 буюу 21.1 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 4.6.7 Гэмтсэн иргэд, бүсээр, 2007-2013 он



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Хүснэгт 4.6.5 Гэмтсэн иргэд, гэмт хэргийн төрлөөр, 2009-2013 он


Эрүүгийн хуулийн зүйл ангиар	Гэмтсэн хүний тоо					Дүнд эзлэх хувь				
	2009	2010	2011	2012	2013	2009	2010	2011	2012	2013
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	899	1013	1013	1212	1257	36.5	44.2	39.5	40.9	46.7
Хүчингийн хэрэг	33	17	22	21	22	1.3	0.7	0.9	0.7	0.8
Танхайн хэрэг	655	662	617	715	657	26.6	28.9	24.0	24.1	24.4
ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг	585	477	477	608	623	23.8	20.8	18.6	20.5	23.1
Бусад	289	125	438	407	134	11.7	5.4	17.1	13.7	5.0
Улсын дүн	2461	2294	2567	2963	2693	100.0	100.0	100.0	100.0	100.0

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Гэмтсэн иргэнийг Эрүүгийн гэмт хэргийн төрлөөр авч үзвэл Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний тоо жил тутам нэмэгдсэн байна.

Сүүлийн 7 жилд шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний 50.9 хувь буюу 8969 нь хөнгөн, 27.3 хувь буюу 4808 нь хүндэвтэр, 21.8 хувь буюу 3840 нь хүнд хэлбэрээр гэмтэл авсан байна. Сүүлийн жилүүдэд шийдвэрлэгдсэн гэмт хэргийн улмаас гэмтсэн дөрвөн хүний хоёр нь хөнгөн гэмтэл авсан байна.

Зураг 4.6.8 Гэмтсэн иргэд, гэмтлийн зэргээр, 2007-2013 он



2013 онд гэмт хэргийн улмаас гэмтсэн иргэдийн тоо өмнөх оныхоос буурсан боловч гэмтлийн зэргийг бүтцээр авч үзвэл хөнгөн гэмтэл 2 пункт, хүндэвтэр гэмтэл 2.8 пунктээр нэмэгдэж, харин хүндэвтэр гэмтэл 4.9 пунктээр буурсан байна.


4.7 ХОХИРОГЧИЙН ДҮР ТӨРХ (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд)

Шийдвэр гүйцэтгэх шатан дахь Эрүүгийн гэмт хэргийн хохирогчийн дүр төрхийг цуглуулсан мэдээллийн хүрээнд тодорхойлохыг зорилоо.

Зураг 4.7.1 Хохирогч иргэд, сүүлийн 7 жилд




Зураг 4.7.2 Хохирогч иргэд, бүсээр, 2007-2013 он



Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Сүүлийн 7 жилийн байдлаар Шийдвэр гүйцэтгэх шатанд нийт 17628 иргэн хохирсны 883 буюу 5.0 хувь нь Баруун бүсэд, 3248 буюу 18.4 хувь нь Хангайн бүс, 2877 буюу 16.3 хувь нь Төвийн бүс, 1322 буюу 7.5 хувь нь Зүүн бүсэд, 9298 буюу 52.7 хувь нь Улаанбаатар хотод байна. Орхон, Дорнод, Дархан-Уул, Төв, Дорноговь, Увс аймгуудаас хамгийн олон иргэн хохирсон байна (Зураг 4.7.2).

Зураг 4.7.3 Хохирогч байгууллага, бүсээр, 2007-2013 он



Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Шийдвэр гүйцэтгэх шатанд гэмт хэргийн хохирогч болсон байгууллагуудыг бүс, нутгийн байршлаар нь авч үзвэл бүсүүдээс хамгийн их байгууллага хохирдог нь Төвийн бүс, Улаанбаатар хот байна.

Төвийн бүсэд хамгийн олон байгууллага хохироход Дорноговь аймагт жил тутам дунджаар 77 байгууллага хохирсон нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 4.7.4 Хамгийн олон байгууллага хохирсон аймаг, 2012-2013 он



Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Улаанбаатар хотод 7 жилийн дунджаар жил тутам 181 байгууллага гэмт хэргийн улмаас хохирсон байна.

Эрүүгийн хэргийн шийдвэртэй хэргээс ч ач холбогдол, хор хохирлын хувьд дутуугүй асуудал бол хүүхдийн тэтгэлэгийн нөхөн төлүүлэлтийн асуудал юм. Энэ удаа Эрүүгийн хэргийн хохирогчийн талаар судалж байгаа боловч бидний ирээдүй болсон үр хүүхдүүдийн эрх ашгийг ихээр хөндсөн хүүхдийн тэтгэлэгийн асуудлыг хөндөхгүй байж чадсангүй. Хүүхдийн тэтгэлэг төлөлтийг сайжруулах нь хүүхдийн эрхийг хангах нөхцлүүдийн нэг юм.

Монгол Улс хүүхдийн төлөө, тэдний эрх ашгийг хамгаалах талаар ихийг ярьж зарим талаар хийсэн зүйл байдаг ч өнөөгийн практикт эрх нь хамгийн их зөрчигдөж буй хүүхдүүд бол тэтгэлэг авагч хүүхдүүд юм.

Хүүхдийн тэтгэлэгийн нөхөн төлүүлэлт сайжрахгүй байгаа нь:

Нэгдүгээрт. Тэтгэлэг төлөгчийн зүгээс хүүхдэд өгч буй тэтгэлэгийн хэмжээ өнөөгийн амьдралын хэрэгцээ, шаардлагатай харьцуулахад туйлын хангалтгүй

Хоёрдугаарт. Нэгэнт шүүхээр тогтоогдсон тэтгэлэгийг барагдуулахад төлбөр төлөгчийн зүгээс төлбөрөө төлөхгүй байх олон шалтаг, шалтгаанууд гардаг

Гуравдугаарт. Шийдвэр гүйцэтгэх газар өнөөдрийг хүртэлх мэдээлэлдээ Монгол Улсын хэмжээнд хэдэн хүүхдийн төлбөр төлөхөөс хэд нь төлөгдсөн талаарх мэдээлэлгүйн улмаас энэ талаар дорвитой арга хэмжээ авагдахгүй явсаар ирсэн байх талтай.

Хүснэгт 4.7.1 Хүүхдийн тэтгэлэгийн төлбөр барагдуулалт, 2010-2013 он

	Гүйцэтгэвэл зохиц	Хэсэгчлэн биелүүлсэн	Дуусгавар болж хаасан				Биелүүлээгүй үлдэгдэл	Гүйцэтгэлийн ажиллагаа удааширч байгаа шалтгаан				
			Тэтгэлэг бүрэн төлөгдсөн	Тэтгүүлэгч хүүхэд бусдад үрчлөгдсөн	18 насанд хүрснээр /тэтгэлэг бүрэн төлөгдөөгүй	Тэтгэгч эсвэл тэтгүүлэгч нас барсан		Төлбөрийн чадваргүй	Оршин суугаа хаяг тодорхойгүй	Ял эдэлж байгаа	Эрэн сурвалжлаг даж байгаа	бусад
2010 он	10 771	1 212	913	2	289	25	9 542	2 022	1 364	39	125	67
2011 он	10 868	1 318	976	8	257	18	9 609	1 488	990	41	28	1 978
2012 он	10 587	712	1 125	12	224	34	9 192	2 332	1 480	59	166	2 640
2013 он	10 882	1 062	25	414	47	2 097	9 334	1 802	1 359	63	107	3 736

Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Гэр бүл цуцлалт, эцэг эхийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж сүүлийн 4 жилд нийт 43108 хүүхдийн тэтгэлэг төлөгчөөс 3039 төлбөр төлөгчтэй холбоотой хүүхдийн тэтгэлэг төлөгдөж, 37677 төлбөр төлөгчтэй холбогдох хүүхдийн тэтгэлэг төлөгдөөгүй байна.

Хүүхдүүд тэтгэлэг авч чадаагүй, авсан тэтгэлэг нь амьдралд нь хүрэлцэхгүйн улмаас насанд хүрээгүй хүүхдүүдэд асар их бэрхшээл тохиолдож байгаа нь хүүхэд оролцсон гэмт хэргийн тоо өсөхөд ч нөлөөлөх талтай.


Цагдаагийн байгууллагын 2013 оны мэдээгээр хүүхэд оролцсон гэмт хэрэг буурсан байдал ажиглагдах боловч энэ нь нөлөөлөхүйц үр дүн биш нь ойлгомжтой.

Монгол Улс хүүхдэдээ хандсан олон бодлого хөтөлбөр явуулдаг ч хууль хяналтын байгууллага тэр тусмаа Хууль зүйн яамны зүгээс хүүхдийн тэтгэлэгийн улмаас хохирч буй хүүхдүүдийн төлөө дорвитой бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй байна. Үүний нэг тод жишээ бол өнөөдрийг хүртэл Монгол Улсын

хэмжээгээр жилд Шүүхээс тэтгэлэг авахаар хэдэн хүүхэдтэй холбоотой шийдвэр гардаг, Шийдвэр гүйцэтгэх газар жилд хэдэн хүүхдийн төлбөрийг барагдуулж, хэдийг нь барагдуулаагүй талаар тоо мэдээлэл байхгүй байгаа явдал гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл ШШГЕГ-ын одоогийн хүүхдийн тэтгэлэгийн мэдээлэл шаардлага хангахгүй байгаа юм.

Хүүхдийн тэтгэлэгийн асуудлыг хариуцан ажиллаж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд ч энэ асуудал дээр дэвшил гаргахуйц ажлыг хийх нь зүйтэй болов уу. “Хүүхэд бол бидний ирээдүй”. Ирээдүйнхээ төлөө Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цаашилбал Хууль зүйн яаманд энэ ажилд чиглэгдсэн бодлого өгүүлэгдэж байна.

Зураг 4.7.5 Хүүхдийн тэтгэлэгийн төлбөр барагдуулалт удааширсан шалтгаан, 2010-2013 он



БҮЛЭГ 5. ХОХИРЛЫГ БАРАГДУУЛЖ БҮЙ ХЭЛБЭР, ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, хууль сахиулах байгууллага бүрээр


5.1 УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ (Цагдаагийн хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд)

Энэхүү бүлэгт 2007-2013 онд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний нөхөн төлүүлэлтийн байдал, гэмт хэргийн улмаас иргэнд учирсан эрүүл мэнд, амь насны хохирлыг хууль сахиулагч байгууллага бүрийн хохирогчтой холбоотой тоо мэдээлэлд үндэслэн тодорхойлохыг зорилоо.

Ихэнх судлаачид хохирол үүсэж байгаа шалтгаан нөхцлийг шууд утгаараа гэмт хэргийн гаралттай холбоотой, харин гэмт хэргийн тоо өсөх шатгааныг хэрэглээний үнэ, инфляци өсөж, нийгэм хямарч ажилгүйдэл, амьжиргааны түвшний доройтол, ядуурал нэмэгдсэнтэй холбон тайлбарладаг ч 2013 онд өмнөх оныхоос улсын хэмжээгээр ядуурлын хамралтын хүрээ 6.3 пункт, ажилгүйдлийн түвшин 0.3 пункт, инфляцийн түвшин 1.5 пунктээр буурахад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 14.8 хувь, учирсан хохирол 3 дахин нэмэгдсэн байна.

Гэмт хэрэг өсөж, хохирол ихээр гарч байгаа нь зөвхөн нийгмийн гол гол үзүүлэлттэй холбон тайлбарлагдах асуудал биш юм. Учир нь гэмт хэргийг ухамсарт хүн үйлдэж байгаа тул хувь хүний биеэ авч явах байдал, нийгэмд эзлэх байр суурь, зан төлөвшил, үйл ажиллагаатай салшгүй холбоотой. Зөвхөн нийгмийн сөрөг үр дагавараас болж гэмт хэрэг өсөж, хохирол их гардаг гэвэл өрөөсгөл ойлголт болно. Өөрөөр хэлбэл хохирол нэмэгдэхэд хувь хүний ухамсарт үйл ажиллагаа чухал нөлөөтэй.

Зураг 5.1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба учирсан хохирол, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 7 жилд нийт 148.8 мянган хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 144.0 мянган иргэн, 3.7 мянган байгууллагад 414.8 тэрбум төгрөгийн хохирол учирчээ. Энэ нь зөвхөн эд материалын хохирол бөгөөд жилд дундажаар 20.6 мянган иргэн, 500 орчим байгууллагад 59.3 тэрбум орчим төгрөгийн хохирол учирсан байна.


Учирсан хохирлыг дүнд эзлэх хувь, байршлаар авч үзвэл сүүлийн 7 жилийн байдлаар нийт учирсан хохирлын 66.4-86.3 хувь нь Улаанбаатарт, 5.6-13.6 хувь нь Төвийн бүсэд, 4.8-9.4 хувь нь Хангайн бүсэд, 2.0-7.6 хувь нь Зүүн бүсэд, 1.9-3.9 хувь нь Баруун бүсийнх байна.

2013 онд учирсан хохирлыг бүс нутгаар нь авч үзвэл нийт хохирлын 84.1 хувь нь Улаанбаатарт, 5.6 хувь нь Төвийн бүсэд, харин 1.9-3.3 хувь нь бусад бүсүүдэд үйлдэгдсэн хэргийн улмаас учирсан байна.

Улсын хэмжээгээр 2013 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирол 3 дахин нэмэгдэхэд Говь-Алтай, Ховд, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймгуудад болон Улаанбаатар хотод өмнөх оныхоос их хохирол учирсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 5.1.2).

Улаанбаатар хотод учирсан хохирол их байгаа нь хүн амын суурьшил, төвлөрөл, ажилгүйдэл, үнийн өсөлт, ядуурал гэх мэт нийгмийн үзэгдлүүдтэй холбоотой байх талтай. 2013 онд нийт учирсан хохирол өсөхөд Баян зүрх дүүрэг, Сүхбаатарт дүүрэгт учирсан хохирол голлон нөлөөлжээ.

Зураг 5.1. 2 Учирсан хохирол, бүсээр, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Хүснэгт 5.1.1 Учирсан хохирол, гэмт хэргийн ангиллаар, хувиар, 2007-2013 он

	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2007-2013
Хөнгөн	10.0	6.7	6.4	10.0	11.8	12.4	5.9	8.1
Хүндэвтэр	54.0	22.0	38.2	42.3	55.7	41.7	55.0	45.9
Хүнд	33.9	42.3	42.0	35.8	13.1	27.4	23.3	29.4
Онц хүнд	2.1	29.0	13.4	11.9	19.4	18.5	15.8	16.6
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 7 жилд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 8.1 хувь нь хөнгөн, 45.9 хувь нь хүндэвтэр, 29.4 хувь нь хүнд, 16.6 хувь нь онц хүнд гэмт хэргийн улмаас учирчээ.


2013 онд хөнгөн гэмт хэрэг өмнөх оныхоос 6.5 пункт, хүнд гэмт хэрэг 4.0 пункт, онц хүнд гэмт хэрэг 2.7 пункт буурсан бол хүндэвтэр гэмт хэрэг 13.3 пунктээр нэмэгдсэн байна. Хүндэвтэр төрлийн гэмт хэрэг өсөхөд Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

Хүснэгт 5.1.2 Учирсан хохирол, бүс, аймаг, нийслэлээр, 2007-2013 он

Улсын дүн	29265.3	54802.3	49186.1	33383.1	35904.3	53263.2	159024.4
Баруун бүс	942.7	1879.3	1913.0	1185.8	1381.1	1737.4	2951.5
Баян-Өлгий	167.1	388.9	178.4	147.9	322.0	328.0	198.4
Говь-Алтай	119.8	168.4	369.4	224.2	210.1	292.8	804.2
Завхан	160.4	266.9	218.5	213.6	113.6	236.6	500.4
Увс	177.6	469	580.9	292.2	495.7	559.1	571.2
Ховд	317.8	586.1	565.8	307.9	239.7	320.9	877.3
Хангайн бүс	2492.7	2627.5	3374.2	3145.4	2936.9	4769.7	5254.4
Архангай	288	402.6	896.4	528.8	572.4	641.9	920.1
Баянхонгор	160.8	552.8	202	225.5	220.4	432.9	594.5
Булган	243.7	221.4	506.4	405	368.9	455.1	1008.2
Орхон	634.7	729.6	953.5	1010.6	672.7	930.4	851.8
Өвөрхангай	361.0	223.5	251.8	571.3	448.0	719.9	780.4
Хөвсгөл	804.5	497.6	564.1	404.2	654.5	1589.5	1099.4
Төвийн бүс	3284.6	4547.2	3974.9	4347.2	4871.3	7052.2	8917.2
Говьсүмбэр	91.8	145.4	115.3	259.2	149.7	138.7	224.5
Дархан-Уул	796.6	895.6	634.5	782.9	320.9	801.8	1247.0
Дорноговь	515.4	290.8	867.2	1107.1	964.0	762.8	1578.0
Дундговь	150.9	601.1	359.4	111.1	195.6	300.6	614.3
Өмнөговь	189.4	342.5	367.5	411	1441.2	1298.9	1288.0
Сэлэнгэ	883.8	1335.5	716.3	862.3	457.0	1319.7	1153.2
Төв	656.7	936.3	914.7	813.6	1342.9	2429.5	2812.2
Зүүн бүс	1050.3	1175.6	962.2	2548	1592.5	2315.8	4739.6
Дорнод	323.1	403.8	472.4	1380.7	528.3	903.9	2951.0
Сүхбаатар	89.8	154.7	139.0	198.5	89.4	293.4	594.4
Хэнтий	637.4	617.1	350.8	968.8	974.8	1118.5	1194.2
Улаанбаатар	21326.3	43993.7	33125.6	21295.8	24847.9	37039.7	133685
Бусад*	168.7	579.0	5836.2	860.9	274.6	348.4	3477.1

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар


Зураг 5.1.3 Учирсан хохирол, гэмт хэргийн төрөл, дүнд эзлэх хувиар, 2013 он



■ Хөнгөн ■ Хүндэвтэр ■ Хүнд ■ Онц хүнд Хөнгөн ■ Хүндэвтэр ■ Хүнд ■ Онц хүнд

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Зураг 5.1.4 Учирсан хохирол, дүүргээр, хувиар, 2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Сүүлийн 7 жилд нийт учирсан хохирлын 198.2 тэрбум төг буюу 47.7 хувийг нь нөхөн төлүүлсэн байна. Нийт хохирлын 20.0 тэрбум төг буюу 10.1 хувийг хэрэг бүртгэлийн, 178.2 тэрбум төг буюу 89.9 хувийг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлжээ.

2007-2008 онд нийт учирсан хохирлын 10 гаруй хувийг нөхөн төлүүлж байсан бол сүүлийн жилүүдэд жил ирэх тусам нөхөн төлүүлэлт нэмэгдсээр 2013 онд нийт

учирсан хохирлын 70 хувийг хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлжээ.

Энэ нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах талаар Цагдаагийн байгууллага бодитой ажил хийж буйг харуулж байна.

Хүснэгт 5.1.3 Хохирол нөхөн төлүүлэлтийн хувь, бүс, аймаг, нийслэлээр, 2007-2013 он

Аймаг, нийслэл	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Улсын дүн	13.9	12.7	36.5	43.0	51.5	47.2	70.0
Баруун бүс	47.7	39.3	65.4	61.4	62.5	74.1	71.9
Баян-Өлгий	43.6	13.7	61.8	85.5	43.2	85.8	72.6
Говь-Алтай	48.7	50.5	66.4	50.6	57.6	76.3	84.4
Завхан	82.9	90.2	58.3	55.5	50.8	66.9	52.4
Увс	42.7	27.3	76.5	62.9	72.5	72.1	62.8
Ховд	34.4	39.4	57.1	60.4	77.5	68.7	77.4
Хангайн бүс	28.8	39.5	65.1	45.2	51.0	67.5	64.8
Архангай	40.5	33.9	69.6	42.5	49.9	65.7	71.3
Баянхонгор	65.9	30.3	52.8	43.6	66.2	63.5	71.5
Булган	37.5	51.0	67.7	60.5	54.0	64.6	54.4
Орхон	22.4	41.0	72.7	44.1	66.2	70.4	52.4
Өвөрхангай	39.3	70.2	64.9	50.1	61.0	61.0	68.7
Хөвсгөл	14.9	33.3	47.1	29.8	22.5	71.5	72.1
Төвийн бүс	37.1	42.1	65.5	68.6	71.7	77.7	68.8
Говьсүмбэр	66	82.5	79.6	71.7	67.6	34.2	66.0
Дархан-Уул	18.1	24.9	34.7	68.4	51.9	61.4	73.0
Дорноговь	34.3	40.6	83.9	66.8	69.0	68.8	68.4
Дундговь	24.0	74.0	78.2	93.8	72.0	57.3	65.0
Өмнөговь	17.9	22.5	42.3	64.8	64.3	80.7	48.2
Сэлэнгэ	47.2	22.1	67.0	70.7	75.4	88.4	80.5
Төв	53.5	67.6	70.8	66.5	85.3	83.4	73.0
Зүүн бүс	45.4	51.8	51.5	76.4	64.9	67.0	63.9
Дорнод	15.3	39.8	30.2	88.5	62.4	75.2	59.9
Сүхбаатар	59.6	85.1	93.5	90.8	53.8	58.1	72.5
Хэнтий	58.6	51.3	63.5	56.0	67.2	62.7	69.3
Улаанбаатар	5.3	5.7	33.2	33.6	45.8	36.3	70.4
Бусад*	36.9	25.2	7.4	12.0	80.6	42.0	70.2

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар


Жил тутам нийт учирсан хохирлын 60 гаруй хувь нь Улаанбаатар хотод гардаг тул хохирол нөхөн төлүүлэлтийн улсын дундажид ч Улаанбаатар хотын нөхөн төлүүлэлт зонхилох нөлөөтэй нь харагдаж байна.

Сүүлийн 7 жилд Сүхбаатар, Хэнтий, Төв, Завхан, Говь-Алтай аймгуудад жил тутам учирсан хохирлын 50-иас дээш хувийг нөхөн төлүүлсэн байна (Хүснэгт 5.1.3).

2013 оны хохирол нөхөн төлүүлэлтийн хувийг аймаг, нийслэлээр авч үзэхэд Говь-Алтай (84.4 хувь), Сэлэнгэ (80.5 хувь), Ховд (77.4 хувь) аймгуудад улсын дунджаас 7.4-14.4 пунктээр илүү буюу хамгийн өндөр хувьтай байхад Өмнөговь,

Орхон, Завхан, Булган, Дорнод аймгуудад улсын дунджаас 10.1-21.8 пунктээр бага буюу хамгийн бага хувьтай байна (Хүснэгт 5.1.3).

Зураг 5.1.5 Хохирлын нөхөн төлүүлэлт, бүсээр, дүнд эзлэх хувиар, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Бүс нутгаар нь авч үзвэл хохирол нөхөн төлүүлэлт сүүлийн жилүүдэд бүсүүдэд жигд 60-70 хувьтай байгаа бол Улаанбаатар хотын хувьд 2007-2012 онд нөхөн төлүүлэлт бүсүүдээс доогуур хувьтай байснаа харин 2013 онд 70.4 хувь болж өссөн байна.


Хөрөнгө битүүмжлэх нь хохирол барагдуулах нэг хэлбэр бөгөөд Цагдаагийн хэрэг бүртгэх мөрдөн байцаах шатанд хөрөнгийг битүүмжилдэг боловч битүүмжилсэн хөрөнгийг борлуулж хохирол барагдуулах процесс явагддаггүй байна.

2007-2013 онд хохирол барагдуулах зорилгоор 140.9 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсний 99.8 тэрбум буюу 70.8 хувийг 2013 онд мөрдөн байцаалтын шатанд битүүмжилжээ.

Хэрэг бүртгэх болон мөрдөн байцаалтын шатанд 2007-2012 онд 0.6-27.7 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилж байсан бол 2013 онд 99.8 тэрбум болж өмнөх оныхоос 2.6 дахин нэмэгдсэн байна.

Битүүмжилсэн хөрөнгө 2013 онд Улаанбаатар хотод өсөхөд Баянзүрх дүүрэгт 72.2 тэрбум төг, Баянгол дүүрэгт 17.0 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь голлон нөлөөлжээ.

Зураг 5.1.6. Битүүмжилсэн хөрөнгө, бүсээр, дүнд эзлэх хувиар, 2007-2013 он



Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар

Битүүмжилсэн хөрөнгийг бүс нутгаар нь авч үзвэл 2013 онд Улаанбаатар хотод 80.6 пунктээр нэмэгдэж, харин Төвийн бүсэд 32.7 пункт, Хангайн бүсэд 21.8 пункт, Зүүн бүсэд 14.0 пункт, Баруун бүсэд 12.1 пунктээр буурсан байна.

Сүүлийн 7 жилд битүүмжилсэн эд хөрөнгийн 69.1-98.7 хувийг Мөрдөн байцаах ажиллагааны явцад битүүмжилжээ.

5.2 УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ (Шүүхийн шатанд)

Зураг 5.2.1 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, тэрбум.төг, 2007-2013 он



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2007-2012 онд Шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хохирлын нөхөн төлүүлэлт хангалтгүй

явж иржээ.

Харин 2013 онд нийт учирсан хохирлын 94.5 хувь нь нөхөн төлөгджээ. Эндээс үзэхэд Шүүхийн шатанд хохирогчийн хохирлыг төлүүлэх үйл ажиллагаа эрс сайжирсан мэт харагдах авч энэ нь зөвхөн Улаанбаатар хотод төлөгдсөн нөхөн төлбөр байна. Өөрөөр хэлбэл нийт нөхөн төлүүлэлт 2013 онд өсөхөд Улаанбаатар хотын учирсан хохирлын 83.0 тэрбум төг буюу 92.8 хувь нь нөхөн төлөгдсөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 5.2.1 Учирсан хохирол, бүс, аймаг, нийслэлээр, 2007-2013 он

Аймаг, нийслэл	Шүүхээр шийдвэрлэгдсэн хохирлын хэмжээ /сая төг/						
	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Улсын дүн	67035.3	14927.6	19440.5	26312.8	13854.6	21982.1	95896.9
Баруун бүс	437.4	551.8	1686.8	308.7	525.2	1132.4	746.8
Баян-Өлгий	39.3	-	51.0	77.2	127.6	68.3	151.7
Говь-Алтай	20.4	282.9	50.1	60.7	5.2	726.3	190.5
Завхан	101.1	159.2	15.5	30.0	55.0	92.7	175.6
Увс	179.6	109.7	622.1	71.2	189.9	93.6	79.1
Ховд	96.9	-	948.1	69.6	147.5	151.5	150.0
Хангайн бүс	1464.5	1960.3	1267.6	3134.1	2152.9	2322.8	2374.1
Архангай	89.8	108.3	242.9	58.8	88.2	421.8	503.1
Баянхонгор	61.9	990.0	46.7	358.4	45.2	126.5	209.0
Булган	54.7	8.8	231.6	206.4	735.5	311.9	83.2
Орхон	1,005.2	285.7	447.1	2,066.7	637.7	603.3	670.9
Өвөрхангай	171.3	294.9	86.7	93.5	362.2	147.2	61.3
Хөвсгөл	81.5	272.6	212.6	350.3	284.1	712.0	846.6
Төвийн бүс	1730.5	2073.66	1485.3	2575.3	2940.1	3724.12	2929.6
Говьсүмбэр	35.0	65.4	13.9	140.4	123.5	35.6	104.9
Дархан-Уул	176.0	1,056.1	444.1	383.3	656.3	573.9	224.7
Дорноговь	680.3	271.5	231.8	275.3	675.4	9.8	276.9
Дундговь	60.6	72.6	120.2	75.4	136.8	131.5	144.7
Өмнөговь	44.0	39.2	45.4	119.4	662.7	65.8	1,650.5
Сэлэнгэ	209.8	22.6	280.1	1,128.9	211.9	1,947.3	527.3
Төв	524.9	546.2	349.8	452.6	473.5	960.2	0.6
Зүүн бүс	364.2	354.1	256.4	551.4	440.9	1377.4	496.8
Дорнод	91.4	135.9	114.8	283.2	168.2	112.6	104.2
Сүхбаатар	85.1	25.0	14.6	81.5	42.9	24.8	10.2
Хэнтий	187.7	193.2	127.0	186.7	229.8	1,239.9	382.3
Улаанбаатар	63038.8	9987.7	14744.4	19743.3	7795.5	13425.4	89349.6

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл


Сүүлийн 7 жилд шүүхээр шийдвэрлэгдсэн хохирлын улмаас иргэн, байгууллагад 259.4 тэрбум төгрөгийн хохирол учирсны 108.6 тэрбум төг буюу 41.6 хувийг Шүүхээр хэрэг шийдвэрлэх шатанд нөхөн төлүүлжээ.

Сүүлийн 7 жилд учирсан хохирлын 95.9 тэрбум төг буюу 37.0 хувь нь 2013 оны хохирол байна.

Учирсан хохирлыг бүс нутгаар нь авч үзвэл 2007-2013 онд учирсан хохирлын 2.1 хувь нь Баруун бүсэд, 5.7 хувь нь Хангайн бүсэд, 6.7 хувь нь Төвийн бүсэд, 1.5 хувь нь Зүүн бүсэд, 84.1 хувь нь Улаанбаатар хотод байна.

2013 онд учирсан хохирлын хэмжээ 97.7 сая төгрөгт хүрч, өмнөх оныхтой харьцуулахад 4.4 дахин нэмэгдсэн байна.

Зураг 5.2.2 Учирсан хохирол, өмчийн хэлбэрээр, хувиар, 2007-2013 он



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2007-2012 онд шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хохирлын дүнд иргэдэд учирсан хохирол зонхилж байснаа 2013 онд шийдвэрлэгдсэн нийт хохирлын 85.0 хувь нь улсад учирсан хохирол байна. Харин аж ахуйн нэгж, байгууллагад учруулсан хохирлын хэмжээ 2009 онд нийт хохирлын 65.4 хувьд хүрч байсан бол 2010-2012 онуудад 10.2-29.3 хувийг эзэлж байгаад 2013 онд буурч 2.3 хувь болсон байна.

5.3 УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд)

Шүүхийн шийдвэрийн дагуу Шийдвэр гүйцэтгэх газарт ирсэн хэргийн нөхөн төлүүлэлтийн талаар өгүүлнэ.

Хүснэгт 5.3.1 Нөхөн төлүүлэлт, хэргийн шийдвэрээр, тэрбум.төг
 2007-2013 он

Он	Үзүүлэлт	Гүйцэтгэвэл зохиx	Гүйцэтгэсэн бүгд	Үүнээс:					
				Иргэний хэргийн шийдвэртэй		Эрүүгийн хэргийн шийдвэртэй		Бусад шийдвэртэй	
				Гүйцэтгэвэл зохиx	Гүйцэтгэсэн	Гүйцэтгэвэл зохиx	Гүйцэтгэсэн	Гүйцэтгэвэл зохиx	Гүйцэтгэсэн
2007 он	Гүйцэтгэх хуудас	18 589	11 238	13 618	8 720	4 472	2 154	499	364
	Мөнгөн дүн	35.0	25.4	30.3	22.4	3.2	1.7	1.4	1.3
2008 он	Гүйцэтгэх хуудас	18 867	12 320	13 404	9 539	4 845	2 459	438	322
	Мөнгөн дүн	47.0	36.8	40.5	32.6	6.2	3.9	0.3	0.2
2009 он	Гүйцэтгэх хуудас	21 730	14 147	16 312	11 365	4 935	2 417	483	365
	Мөнгөн дүн	56.7	42.9	52.6	40.9	4.0	1.9	0.2	0.1
2010 он	Гүйцэтгэх хуудас	25 288	15 411	19 519	12 494	5 165	2 447	604	470
	Мөнгөн дүн	193.4	83.1	183.6	79.1	8.8	3.0	1.1	1.0
2011 он	Гүйцэтгэх хуудас	22 155	14 292	16 255	11 096	5 374	2 758	526	438
	Мөнгөн дүн	189.2	83.6	173.3	80.3	15.5	3.0	0.3	0.2
2012 он	Гүйцэтгэх хуудас	22 050	14 545	15 530	10 694	6 111	3 509	409	342
	Мөнгөн дүн	223.8	89.8	196.6	82.0	18.8	5.3	8.4	2.5
2013 он	Гүйцэтгэх хуудас	23 839	16 077	15 938	10 953	7 460	4 747	441	377
	Мөнгөн дүн	823.7	507.5	364.9	89.0	34.4	4.9	424.5	413.6

Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Энэ бүлэгт 2013 онд Шийдвэр гүйцэтгэх газар 23839 гүйцэтгэх хуудсанд хамрагдах 823.7 сая төгрөгийн үйл ажиллагааг гүйцэтгэх ёстойгоос 16077 гүйцэтгэх хуудсанд хамрагдах 507.5 сая төгрөгийн үйл ажиллагааг гүйцэтгэжээ.

Сүүлийн 7 жилийн байдлаар Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаагаар 1.6 их наяд төгрөгийн хохирол барагдуулах ёстой байснаас 869.1 тэрбум төг буюу 55.4 хувийг нөхөн төлүүлсний 426.3 тэрбум төгрөг нь Иргэний хэргийн шийдвэртэй, 23.7 тэрбум төг нь Эрүүгийн хэргийн шийдвэртэй, 418.9 тэрбум төг нь Бусад шийдвэртэй хэргийн хохирлын нөхөн төлүүлэлт байна.

Зураг 5.3.1 Нөхөн төлүүлэлт, хэргийн шийдвэрээр, тэрбум.төг, 2007-2013 он



Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Энэ удаагийн баримтын судалгаагаар Эрүүгийн гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн дүр төрх, учирсан хохирол, түүний нөхөн төлүүлэлт, хохирогчийн эрхийг хэрхэн хамгаалж буй талаар судалж байгаа тул энд зөвхөн Эрүүгийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, түүнд учирсан хохирол, түүнийг хэрхэн нөхөн төлүүлж байгаа талаар судлахыг зорилоо.

Улсын хэмжээгээр 2013 онд Эрүүгийн гэмт хэргийн улмаас 7460 гүйцэтгэх хуудсанд холбогдох 34.4 тэрбум төгрөгийн хохирлыг барагдуулахаас 4.9 сая төг буюу 14.2 хувийг барагдуулжээ.

Эрүүгийн хэргийн шийдвэртэй нөхөн төлбөрт Иргэн, Байгууллага, Хорихоос өөр төрлийн ялын, Хорих ял эдэлж буй төлбөр төлөгчийн, Үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, гүйцэтгүүлэхгүй байх үйл ажиллагааны төлбөрүүд багтана. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд хохирогчийн талаарх мэдээлэл дутагдалтай тул байгаа мэдээллийн хэмжээнд тодорхойлсон болно.


Хүснэгт 5.3.2 Хохирлын нөхөн төлүүлэлт, бүс, аймаг, нийслэлээр, сая.төг, 2007-2013 он

Аймаг, нийслэл	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Улсын дүн	2357.0	6112.7	2605.7	5214.8	4909.3	8011.8	7382.5
Баруун бүс	178.4	210.8	198.2	120.2	224.3	221.1	478.3
Баян-Өлгий	14.8	20.2	9.2	8.3	13.0	52.3	17.2
Говь-Алтай	43.1	19.3	13.2	10.8	32.3	62.6	78.4
Завхан	19.8	51.4	27.5	2.2	11.4	23.0	22.2
Увс	78.7	83.8	48.2	21.9	112.9	53.3	266.0
Ховд	22.0	36.1	100.1	77.0	54.7	29.9	94.5
Хангайн бүс	245.1	306.4	216.0	190.5	298.1	587.5	923.1
Архангай	14.9	34.6	27.0	12.0	16.9	38.9	56.5
Баянхонгор	17.9	50.5	53.0	24.2	46.9	45.5	40.6
Булган	41.9	13.7	10.6	26.2	33.9	140.9	56.8
Орхон	73.0	92.8	68.7	91.5	111.0	235.3	186.4
Өвөрхангай	37.2	51.7	25.0	21.9	75.0	75.8	147.9
Хөвсгөл	60.2	63.1	31.7	14.7	14.4	51.1	434.9
Төвийн бүс	551.8	1140.7	741.2	387.7	521.9	1661.1	731.1
Говьсүмбэр	1.9	3.3	7.0	9.8	23.9	23.5	34.5
Дархан-Уул	25.9	33.2	53.1	142.8	76.4	80.5	167.9
Дорноговь	429.4	517.7	157.3	58.1	83.7	434.9	121.2
Дундговь	13.2	13.8	7.5	22.2	13.1	39.3	13.5
Өмнөговь	13.3	414.8	338.4	42.9	120.3	839.7	112.3
Сэлэнгэ	38.6	27.7	88.4	70.8	52.6	63.8	85.1
Төв	24.7	105.2	75.1	26.5	107.4	146.9	164.4
Багануур	4.8	25.0	14.4	14.6	44.5	32.5	32.2
Зүүн бүс	705.9	2267.7	748.2	2311.7	1981.5	2823.0	2729.9
Дорнод	8.7	33.4	11.3	20.3	25.3	22.7	113.1
Сүхбаатар	12.3	30.9	11.3	51.8	26.1	45.0	54.8
Хэнтий	9.1	16.3	23.5	34.9	46.6	36.2	41.9
Улаанбаатар	675.8	2187.1	702.1	2204.7	1883.5	2719.1	2520.1

Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

5.4 НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ (Прокурорын шатанд)

Зураг 5.4.1 Прокурорын хяналтын шатан дахь хохирлын нөхөн төлүүлэлт, бүс, аймаг, нийслэлээр, дүнд эзлэх хувиар, 2007-2013 он



Эх үүсвэр: Улсын Прокурорын ерөнхий газар

Хүснэгт 5.4.1 Нөхөн төлүүлэлт, сая.төг, 2007-2013 он

	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2007-2013	7 жилийн дундаж
Улсын дүн	3136.0	5288.7	6132.5	9873.5	87020.5	43916.7	18736.9	174104.8	24872.1
Баруун бүс	210.3	297.1	544.9	351.5	1581.3	812.0	1121.8	4918.9	702.7
Хангайн бүс	214.0	488.5	568.2	473.2	81040.5	2085.8	1644.3	86514.5	12359.2
Төвийн бүс	343.0	974.7	964.5	1116.1	1977.5	3126.4	4046.2	12548.4	1792.6
Зүүн бүс	152.7	241.0	500.0	840.9	853.6	1558.1	788.2	4934.5	704.9
Улаанбаатар	2200.0	3220.9	3400.0	6968.0	481.4	34622.6	9781.5	60674.4	8667.8
Тээвэр	16.0	66.5	154.9	123.8	1086.2	1711.8	1354.9	4514.1	644.9

Эх үүсвэр: Улсын Прокурорын ерөнхий газар

Сүүлийн 7 жилд Прокурорын хяналтын шатанд 174.1 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлсэн бөгөөд жилд дунджаар 24.9 тэрбум төгрөгийн хохирол барагдуулжээ.

Нөхөн төлүүлэлтийг бүс нутгаар нь авч үзэхэд сүүлийн 7 жилд нөхөн төлүүлсэн хохирлын 4.9 тэрбум.төг буюу 2.8 хувийг Баруун бүсэд, 86.5 тэрбум.төг буюу 49.7 хувийг Хангайн бүсэд, 12.5 тэрбум.төг 7.2 хувийг Төвийн бүсэд, 4.9 тэрбум.төг буюу 2.8 хувийг Зүүн бүсэд, 60.7 тэрбум.төг буюу 34.8 хувийг Улаанбаатар хотод, 4.5 тэрбум.төг буюу 2.6 хувийг Тээврийн прокурорын газар нөхөн төлүүлжээ.

Хүснэгт 5.4.2 Хохирол нөхөн төлүүлэлт, бүс, аймаг, нийслэлээр, сая.төг,
2007-2013 он


Аймаг, нийслэл	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Улсын дүн	3136.0	5288.7	6132.5	9873.5	87020.5	43916.7	18736.9
Баруун бүс	210.3	297.1	544.9	351.5	1581.3	812.0	1121.8
Баян-Өлгий	3.2	58.0	49.2	85.2	125.9	220.0	141.1
Говь-Алтай	2.6	8.3	8.1	1.9	10.1	26.1	109.0
Завхан	21.0	71.6	71.7	60.4	102.4	13.0	260.6
Увс	27.5	26.4	48.9	38.8	216.9	356.0	140.4
Ховд	156.0	132.8	367.0	165.2	1126.0	196.9	470.7
Хангайн бүс	214.0	488.5	568.2	473.2	81040.5	2085.8	1644.3
Архангай	6.8	42.6	43.6	57.1	151.6	253.2	270.3
Баянхонгор	22.5	76.8	78.9	1.7	68.5	76.1	116
Булган	35.3	120.0	90.7	1.2	79865.4	80.5	72.8
Орхон	12.5	22.0	11.0	220.0	500.1	881.4	449.9
Өвөрхангай	34.1	98.7	167.8	121.7	165.5	161.5	394.4
Хөвсгөл	102.8	128.4	176.2	71.5	289.4	633.1	340.9
Төвийн бүс	343.0	974.7	964.5	1116.1	1977.5	3126.4	4046.2
Говьсүмбэр	9.2	28.8	31.0	1.7	74.7	72.9	122.8
Дархан-Уул	113.0	315.0	272.0	568.2	225.6	124.2	411.3
Дорноговь	7.0	7.0	7.7	26.8	967.5	154.9	350.5
Дундговь	29.3	177.7	250.5	202.0	121	84.1	106.0
Өмнөговь	67.8	75.2	127.0	131.0	448.2	1020.0	404.1
Сэлэнгэ	12.7	260.8	197.9	152.3	140.1	1278.2	1718
Төв	104.0	110.2	78.4	34.1	0.4	392.1	933.5
Зүүн бүс	152.7	241.0	500.0	840.9	853.6	1558.1	788.2
Дорнод	56.8	117.8	153.5	400.0	320.5	802.2	388.0
Сүхбаатар	30.2	99.2	142.3	45.5	47.9	42.6	170.5
Хэнтий	65.7	24.0	204.2	395.4	485.2	713.3	229.7
Улаанбаатар	2200	3220.9	3400.0	6968.0	481.4	34622.6	9781.5
Тээвэр	16.0	66.5	154.9	123.8	1086.2	1711.8	1354.9

Эх үүсвэр: Улсын прокурорын ерөнхий газар

5.5 УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ(АТГ)

5.5-д авилгын хэргийн улмаас ямар хэмжээний хохирол учирсан, түүний нөхөн төлүүлэлт хэрхэн явагддаг талаар тодорхойлохыг зорилоо.

Зураг 5.5.1 Авилгын хэргээс учирсан хохирол ба нөхөн төлүүлэлт, сонгосон оноор



Эх үүсвэр: Авилгатай тэмцэх газар

Сонгосон 5 жилийн дунджаар жил тутам Авилгатай тэмцэх байгууллага 160 орчим иргэнд таслан сэргийлэх арга хэмжээ авчээ.

2007 онд учирсан хохирлын 0.5 тэрбум төг буюу 1.8 хувь, 2008 онд учирсан хохирлын 4.4 тэрбум төг буюу 14.1 хувь, 2009 онд 1.4 тэрбум төг буюу 4.7 хувь, 2011 онд 1.1 тэрбум төг буюу 4.8 хувь, 2013 онд 6.5 тэрбум буюу 7.6 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Хүснэгт 5.5.1 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, өмчийн хэлбэр, сонгосон оноор, сая.төг

	Учирсан хохирол. сая.төг				Нөхөн төлүүлэлт. сая.төг			
	Төрийн	Гадаадын хөрөнгө оруулалттай	Хамтарсан	Хувийн	Төрийн	Гадаадын хөрөнгө оруулалттай	Хамтарсан	Хувийн
2007 он	20232.4	20.0	2563.7	4393.2	19.6	-	13.0	21.3
2008 он	26497.5	297.3	355.9	3954.5	1223.1	6.5	318.2	2821.4
2009 он	27753.2	102.9	294.4	1624.1	602.2	36.0	7.5	757.5
2011 он	21840.5	241.5	-	658.1	959.9	66.9	-	90.8
2013 он	80890.4	3505.0	-	1512.0	6416.8	141.0	-	-

Эх үүсвэр: Авилгатай тэмцэх газар

5.6 УЧИРСАН ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ, хууль сахиулах байгууллагаар


Хүснэгт 5.6.1 Нөхөн төлүүлэлт, тэрбум.төг, 2007-2013 он

	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2007-2013
ЦЕГ	4.0	7.0	18.0	14.3	18.5	25.1	111.3	198.2
ШЕЗ	1.2	9.7	1.2	1.9	1.7	2.1	90.8	108.6
ШШГЕГ	2.4	6.1	2.6	5.2	4.9	8.0	7.4	36.6
Прокурор	3.1	5.3	6.1	9.9	87.0	43.9	18.7	174.0
Дүн	10.7	28.1	27.9	31.3	112.1	79.1	228.2	517.4

Эх үүсвэр: ЦЕГ, ШЕЗ, УПЕГ, ШШГЕГ

Сүүлийн 7 жилд хууль сахиулах байгууллагууд нийт 517.4 тэрбум төгрөгийн хохирлыг барагдуулсан бөгөөд улсын хэмжээнд жилд дунджаар 73.9 тэрбум төгрөгийн хохирол барагдуулсан байна. Үүний 28.3 тэрбум төгрөгийг Цагдаагийн ерөнхий газар, 15.5 тэрбум төгрөгийг Шүүхийн ерөнхий зөвлөл, 5.2 тэрбум төгрөгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 24.9 тэрбум төгрөгийг Улсын прокурорын ерөнхий газар нөхөн төлүүлсэн байна.

Зураг 5.6.1 Нөхөн төлүүлэлт, бүтцээр, хууль сахиулах байгууллагаар, 2007-2013 он



Эх үүсвэр: ЦЕГ, ШЕЗ, УПЕГ, ШШГЕГ

Сүүлийн 7 жилд хууль сахиулах байгууллагуудын нийт нөхөн төлүүлэлтийн 38.3 хувийг ЦЕГ, 33.6 хувийг УПЕГ, 21.0 хувийг ШЕЗ, 7.1 хувийг ШШГЕГ нөхөн төлүүлсэн байна.

Сүүлийн 7 жилд улсын хэмжээнд 148818 гэмт хэрэг бүртгэгдэж, 144014 иргэн, 2665 байгууллагад 415.1 тэрбум.төг-н хохирол учирсан боловч хууль сахиулах 4 байгууллага 7 жилийн туршид 517.4 тэрбум.төг-г нөхөн төлүүлжээ (Хүснэгт 5.6.1).

Эндээс үзэхэд ЦЕГ-т бүртгэгдсэн хэргийн хохирлоос нөхөн төлүүлэлт их байгаа нь Прокурор, Шүүхээр хэрэг хянагдах шатанд хохирлыг дахин үнэлэсэн байх талтай боловч нөгөөтэйгүүр өмнөх онуудын хуримтлагдсан хохирлыг нөхөн төлүүлсэн байх талтай. Иймээс хууль сахиулах байгууллага бүр өөр өөрсдийн үйл ажиллагааны шатанд хохирлыг дахин үнэлэсэн эсэх талаар мэдээлэлтэй байх нь зүйтэй байна. Нөгөөтэйгүүр Цагдаагийн байгууллага хэрэг бүртгэх шатанд учирсан хохирлыг шууд үнэлж бүртгэхэд зарим хэргийн хувьд хүндрэлтэй байдаг тул хэрэг бүртгэх үеийн хохирлын хэмжээ нь хөдөлшгүй бодит тоо биш бөгөөд хууль сахиулах байгууллагууд болон хохирол үнэлэх багийн үйл ажиллагааны явцад хохирол үнэн зөвөөр үнэлэгдэх процесс явагддаг байна.

Хүснэгт 5.6.2 Гэмтсэн ба нас барсан иргэд, 2012-2013 он

	Цагдаагийн ерөнхий газар		Шүүхийн ерөнхий зөвлөл	
	2012 он	2013 он	2012 он	2013 он
Гэмтсэн иргэд	8436	9797	2963	2693
Нас барсан иргэд	901	949	654	555

Эх үүсвэр: ЦЕГ, ШЕЗ

2013 онд улсын хэмжээнд 25362 гэмт хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 9797 иргэн гэмтэж, 949 иргэн нас барснаас гэмтсэн 2693, нас барсан 555 иргэнтэй холбоотой хэрэг Шүүхээр шийдвэрлэгджээ. Улсын хэмжээнд 2013 онд 6161 хэрэг Шүүхээр шийдвэрлэгдсэн нь бүртгэгдсэн гэмт хэргийн 24.3 хувь байна.

5.7 ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хууль сахиулах байгууллагууд гэмтсэн иргэдийн эрүүл мэндийг нөхөн сэргээх үүднээс гэмт этгээдээс эрүүл мэнд, эмчилгээний зардлыг нөхөн төлүүлэх болон бусад нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авдаг боловч энэ нь гэмт хэрэг үйлдэгчийн төлбөрийн чадвараас шалтгаалж хэрэгжилт нь харилцан адилгүй явагддаг байна.

Харин нас барсан иргэдийн хувьд ар гэрийн нэхэмжлэлийн дагуу гэмт этгээдээс оршуулгын зардал гаргуулах, эмчилгээний зардал нөхөн төлүүлэх гэх мэт нөхөн төлбөрийг төлүүлэх шаардлагыг хууль сахиулах байгууллагууд тавьдаг ч энэ нь мөн л тухайн гэмт этгээдийн төлбөрийн чадвараас шалтгаалж харилцан адилгүй төлөгддөг байна. Иймээс гэмт этгээдийг Цагдан хорихоос илүү хохирогчийн хохирлыг барагдуулах талын арга хэмжээг илүү эрчимжүүлж ажиллах хэрэгцээ шаардлага байгаа юм.

Хууль сахиулах байгууллагуудын зүгээс хохирогчид хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйл ажиллагаа явуулах, аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ч энэ нь үр нөлөө багатай байна. Хохирогчийн эрхийг хамгаалах талаар хийж байгаа үйл ажиллагааны эхлэл байгаа ч энэ чиглэлийн мэдээлэл хууль сахиулах байгууллагуудын хувьд дутагдалтай байна.

БҮЛЭГ 6. ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЧАНАР, УЯЛДАА ХОЛБОО

Энэ удаагийн баримтын судалгаагаар бид зөвхөн гэмт хэргийн хохирогчийн талаар судлаад зогсохгүй гэмт хэргийн статистикийн мэдээллийн уялдаа холбоо ямар байгааг тодорхойлохыг зорилгоо.

Гэмт хэрэг, хууль сахиулахын статистикийн хөгжил нь хууль сахиулах системийн үйл ажиллагаатай нягт холбоотой хөгждөг. Гэмт хэрэг, хууль сахиулахын статистик нь хууль сахиулах үйл ажиллагааны удирдлага, төлөвлөлт, бодлого боловсруулалтын хамгийн чухал, асуудлуудад байнга хамгийн бодитой хариултыг өгдөг салбар шинжлэх ухаан юм.

Үндэсний болон олон улсын байгууллагуудын дунд, гэмт хэрэг болон эдийн засгийн өсөлт, хөгжлийн хоорондын харилцааг ойлгох, хянахад гэмт хэрэг, хууль сахиулахын статистикийн үүрэг, ач холбогдол их юм.

Гэмт хэрэг, хууль сахиулахын статистикийн үндэсний тогтолцооны хөгжил нь цогц үйл явц юм. Энэ нь Цагдаа, Прокурор, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Авилгатай тэмцэх газар зэрэг системийн олон бүрэлдэхүүн хэсгийн оролцоо, хамтын ажиллагааг шаарддаг.

Гэмт хэрэг нь тодорхой цаг хугацаа, орон зай, нутаг дэвсгэрт буй болдог өөрийн гэсэн өвөрмөц онцлог, зүй тогтол, шинж чанар бүхий нийгмийн сөрөг үзэгдэл юм. Гэмт хэрэг бол өөрөө нийгмийн амьдралын сөрөг үр дагавар бөгөөд улс орны эдийн засаг доройтож ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, үнэ, инфляци өсөхийн хирээр гэмт хэргийн гаралт ч бас нэмэгдэж байдаг зүй тогтолтой. Энэ ч утгаараа гэмт хэргийн статистикийн үзүүлэлтийг олон улсын түвшинд амьдралын чанарын үзүүлэлтэд тооцдог байна.

Гэмт хэргийн статистик нь гэмт хэрэг, зөрчилтэй холбогдолтой тоо мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэй, зохион байгуулалттайгаар цуглуулж, нэгтгэн боловсруулж, гэмт хэрэг зөрчлийн тоон талыг чанартай нь уялдуулан тодорхой орон зай, цаг хугацаанд нь судалж, анализ дүн шинжилгээ хийдэг салбарын статистик төдийгүй гэмт хэргийн хохирогчийн талаарх салбар шинжлэх ухааныг өөртөө багтааж судалдаг судлах цар хүрээний хувьд маш их мэдээллийг агуулдаг томоохон салбарын нэг юм.

Гэмт хэрэг, хууль сахиулахын статистикээр гэмт хэргийн гаралт, тархалт, бүтэц, хөдөлгөөн, гэмт хэрэг үүсэж буй шалтгаан, нөхцөл зэргийг судлахаас гадна гэмт хэрэгтний нийгэм, хувь хүн байгуулагад учруулсан хохирол, хохирлын нөхөн төлүүлэлт, гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах талаарх хууль сахиулах байгууллагуудаас хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрийн хэрэгжилт, хохирогчийн эрхийг хамгаалах талаарх хууль эрх зүйн орчин ямар хэмжээнд байгаа, гэмт хэргийн хохирогчийн эрхийн хамгаалалт ямар түвшинд байгаа, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт ямар хэмжээнд байгаа гэх мэтчлэн олон асуудлыг хөндөн судалдаг.

Гэмт хэргийн статистикийн мэдээллийн гол эх үүсвэр нь одоогоор Цагдаагийн ерөнхий газрын сар бүрийн мэдээ, Улсын Дээд Шүүхийн хагас, бүтэн жилийн тайлан байна. Эдгээр мэдээллийн эх үүсвэрт үндэслэж гэмт хэрэг, гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогч, хохирогч, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, ял шийтгэгдсэн хүний тоо, шүүхээр шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргаан зэрэг үзүүлэлтийг сар, улирал, жилийн давтамжтайгаар гаргаж, бюллетень, танилцуулга, эмхэтгэлд тусган нийтэд хүргэж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2007 онд зохион байгуулж явуулсан “Хохирогчийн эрхийн баталгаа” үндэсний чуулганаар гэмт хэрэгт холбогдсон, шийтгэгдсэн хүмүүсийн тоо, тэдгээрт хамаарах мэдээллүүдийг аль ч газрын тайлан мэдээнээс харж болохоор атал гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч, учирсан хохирол, нөхөн төлүүлэлтийн талаарх мэдээллийн нэгдсэн тогтолцоо өнөөг хүртэл бүрдээгүй байна. Хохирогч нэг бүрээр хийсэн судалгаа, тооцоогүйгээр, хохирол нөхөн төлөгдөж, хөндөгдсөн эрх нь сэргээгдсэн эсэхэд тавих нэгдсэн бүртгэлгүйгээр Үндсэн хуульд заасны дагуу” Хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх...” талаар хүлээсэн үүргээ төр зохих ёсоор биелүүлэх боломжгүй юм. Иймд юуны өмнө гэмт хэргийн хохирогчийг нэг бүрчлэн бүртгэж, нэгдсэн мэдээ тайлан гаргадаг, хохирол төлөгдөөгүй шалтгаан нөхцөл болгоныг авч үзэж, хохирогчийн өмнөөс асуудлыг шийдвэрлэдэг тогтолцоонд нэн даруй шилжих хэрэгтэй байна.

Хохирогчийн эрхийн баталгааг хангахын тулд юуны өмнө хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэх, түүний аюулгүй байдлыг хамгаалах тухай төрөлжсөн хуулиуд гаргаж, хохирогчийн нэгдсэн бүртгэлтэй болж, хохирлын үнэлгээг нарийвчлан тогтоох шалгуур, журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх нь зүйтэй.

Мөн энэ асуудалд шинжлэх ухааны үндэстэй хандаж, хохирогч судлалын шинжлэх ухааныг эх орондоо хөгжүүлэх, энэ чиглэлийн сургалт, судалгааны ажлыг дэмжих бодлогыг баримтлах хэрэгтэй байна. Хохирогчийн эрхийн баталгаа нь зөвхөн эрх зүйн баримт бичигт тусгагдснаар бус, түүнийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, мөн иргэдийн мэдлэг, боловсрол, сонор, сэрэмжтэй байдал, нийгмийн бүхий л харилцаа хариуцлагатай болохоос шууд хамааралтай юм. Ний нуугүй хэлэхэд өнөөдөр манай нийгмийн харилцаанд хариуцлагагүй байдал ихээхэн газар авсан тул хохирогчийн тоо нь олон, асуудал нь хурц болж байна. (Хохирогчийн эрхийн баталгаа, үндэсний чуулган, 2007 он)

2007 оны “Хохирогчийн эрхийн баталгаа” үндэсний чуулганаас хойш Монгол Улсын Цагдаа, Шүүхийн байгууллага хохирогчийн талаар тодорхой мэдээллийн сантай болж, Хууль зүйн яам, төрийн бус байгууллагуудаас ч гэмт хэргийн хохирогчийн өнөөгийн байдал, хохирогчийн эрх зүйн хамгаалалт, хууль эрх зүйн орчинг сайжруулах хэрэгцээ, шаардлагыг судалсан олон судалгаа хийгдсэн хэдий ч өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангах хэмжээнд хүрээгүй байна.

ҮСХ, гэмт хэргийн статистикийн хүрээнд ЦЕГ, УПЕГ, ШЕЗ, АТГ, ШШГЕГ-ын захиргааны болон албан ёсны мэдээллийг цуглуулж, боловсруулж, тархаах үүрэгтэй боловч дээрх байгууллагуудын мэдээллийн чанар, үзүүлэлтийн оновчтой байдал харилцан адилгүй явж ирсэн байна. Энэ удаагийн хохирогчтой холбоотой мэдээлэл цуглуулалтаар ч эдгээр байгууллагуудын захиргааны болон албан ёсны статистикийн мэдээллийн чанар, уялдаа хангалтгүй болох нь тод томруун харагдсан гэж хэлж болно.

Сүүлийн жилүүдэд Хууль зүйн яам болон хууль сахиулах байгууллагууд хамтарсан ажлын хэсэг байгуулж, хамтран ажиллах санамж бичиг байгуулан хууль эрх зүйн системийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах талаар санаачлага гарган ажиллаж байгаа ч өнөөдрийн байдлаар ахиц дэвшил гарахуйц ажил хийгдээгүй байна.

Цагдаагийн ерөнхий газар. Энэ байгууллагын хувьд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, сэжигтэн яллагдагч, гэмт хэргийн төрөл, гэмт хэрэг үйлдсэн цаг, хугацаа, үйлдэгдсэн байдал, газар, байршил, гэмт хэргийн илрүүлэлт, гэмт хэргийн хохирогч иргэн, байгууллага, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, хохирогчийн нас, хүйс,

нийгмийн байдал, захиргааны зөрчил, эрүүлжүүлэгдсэн хүний тоо гэх мэтчлэн бусад хууль сахиулагч байгууллагуудаас гардаггүй олон үзүүлэлтийг цогц байдлаар нь бүс, аймаг, нийслэлээр нь сар бүр гаргаж албан ёсны мэдээлэл хэлбэрээр нийтэд тархаадаг.

Энэ ч утгаараа Цагдаагийн ерөнхий газрын захиргааны статистикийн мэдээлэл нь гэмт хэргийн статистикийн мэдээллийн суурь эх үүсвэр болдог онцлогтой.

Хууль сахиулах байгууллагуудаас ЦЕГ-ын МТТ-ийн мэдээллийн чанар, уялдаа холбоо, цогц байдал бусдаас олон талаар давуу боловч хохирогчтой холбоотой мэдээлэл цуглуулах, боловсруулах явцад зарим чухал үзүүлэлтүүд гарахгүй, зарим үзүүлэлтийг гаргах боломжгүй байдал ажиглагдаж байсан.

ЦЕГ хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн эх үндэс суурь нь болохын хувьд мэдээллийн чанар, уялдаа холбоог сайжруулахад анхаарч ажилладаг хамт олон гэдэг нь тэдний хийсэн бүтээснээс тодорхой байсан. Гэвч хамтран ажилладаг хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа, үйл ажиллагааны доголдлоос болж системийн мэдээллийн уялдаа, чанарт сөргөөр нөлөөлж байна.

2010 оны 04-р сард Авилгатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Улсын Прокурорын ерөнхий газрын дарга нарын 43/182/223/211 тоот хамтарсан тушаалаар Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягтыг нөхөх, мэдээллийн санд төвлөрүүлэх тухай журмыг баталсан нь сайшаалтай хэрэг боловч хэрэгжилт нь муу байна. Тухайлбал: Сар бүр ЦЕГ-аас гардаг статистикийн мэдээлэлд АТГ, УПЕГ, ТЕГ мэдээллээ өгдөг гэх боловч өнөөдрийн түвшинд Цагдаад ирүүлсэн мэдээлэл судалгаагаар цуглуулсан мэдээллийн хооронд хол зөрүү ажиглагдаж байна.

Хүснэгт 6.1.1 Цагдаагийн ерөнхий газрын 2010-2013 оны албан ёсны мэдээлэлд АТГ, УПЕГ, ТЕГ-ын өгсөн мэдээлэл

	Учирсан хохирол. сая төг				Нөхөн төлүүлэлт. сая төг			
	Цагдаагийн ерөнхий газар	Үүнээс:			Цагдаагийн ерөнхий газар	Үүнээс:		
Авилгатай тэмцэх газар		Улсын Прокурорын ерөнхий газар	Тагнуулын ерөнхий газар	Авилгатай тэмцэх газар		Улсын Прокурорын	Тагнуулын ерөнхий газар	
2010 он	33383.0	406.8	149.5	14.4	14347.2	82.3	8.2	14.4
2011 он	35904.1	6.0	205.2	1.0	18490.4	2.4	157.0	0.8
2012 он	53263.2	0.5	158.9	10.7	25 135.6	0.5	129.2	4.2
2013 он	159024.2	11.1	45.6	169.1	111266.6	11.1	21.4	14.6

Эх үүсвэр: Засгийн газрын тохируулагч агентлаг ЦЕГ

ЦЕГ-ын албан ёсны мэдээлэлд АТГ, УПЕГ-ийн өгч буй мэдээллийг УПЕГ-ын судалгаагаар цуглуулсан мэдээлэл, АТГ-ын ҮСХ-нд ирүүлдэг мэдээлэлтэй харьцуулахад ЦЕГ-т өгсөн мэдээлэл дутуу байгаа нь ажиглагдаж байна (Хүснэгт 6.1.1).

Хүснэгт 6.1.2 Авилгатай тэмцэх газрын ҮСХ болон ЦЕГ-т өгсөн мэдээллийн зөрүү, сая.төг

	ҮСХ		ЦЕГ	
	Учирсан хохирол	Нөхөн төлбөр	Учирсан хохирол	Нөхөн төлбөр
2011 он	22.7	1.1	6.0	2.4
2013 он	85.9	6.5	11.1	11.1

Эх үүсвэр: Авилгатай тэмцэх газар

Хүснэгт 6.1.3 Улсын Прокурорын ерөнхий газрын ҮСХ болон ЦЕГ-т өгсөн мэдээллийн зөрүү, сая.төг

	ҮСХ		ЦЕГ	
	Учирсан хохирол	Нөхөн төлбөр	Учирсан хохирол	Нөхөн төлбөр
2010 он	-	9873.5	149.5	8.2
2011 он	-	87020.5	205.2	157.0
2012 он	-	43916.7	158.9	129.2
2013 он	-	18736.9	45.6	21.4

Эх үүсвэр: УПЕГ

Хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоо, үнэн зөв бодит байдал ямар хэмжээнд байгааг харж болно (Хүснэгт 6.1.3).

Улсын прокурорын ерөнхий газар. Энэ байгууллагын хувьд ҮСХ-нд жил, улирал, сараар мэдээлдэг албан ёсны мэдээлэл байхгүй. Баримтын судалгаанд зөвхөн нөхөн төлүүлэлтийн үзүүлэлтийг аймаг, нийслэлээр цуглуулж өгсөн. Олон улсын түвшинд Прокурорын байгууллагаас гаргадаг мэдээллүүд ч гарахгүй байна. Цаашид Эрүүгийн гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн судалгааны үндсэн үзүүлэлтүүд болон Прокурорт хянагдсан хэргийн тоог олон улсын түвшинд харьцуулагдах хэмжээнд гаргаж мэдээлдэг болох хэрэгцээ шаардлага байна. Хүснэгт 5.4-ээс харахад УПЕГ-ын мэдээлэл хууль сахиулах бусад байгууллагуудын мэдээлэлтэй уялдаа холбоогүй явж байгаа нь ч харагдаж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл. Энэ байгууллагын хувьд хагас, бүтэн жилээр ҮСХ-нд 13 маягтаар мэдээллээ өгч, нийтэд тархаадаг. Гэмт хэргийн хохирогчийн талаарх баримтын судалгаанд 231 үзүүлэлтээр мэдээлэл цуглуулж оролцсон. Цаашид мэдээллийн чанар, уялдаа холбоог сайжруулах, үзүүлэлтийг оновчтой болгох хэрэгцээ шаардлага байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн хувьд хохирогч иргэн, байгууллагын талаарх мэдээлэл дутагдалтай байгаа нь анализ хийх явцад харагдаж байсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. Энэ байгууллагын хувьд сар бүрийн 4-ний дотор Шийдвэр гүйцэтгэх албаны ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн мэдээг ирүүлдэг. Хохирогчтой холбоотой баримтын судалгаанд 140 үзүүлэлтээр мэдээлэл цуглуулж ирүүлсэн боловч анализ, дүн шинжилгээ хийхэд хэрэгтэй чухал үзүүлэлтүүд бага байсан. Тухайлбал: Хүүхдийн тэтгэлэгийн мэдээлэл гэхэд зөвхөн гүйцэтгэх хуудсаар гарч, тэтгэлэг авсан хүүхдийн тоо, авсан тэтгэлэгийн хэмжээ, олгогдоогүй тэтгэлэгийн хэмжээ, тэтгэлэг авч чадаагүй хүүхдийн тоо, тэтгэлэг олгогдоогүй шалтгаан зэрэг зайлшгүй шаардлагатай мэдээлэл хэрэгцээ хангах хэмжээнд үгүй байна.

Бүлэг 5-н дүгнэлт. Судалгааны дүн шинжилгээний явцад хохирогчтой холбоотой болон захиргааны статистикийн мэдээлэл дутагдалтай, чанар, үзүүлэлт хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаа нь ажиглагдаж байна. Иймд цаашид хууль сахиулах байгууллагууд мэдээллийн уялдаа холбоог хангах, чанарыг сайжруулах, үзүүлэлтийг оновчтой, олон улсын жишигт нийцүүлж гаргах хэрэгцээ шаардлага байна. Улсын хэмжээгээр нэг гэмт хэрэгт нэг л дугаар өгч хавтаст хэрэг нээдэг ба нэг гэмт хэрэг ЦЕГ, УПЕГ, ШЕЗ, ШШГЕГ, АТГ, ТЕГ гэх мэт хууль сахиулах байгууллагуудыг дамжиж эцсийн дүнд ямар байдлаар шийдвэрлэгдсэн нь хууль зүйн мэдээллийн нэгдсэн сангаас шууд харагдах хэмжээнд очиж байж сая хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоо харагдана. Өнөөдрийн байдлаар УПЕГ, АТГ -ын ҮСХ-нд өгч байгаа мэдээлэл нэг өөр, ЦЕГ-т өгч буй мэдээлэл бас нэг өөр байна.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ДҮР ТӨРХ (2013 оны байдлаар)

- Бүртгэгдсэн 10 гэмт хэрэг тутмын
 - 6 нь нийслэлд
 - 4 нь аймаг, орон нутагт
 - 2 нь аймгийн төвд
 - 3 нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг
 - 1 нь эмэгтэйчүүд оролцсон хэрэг

- Бүртгэгдсэн 10 хэрэг тутмын
 - 4 нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
 - 3 нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байна.
- Өмчлөх эрхийн эсрэг 10 хэрэг тутмын
 - 7 нь бусдын эд хөрөнгийг хулгайлах
 - 5 нь хувийн өмчийг хулгайлах
 - 1 нь бусдын эд хөрөгийг залилан мэхэлж авах

- Халаасны хулгайн хэргийн 92.3 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.


- Нийслэлд бүртгэгдсэн халаасны хулгайн 10 хэрэг тутмын
 - 3 нь Сүхбаатар дүүрэгт
 - 2 нь Баянгол дүүрэгт
- Хүний амь эрүүл мэндийн эсрэг 10 хэрэг тутмын
 - 9 нь бусдын бие махбодид гэмтэл учруулах

- Хүүхэд, гэр бүл, ёс суртахууны эсрэг 10 хэрэг тутмын
 - 8 нь хүчингийн хэрэг байна.

- Гэмт хэргийн илрүүлэлт
 - хамгийн бага аймаг, дүүрэг- Завхан аймаг (41.1%), Баянзүрх дүүрэг (51.8%)-т,
 - хамгийн өндөр аймаг, дүүрэг- Хөвсгөл аймаг (84.1%), Багануур дүүрэг (63.6%) байна.
- Бүртгэгдсэн 10 гэмт хэрэг тутмын
 - 8 нь ажлын цагаар
 - 2 нь Даваа гаригт
 - 4 нь 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн байна.
- Гудамж, талбайд үйлдэгдсэн 10 хэрэг тутмын
 - 4 нь гэр хорооллын гудамжинд үйлдэгджээ.

- Гэр орон сууцанд үйлдэгдсэн 10 хэрэг тутмын
 - 4 нь гэрт
 - 2 нь орон сууцны байранд
 - 2 нь хувийн байшинд
- Хэрэгт холбогдсон 10 хүн тутмын
 - 5 нь ажилгүй иргэд
 - 5 нь 18-29 насны залуучууд
 - 4 нь бүрэн дунд боловсролтой
 - 3 нь ял сонссон
 - 2 нь согтуугаар үйлдсэн

ХОХИРОГЧИЙН ДҮР ТӨРХ*(Цагдаагийн хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд 2013 он)*


 Гэмт хэргийн улмаас Монгол Улсын 10 000 хүн тутмаас

2012 онд


- 74 иргэн хохирсны
- 29 нь эмэгтэй
- 4 нь 18 хүртэлх насны хүүхэд байсан бол

2013 онд


- 85 иргэн хохирсны
- 35 нь эмэгтэй
- 5 нь 18 хүртэлх насны хүүхэд байна.

 Гэмт хэргийн улмаас хохирсон 10 хүн тутмын


- 5 нь 18-34 насны залуучууд
- 6 нь эрэгтэйчүүд
- 3 ажилгүй иргэд байна.

 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 10 хүн тутмын


- 8 нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн
- 6 нь тухайн хүчирхийлэгчийн эхнэр байна.

 Гэмт хэргийн улмаас хохирсон 100 хүн тутмын


- 4 нь нас барсан
- 4 нь гэмтсэн байна.

 Гэмт хэргийн улмаас нас барсан 10 хүн тутмын


- 2 нь санаатай алах гэмт хэрэг
- 4 нь тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- 3 нь эмэгтэй хүн

 Гэмт хэргийн улмаас нас барсан 10 хүүхэд тутмын


- 5 нь авто ослын улмаас

 Гэмт хэргийн улмаас гэмтсэн 10 хүн тутмын


- 6 нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг
- 1 нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг

 Гэмтсэн 100 хүн тутмын


- 8 нь хүнд гэмтэл авсан
- 15 нь хүндэвтэр гэмтэл авсан байна.

 1 хохирогчид ноогдох учирсан хохирлын хэмжээ

- 2012 онд 2.5 сая төгрөг
- 2013 онд 6.4 сая төгрөг

 1 хохирогчид ноогдох хохирол барагдуулалт

- 2012 онд 1.2 сая төгрөг
- 2013 онд 4.4 сая төгрөг

 Захиргааны зөрчлийн улмаас хохирсон 10 хүн тутмын

- 4 нь эмэгтэй
- 3 нь ажилгүй иргэн байна.

ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, ОНООР

	нэгж	2012 он	2013 он	Өөрчлөлт
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	22 089	25 362	↑
хөнгөн	тоо	9 637	11 648	↑
хүндэвтэр	тоо	10 041	11 514	↑
хүнд	тоо	1 914	1 766	↓
онц хүнд	тоо	497	434	↓
Үндэсний аюулгүй байдлын эсрэг	тоо	138	54	↓
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	тоо	7 155	8 156	↑
Хүний эрх, эрх чөлөө, алдар хүндийн эсрэг	тоо	46	55	↑
Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг	тоо	405	425	↑
Иргэдийн улс төрийн болон бусад эрх чөлөөний эсрэг	тоо	126	124	↓
Өмчлөх эрхийн эсрэг	тоо	9 023	11 118	↑
Аж ахуйн эсрэг	тоо	185	234	↑
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	тоо	1 749	1 894	↑
Хүн амын эрүүл мэндийн эсрэг	тоо	295	318	↑
Байгаль хамгаалах журмын эсрэг	тоо	410	337	↓
ТХХАБАЖ-ын эсрэг	тоо	1999	2148	↑
Шүүн таслах ажиллагааны эсрэг	тоо	100	104	↑
Албан тушаалын гэмт хэрэг	тоо	110	106	↓
Цэргийн албаны эсрэг	тоо	16	10	↓
Хохирогч иргэн	тоо	21 294	25 015	↑
Нас барсан	тоо	901	949	↑
Гэмтсэн	тоо	8 436	9 797	↑
Хохирогч байгууллага	тоо	167	157	↓
Учирсан хохирол	тэрбум.төг	53.3	159.0	↑
Нөхөн төлүүлэлт	тэрбум.төг	25.1	111.3	↑
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч иргэд	тоо	8 838	11 012	↑
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол	тэрбум.төг	28.8	72.8	↑
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хохирогч иргэд	тоо	7 167	8 285	↑
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол	тэрбум.төг	2.5	3.9	↑
Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг	тоо	6 161	6 169	↑
Шүүхийн шатанд хохирсон иргэн	тоо	3 617	3 248	↓
Гэмтсэн	тоо	2 963	2 693	↑
Нас барсан	тоо	654	555	↓
Учирсан хохирол	тэрбум.төг	22.0	95.9	↑
Нөхөн төлүүлэлт	тэрбум.төг	2.0	90.8	↑
Прокурорын шатан дахь нөхөн төлүүлэлт	тэрбум.төг	43.9	18.7	↓
Шийдвэр гүйцэтгэх шатан дахь хохирсон иргэд	тоо	2 486	2 912	↑
Хохирогч байгууллага	тоо	704	751	↑
Нөхөн төлүүлэлт	тэрбум.төг	2.7	2.5	↓

Эх үүсвэр: ЦЕГ, ШЕЗ, УПЕГ, ШШГЕГ

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас 1985 онд “ Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал” батлагдсан нь дэлхийн улс орнуудад “Хохирогч судлалын шинжлэх ухаан” үүсэж, хөгжих эрх зүйн гол үндэслэл болсон байна.

Өнөөг хүртэл дэлхийн олон оронд хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр олон ажил хийгдсэний адил, Монгол Улс ч хохирогчийн эрхийг хамгаалах зүйл, заалтыг Монгол Улсын үндсэн хууль (1992), Монгол Улсын Эрүүгийн хууль (2002), Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль(2002), Монгол Улсын Иргэний хууль (2002), Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль (1999), Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль (2001), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиндаа тусгаж, мөрдөж байна. Харин манай орны хувьд хууль эрх зүйн үндэс нь тавигдсан боловч хохирогчийн эрхийг хамгаалах механизм, хохирлыг тогтоох арга зүй, хохирогчид үйлчлэх үйлчилгээ, нийгмийн халамж, дэмжлэг туслалцаа , хохирогчийн хохирлыг барагдуулах сан үгүйлэгдсээр байна.

Аливаа нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдлээс баттай хамгаалагдсан байх явдал юм.

Нэг ч хүн хохирохгүй байх нөхцлийг бүрдүүлсэн улс орны туршлага хаа ч байхгүй бөгөөд байх ч боломжгүй. Гэхдээ л иргэдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг тасралтгүй үр ашигтай явуулах, нэгэнт хохирсон тохиолдолд түүний хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх эрх зүйн тогтолцоо, үйл ажиллагааны зохистой нөхцлийг цогцоор нь бүрдүүлэх явдал нь аль ч улс орны хувьд нэн чухал байдаг байна.

Цагдаагийн ерөнхий газар

- Сүүлийн 7 жилийн дунджаар жил тутам 21260 гэмт хэрэг Цагдаад бүртгэгдэж 20573 хүн Эрүүгийн гэмт хэргийн хохирогч болжээ. Хохирогчдын 7196 буюу 35.0 хувь нь эмэгтэйчүүд, 1174 буюу 5.7 хувь нь хүүхдүүд байна (хүснэгт 3.1.2).
- 2012 оны байдлаар Монгол Улсын 10000 хүн тутмаас 74 нь гэмт хэргийн хохирогч болсон бол 2013 онд 85 болж, 11 хүн буюу 12.9 хувиар нэмэгдсэн байна. Харин 2012 онд 10000 хүн тутмын 28 нь эмэгтэй хохирогч, 4 нь 18 хүртэлх насны хохирогч хүүхэд байсан бол 2013 онд 10000 хүн тутмын 34 нь эмэгтэй хохирогч, 5 нь 18 хүртэлх насны хохирогч хүүхэд болж, 10000 хүнд ноогдох эмэгтэй хохирогчийн тоо 6-аар, 18 хүртэлх насны хүүхдийн тоо 1-ээр нэмэгдсэн байна.
- 2013 онд гэмт хэргийн улмаас хохирсон 10 хүн тутмын 5 нь 18-34 насны залуучууд, 6 нь эрэгтэйчүүд, 3 нь ажилгүй иргэн байгаа нь өмнөх оны түвшингээс буураагүй байна.
- Сүүлийн 7 жилд хохирсон нийт иргэдийн 51.6-60.6 хувь нь Улаанбаатарынх, 6.0-8.6 хувь нь Зүүн бүсэд, 15.3-18.3 хувь нь Төвийн бүсэд, 11.3-13.1 хувь нь Хангайн бүсэд, 5.9-8.4 хувь нь Баруун бүсэд байна.
- 2013 оны эцсийн байдлаар нийт хохирогчдын 60.6 хувь нь Улаанбаатар хотод, 15.3 хувь нь Төвийн бүсэд, 12.2 хувь нь Хангайн бүсэд, 6.0 хувь нь Зүүн бүсэд, 5.9 хувь нь Баруун бүсэд байна. 2013 онд Төв, Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудаас хамгийн олон иргэн хохирсон бол Говь-Алтай, Говьсүмбэр аймагт хамгийн цөөн иргэн хохирсон байна. 2013 онд Улаанбаатар хотод 15029 иргэн хохирсны 14393 буюу 95.8 хувь нь төвийн 6 дүүрэгт гарсан байна.

Дүүргүүдээс Баянзүрх дүүрэгт хамгийн олон 3630 иргэн хохирсон нь 2013 онд улсын хэмжээнд хохирсон иргэдийн 14.5 хувийг эзэлж байна. Баянзүрх дүүргийн хохирсон иргэдийн 1047 буюу 28.8 хувь нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хохирогч, 1755 буюу 48.3 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч байна.

2007-2013 оны мэдээллээр гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн дүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь тасралтгүй өссөөр ирсэн байна. 2007-2009 онд Монгол Улсын 10000 хүн тутмаас 23 эмэгтэй гэмт хэргийн улмаас хохирч байсан бол 2010 онд 3-аар нэмэгдэж 26 болж, харин 2011 онд буураад, сүүлийн 2 жил дахин нэмэгдсээр байна.

2007-2010 онд Монгол Улсын 18 хүртэлх насны 10000 хүүхдийн 11-12 нь хохирогчоор бүртгүүлсэн бол 2011 оноос нэмэгдсээр 2013 онд Монгол Улсын 10000 хүүхэд тутмаас 15 хүүхэд хохирогчоор Цагдаагийн байгууллагад эдийн засаг, эд материалын хохирлоо барагдуулахаар бүртгүүлжээ.

2013 оны байдлаар хохирогч хүүхдийн 13.0 хувь нь 7 хүртэлх насны, 27.7 хувь нь 8-13 насны, 59.3 хувь нь 14-17 насны хүүхэд байна.

Гэмт хэргийн зүйл ангиар нь авч үзвэл хохирогч хүүхдүүдийн зонхилох хэсэг нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, Өмчлөх эрхийн эсрэг, Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг, Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг, Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирчээ.

2013 онд нийт хохирсон хүүхдүүдийн 27.9 хувь нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, 26.2 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг, 17.2 хувь нь ТХХАБАЖ-ын эсрэг, 14.2 хувь нь Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг, 7.2 хувь нь Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон байна. 2013 онд хохирсон хүүхдийн тоо 156 буюу 12.3 хувиар өсөхөд Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо өмнөх оныхоос 6.1 пункт, Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо 2.2 пунктээр өссөн нь голлон нөлөөлжээ.

Хохирогч иргэдийн 11012 буюу 44.0 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг, 33.1 хувь нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, 2293 буюу 9.2 хувь нь ТХХАБАЖ-ын эсрэг, 1927 буюу 7.7 хувь нь Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч байна.

Гэмт хэргийн улмаас 2013 онд 1 хохирогч иргэнд 6.4 сая төгрөгийн хохирол учирсан нь 2007 оныхоос 4.3 дахин, 2008 оныхоос 2.4 дахин, 2009 оныхоос 2.6 дахин, 2010 оныхоос 3.8 дахин, 2011 оныхоос 3.4 дахин, 2012 оныхоос 2.6 дахин нэмэгдсэн байна.

2012 онд нийт учирсан хохирлын 47.2 хувийг нөхөн төлүүлсэн бол 2013 онд нийт учирсан хохирлын 70 хувийг нөхөн төлүүлсэн байна. Энэ нь 2009 оныхоос 33.4 пункт, 2010 оныхоос 27.2 пункт, 2011 оныхоос 18.5 пункт, 2012 оныхоос 22.8 пунктээр өссөн хэдий ч бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, түүний хор хохиролтой харьцуулахад хангалттай үр дүн биш юм.

Хохирогч иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 2013 онд нийт хохирогч иргэдийн 38.5 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 30.4 хувийг дээд боловсролтой иргэд, 16.7 хувийг суурь боловсролтой иргэд эзэлж байна.

Эрүүгийн гэмт хэргийн улмаас сүүлийн 7 жилд нийт 8469 хүн амь насаа алдсаны 1990 буюу 23.5 хувь нь эмэгтэйчүүд, 665 буюу 7.9 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Жил тутам дундажаар 1210 хүн нас барсны 284 нь эмэгтэй, 95 нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. 2007-2008 онд жилд 1500-1600 иргэн гэмт хэргийн улмаас нас барж байсан бол сүүлийн жилүүдэд 900 орчим болж буурчээ.

Гэмт хэргийн улмаас 2013 онд 25015 хүн хохирсны 949 хүн буюу 3.8 хувь нь

- нас барсан, 9797 буюу 39.2 хувь нь гэмтсэн иргэд байна. Нас барсан иргэдийн тоо өмнөх оныхоос 48 буюу 5.3 хувиар нэмэгдэхэд Архангай, Төв, Дундговь, Говьсүмбэр, Булган аймгуудад өмнөх оныхоос өссөн нь голлон нөлөөлжээ.
- Сүүлийн 7 жилд гэмт хэргийн улмаас нас барсан хүмүүсийн 5619 буюу 66.3 хувь нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, 2455 буюу 29.0 хувь нь Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алджээ.
 - Эрүүгийн гэмт хэргийн улмаас сүүлийн 7 жилд нийт 59267 хүн гэмтсэний 20154 буюу 34.1 хувь нь эмэгтэйчүүд, 4603 буюу 7.8 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Жил тутам дунджаар 8467 хүн гэмтсний 2879 нь эмэгтэй, 658 нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна.
